МОНГОЛ БАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2010 оны 05 сарын 26 өдөр Дугаар 311 Улаанбаатар хот

Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйл, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Монголбанкны Захирлуудын зөвлөлийн 2009 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 14 тоот протоколыг үндэслэн ТУШААХ нь:

1.Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 594 дүгээр тушаалаар батлагдсан "Банкны зохистой удирдлагын зарчмыг хэрэгжүүлэх журам"-ын нэрийг "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам" гэж өөрчилсүгэй.

2.Энэ тушаалын 1 дэх хэсэгтэй холбогдуулан "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам"-д буй "банкны зохистой удирдлага" гэсэн үгийг "банкны зохистой засаглал" гэж өөрчилсүгэй.

3.Дээр дурьдсан журамд дараах нэмэлтийг хавсралтаар оруулсугай:

а)"Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журмыг хэрэглэх зөвлөмж"-ийг 1 дүгээр хавсралт;

б)"Мэдээллийн технологийн хяналт шалгалтын зөвлөмж"-ийг 2 дугаар хавсралт;

в)"Банкуудын зохистой удирдлагын хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний загвар", "Мэдээллийн технологийн хяналт шалгалтын удирдамж"-ийг 3, 4 дүгээр хавсралт.

4.Энэ тушаалын 2 дахь хэсгийн "а" заалтаар баталсан зөвлөмжийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 594 дүгээр тушаалаар батлагдсан "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам"-ын хавсралт гэж, энэ тушаалын 2 дахь хэсгийн "в"-д заасан хавсралтуудыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 444 дүгээр тушаалаар батлагдсан "Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь иж бүрэн шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журам"-ын IX, X хавсралтад тус тус тооцсугай.

5.Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 444 дүгээр тушаалаар батлагдсан "Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь иж бүрэн шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журам"-д дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай:

а)журмын 17 дахь заалтыг "Хянан шалгагч нь банкны удирдлагын чадварыг энэхүү журмын IX хавсралтын дагуу үнэлнэ. Ингэхдээ асуулт тус бүр дээр маш сайнаас буюу 1-ээс муу хүртэл буюу 10-ын хооронд үнэлгээ өгч, тухайн хэсгийн нэгдсэн үнэлгээг гаргана."

14 0592

б)нэгдүгээр бүлэгт “7. Банкуудын мэдээллийн технологийн хяналт шалгалт нь удирдлагын чадварт өгөх дүгнэлтийн нэг хэсэг болох бөгөөд журмын X хавсралтын дагуу хийгдэнэ.”

в)журмын V хавсралтыг энэ тушаалын тавдугаар хавсралтаар, журмын VIII хавсралтыг энэ тушаалын зургаадугаар хавсралтаар.

6.Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 491 дүгээр тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой хагрьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам”-ын 8 дугаар бүлэгт дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай:

а)“8.3. Банк нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 444 дүгээр тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь иж бүрэн шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журам”-ын IX хавсралтын дагуу банкныхаа зохистой засаглалын дотоод үнэлгээг хагас жил тутам хийж, дараа сарын 5-ны өдрийн дотор Монголбанкинд албан бичгээр болон файлаар ирүүлнэ.” гэсэн заалт нэмэх;

б)“8.3.” дахь заалтыг “8.4.” гэж өөрчлөх.

7.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Г.Тогтохбаатар)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Л.ПҮРЭВДОРЖ

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 5 дугаар сарын 26.-ны өдрийн ....311..... дугаар тушаалын 1 дүгээр хавсралт (Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журмын хавсралт)

УХИ0014

Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журмыг хэрэглэх зөвлөмж

ӨМНӨТГӨЛ

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын зохистой засаглалыг журамлах зорилгоор "Банкны зохистой засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх журам"-ыг (цаашид журам) 2006 оны 12 дугаар сард Монголбанкнаас батлан гаргасан бөгөөд энэхүү журмын хэрэгжилтийг хангах, зарим заалт, ойлголтыг тодорхой болгох болон банкны зохистой засаглалыг сайжруулах зорилгоор Монголбанкнаас журмын тайлбар бүхий зөвлөмжийг боловсруулаа.

Банк нь нийгмийн дэд бүтэц, эдийн засгийг бүрдүүлэгч гол салбаруудын нэг юм. Банкны салбар дахь зохистой засаглалыг сайжруулснаар үндэсний эдийн засгийн хөгжилд эерэгээр нөлөөлөхөөс гадна хадгаламж эзэмшигчдийг тогтвортой, аюулгүй орчинд хөрөнгөө хадгалуулах боломжийг бий болгоно. Түүнчлэн, банкны салбарт оновчтой зохистой засаглалыг бүрдүүлснээр тухайн улс дахь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангахад нөлөөлдөг.

Зохистой засаглалыг банкуудад хэрэгжүүлэх, түүнийг олон улсын хэмжээнд хүргэх нь гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, үндэсний эдийн засгийн өсөлтийг хангах, эцсийн үр дүнд иргэдэд оногдох баялгийн хэмжээг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

I. ЕРӨНХИЙ УХАГДАХУУН

(1) Ил тод байдал

Банкны үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх нь зохистой засаглалын үр ашигтай хэрэгжүүлэлтийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Банкны салбарт одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа ихэнх банк гэр бүлийн хүрээний буюу эсхүл цөөн тооны хувь нийлүүлэгчтэй байгаа бөгөөд цаашид нээлттэй хэлбэрээр зохион байгуулагдсан банкууд бий болох нь дамжиггүй. Нээлттэй хэлбэр бүхий компанитай харьцуулахад хаалттай бүтэцтэй банкны нийтэд ил тод болгох шаардлагатай мэдээлэл нь харьцангуй цөөн байдаг. Банк нь нийгмийн голлох дэд бүтцийг бүрдүүлэхээс гадна, банкны харилцагчид, ялангуяа хадгаламж эзэмшигчид нь банкны хөрөнгө оруулагчид болдог учраас тэдгээрийн эрх ашгийг хамгаалах үндсэн үүргээ биелүүлэх үүднээс банк нь ил тод байдлаа сайжруулах шаардлага урган гарна.

Банкны ил тод байдлыг сайжруулах нь харилцагчдын эрх ашгийг хамгаалахад эерэгээр нөлөөлөөд зогсохгүй банкны талаар зохистой мэдээллийг тохиромжтой хугацаанд олон нийтэд мэдээлснээр банкны удирдлагын үйл ажиллагааг бэхжүүлэх ач холбогдолтой. Банкны ил тод байдлыг хангах хүрээнд мэдээллийг нээлттэй болгохоос гадна, банкны үйл ажиллагаанд бие даасан этгээдээс тавих хяналт, тэдгээрийн санал дүгнэлтийг хэрэгжүүлэх нь чухал байдаг. Хараат бус этгээдийн санал дүгнэлт нь ялангуяа нэг хэв маягаар ажиллаж

заншсан хаалттай бүтэцтэй банкны удирдлагын санаа бодлыг өөрчлөн сайжруулах давуу талтай. Түүнчлэн энэ төрлийн арга хэмжээг тогтмол авах нь хадгаламж эзэмшигчдийн банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

Банк нь ил тод байдлыг хангах асуудлыг гаднаас үзүүлж буй дарамт мэтээр үзэхээс илүүтэйгээр банкны ил тод байдлыг сайжруулах нааштай талаас харах нь зүйтэй юм.

(2) Шалгалт, эрх мэдлийн тэнцвэртэй байдлыг хангах

Хувь нийлүүлэгчдийн бүтцийн ил тод байдал хангалтгүй, хяналтын багцыг эзэмшигч хувь нийлүүлэгчид эсвэл банкны ажилчдын хийсэн хууль бус үйл ажиллагаа нь банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэхэд шаардлагатай хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх нэгжийн эрх мэдлийн тэнцвэртэй байдлыг хангадаггүй банкны хувьд зохистой засаглалыг сайжруулахад хүндрэл учирдаг. Иймд банкинд тулгарах дээрх асуудлаас зайлсхийх үүднээс зохистой хяналт болон эрх мэдлийн тэнцвэрийг хангах тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх шаардлагатай.

Банкны эрх мэдлийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор үндсэн 4 төрлийн шалгалт хийх ёстой. Үүнд: (1) *Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ) болон Хяналтын зөвлөлөөс хийгдэх шалгалт,* (2) *Банкны бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдоггүй бие даасан этгээдээр хийлгэх шалгалт,* (3) *Банкны үйл ажиллагаанд газар дээр нь хяналт шалгалт хийх,* (4) *Хараат бус эрсдэлийн удирдлага, хууль журмын хэрэгжилт, аудитын үйл ажиллагаа.* Үүнээс гадна тухайн ажлын байранд тавигдах шаардлагуудыг хангасан боловсон хүчнийг томилон ажиллуулах шаардлагатай юм. Одоогоор мөрдөгдөж буй Компанийн тухай хуульд зааснаар хяналтын зөвлөлийг хувьцаат компани (ХК) хэлбэрээр байгуулагдсан аж ахуйн нэгжийн хувьд байгуулах шаардлагатай байдаг. Харин хязгаарлагдмал хариуцлагатай компанийн (ХХК) хувьд хяналтын зөвлөлийг байгуулах шаардлагагүй боловч ТУЗ болон хувь нийлүүлэгчдийн эрх мэдлийг тэнцвэржүүлэх зорилгоор үүнийг сайн дурын үндсэн дээр байгуулан ажиллуулбал зохино.

(3) Зохистой засаглалын мөчлөг (Төлөвлөх-Хэрэгжүүлэх-Шалгах-Арга хэмжээ авах мөчлөг)

Банкны зохистой засаглалыг шаардлагатай дүрэм, журмыг боловсруулан, удирдлага зохион байгуулалтыг тодорхойлсноор бүрэн хангана гэдэг нь өрөөсгөл ойлголт бөгөөд дүрэм, журам болон бусад акт нь бодит байдал дээр үр ашигтайгаар хэрэгжиж байх шаардлагатай. Дээрх арга хэмжээ нь зохистой засаглалын хэрэгжилтийн мөчлөгийн зөвхөн эхний шат буюу төлөвлөх үе шат (*Төлөвлөх үе шат -Т*) болдог. Боловсруулсан баримт бичгүүд нь банкинд бодитойгоор хэрэгжиж байх шаардлагатай (*Хэрэгжилтийн үе шат - Х*) бөгөөд үр ашигтайгаар хэрэгжиж байгаа эсэх дээр зохих хяналтыг (*Шалгалтын үе шат -Ш*) тавих нь зүйтэй байдаг. Хэрэгжилтийн үйл явц үр ашигтай эсэхэд шалгалт хийсний үндсэн дээр цаашид сайжруулах шаардлагатай арга хэмжээ (*Арга хэмжээ авах үе шат -А*)-г авч зохистой засаглалын хэрэгжилтийг сайжруулах үйл явцыг үргэлжлүүлдэг. Иймд ТХША мөчлөгийн үе шат бүрийг хэрэгжүүлэх нь банкны зохистой удидлагыг тогтмол хангах, сайжруулах ач холбогдолтой байдаг бөгөөд энэ талаар тус зөвлөмжийн холбогдох тайлбарт тусгагдсан болно.

(4) Зохистой засаглалыг цаашид сайжруулах арга хэмжээг тогтмол авч байх шаардлагатай

Хэдийгээр банкны зохистой засаглалын хэрэгжилт тогтмол сайжирч байгаа ч энэ нь банкны хувьд эцсийн зорилго байх ёсгүй юм. Учир нь улс орны нийгэм, эдийн засгийн орчин байнга өөрчлөгдөж байдагтай холбоотойгоор банкны үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд ч дээрх өөрчлөлтөд оновчтойгоор зохицож байх шаардлага тулгардаг. Түүнчлэн банкинд ажиллаж буй, нийгэм соёлын харилцан адилгүй үнэт зүйлс, үзэл бодолтой ажилтнуудыг нэг хэвийн, тогтмол системээр хянах, удирдах боломжгүй. Иймд, банкны ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь одоо мөрдөгдөж буй зохистой засаглалын тогтолцоонд сэтгэл тайвшрах бус, харин банкинд тулгарах аливаа асуудал, тулгарч болох эрсдэлийн талаар байнга мэдээлэлтэй байж, хүндрэлийг арилгах талаар тогтмол арга хэмжээ авч байх нь зүйтэй.

(5) Зохистой засаглалтай холбоотой, мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэглээ

Хууль тогтоомжийн дагуу хувь нийлүүлэгчдийн хурал нь компанийн хувьд удирдах дээд эрх мэдэл бүхий нэгж мөн. Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийг хувь нийлүүлэгчдийн хурлаар сонгон шалгаруулж томилдог бол компанийн өдөр тутмын удирдлагын үйл ажиллагааг хариуцах үүрэг бүхий гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөс томилдог. Нөгөө талаар, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллгааг хянах зорилгоор хяналтын зөвлөл, гадны аудит болон аудитын хороог томилон ажиллуулдаг. Иймд байгууллагын зохистой засаглалын хэрэгжилтийг хангахын тулд тухайн албан тушаалд ногдох эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлага болон ТУЗ, гүйцэтгэх удирдлагын ач холбогдолын талаар хууль тогтоомжид дэлгэрэнгүй заасан байх шаардлагатай.

Хэдийгээр дээр дурьдсан албан тушаалын эрх үүрэг, хариуцлага, ач холбогдолын талаар Компанийн тухай хуулийн холбогдох хэсэгт заасан боловч утга санаа нь ерөнхий, тохиромжтой бус байна. Түүнчлэн Банкны тухай хууль нь банкны үйл ажиллагааны талаарх харилцааг зохицуулдаг боловч банкуудын зохистой засаглалын талаар авах арга хэмжээ, нөхцлийн талаар дэлгэрэнгүй заагаагүйгээс банкуудын зүгээс зохистой засаглалыг хангах, сайжруулахад хүндрэл учруулах талтай.

II.ЖУРМЫН ТАЙЛБАР

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1.Банкны Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/ болон гүйцэтгэх шатны удирдлагын үйл ажиллагааг банкны хувь нийлүүлэгч болон бусад сонирхол нэгтэй этгээдийн эрх ашигт нийцүүлэх, улмаар банкны зохистой засаглалын тогтолцоог боловсронгуй болгоход энэхүү журмын зорилго оршино.

Өмнөх хэсэгт дурьдсанчлан, ТУЗ нь компанийн хувьд удирдах дээд шатны байгууллага бөгөөд хувь нийлүүлэгчдийн хурлаас сонгогдсон ТУЗ-ийн гишүүд нь ихэнхдээ банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдах үүргийг давхар гүйцэтгэж байна. Энэ тохиолдолд ТУЗ-ийн зүгээс зохистой засаглалын хүрээнд банкны өмнө хүлээх үүрэг өөрчлөгдөх бөгөөд энэ талаар сайтар ухамсарласан байх шаардлагатай юм.

Дээрх нөхцөл байдал болон одоо мөрдөгдөж буй журамд зааснаар зохистой засаглалын талаар авах арга хэмжээг банкны ТУЗ, гүйцэтгэх удирдлага, холбогдох бусад байгууллага болон хувь нийлүүлэгчдийн хооронд үүсэх харилцаанд тулгуурлан тайлбарласан. Үүнээс

гадна, банкны харилцагчидтай холбоотой асуудлыг тусгах шаардлагатай боловч банкны харилцагчийн тодорхойлолтод хадгаламж эзэмшигч, ажилтан, зээлдэгчид, хяналт шалгалтын байгууллагууд (Монголбанк) зэрэг оролцогчдыг хамруулах шаардлагатай. Эдгээрээс, Монголын нөхцөлд ялангуяа хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах асуудалд голчлон анхаарлаа хандуулах нь зохистой.

1.2.Банкны зохистой засаглал /цаашид БЗЗ гэх/-ыг хэрэгжүүлэхдээ Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

Зохистой засаглалын журмыг боловсруулахдаа банк нь мөрдөгдөж буй хууль тогтоомжийг чандлан сахиж ажиллана гэсэн таамаглалд тулгуурласан байдаг. Банкны хууль тогтоомж Монголбанкны цахим хуудсанд байршсаныг татан авч танилцах боломжтой боловч, банкны зүгээс дээрх эрх зүйн баримт бичгийн хууль зүйн зорилгыг сайтар ойлгох, дээрх хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орох, шинээр хууль, журам батлагдах тухай бүрт зохих өөрчлөлтийг байгууллага дотроо сургалт семинарыг тогтмол явуулах замаар танилцуулах шаардлагатай.

Хэдийгээр зохистой засаглалыг сайжруулах нь банкны эцсийн зорилго биш боловч цаашид мөрдөгдөж буй хууль, журамд баригдалгүйгээр зохистой засаглалын хэрэгжилтийг бэхжүүлэн, чангатгах эрмэлзэлтэй байх нь чухал юм.

ХОЁР. ҮНДСЭН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

2.1.”БЗЗ„ гэж банкны гүйцэтгэх шатны удирдлага, ТУЗ, хувь нийлүүлэгчид болон бусад сонирхол нэгтэй хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг хэлнэ. Уг харилцаа нь банкны эрхэм зорилго болон хэтийн зорилтыг тогтоох, тэдгээрт хүрэх, үр дүнг эргэн тооцож, хяналт тавих арга замыг тодорхойлно.

2.2.БЗЗ нь дараахь үндсэн хэсгээс бүрдэнэ:

2.2.1. Зохистой хэлбэрээр тодорхойлсон банкны хэтийн стратеги төлөвлөгөө. Уг стратеги төлөвлөгөөний бүтэц, хэлбэр нь банкны үйл ажиллагааны үр дүн болон түүнд банкны ажилтан бүрийн оруулсан хувь нэмэр зэргийг тооцох бололцоог бүрдүүлсэн байна;

Банкны зохистой засаглалыг сайжруулахад оновчтой байдлаар банкны хэтийн стратеги төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай бөгөөд юуны түрүүнд банкны удирдлагын алсын хараа, эрхэм зорилгыг нарийн тодорхойлно. Боловсруулсан урт хугацааны стратеги төлөвлөгөөг цаашид банкны үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэлийн үр дүнг хэмжих шалгуур болгон ашиглана. Түүнчлэн банкны эрхэм зорилгын хэрэгжилт, ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх тогтолцоог бүрдүүлэх, үнэлгээний үр дүнг банкны удирдлага болон банкны нийт ажилчдад тогтмол танилцуулж хэвших нь чухал юм.

Хэтийн стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа хэмжигдэх боломжийг нь харгалзан тоон үзүүлэлтүүд, ялангуяа санхүүгийн харьцааг ашиглан зорилгоо тодорхойлох нь тохиромжтой байдаг. Нөгөө талаас, банкны нийгэмд оруулсан хувь нэмэр, байгаль орчныг хамгаалах болон харилцагчдын сэтгэл ханамжийн талаар тавьсан зорилтын хэрэгжилтийг

тоон үзүүлэлтээс илүүтэйгээр чанарын үзүүлэлтээр хэмжих нь тохиромжтой бөгөөд оновчтой үнэлгээний аргыг боловсруулан ашиглах шаардлагатай.

2.2.2. Банкны эрсдэлийн ерөнхий түвшинд нийцсэн удирдлага, хяналтын тогтолцоо. Уг тогтолцоо нь банкны ажилтнуудын эрх үүрэг, шийдвэр гаргах эрх мэдэл болон хариуцлага тооцох арга зам зэргийг нарийвчлан тогтоосон байна;

Банкны ажилтнуудын ажил үүргийн гүйцэтгэлд мэргэжлийн үнэлгээ, дүгнэлт өгөх болон ажилтнуудын зүгээс хууль бус үйлдэл гаргасан үед тохирох арга хэмжээг авах тогтолцооны зохистой хэлбэрийг сонгон авч хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ тогтолцоо нь банкны ажилтнуудыг ажил үүргээ гүйцэтгэхэд удирдлагын зүгээс саад учруулахгүй, эсвэл удирдлагын зохисгүй оролцоонд эсэргүүцэл үзүүлсэн ажилтнуудын эрх ашгийг хамгаалах боломжийг олгодог байхуйц байвал зохино. Ажилтнуудын эрх ашгийг хамгаална гэдэг нь банкны удирдлагад эсэргүүцэл үзүүлснээр тухайн ажилтанд ялгавартайгаар хандахгүй байх баталгаа үзүүлэх арга хэмжээ юм. Нөгөө талаас энэ төрлийн тогтолцоо нь хууль бус үйлдэл хийсэн ажилтнуудад тохирох арга хэмжээ авах буюу *ёс зүйн гажуудал (moral hazard)*-ыг үүсгэхээс сэргийлэх ач холбогдолтой байдаг.

2.2.3. Эрсдэлийн удирдлагын нэгжүүдийг холбогдох бизнесийн нэгжүүдээс нь бие даасан хэлбэрээр зохион байгуулж, дотоод хяналтын механизмыг бүрдүүлсэн байна;

Банкинд эрх мэдлийн тэнцвэртэй байдлыг хангах, дотоод хяналтыг чангатгах зорилгоор бие даасан нэгжийг байгуулах шаардлагатай байдаг. Гэхдээ бие даасан нэгжийг байгуулахаас илүүтэйгээр дотоод хяналтын тогтолцоо нь банкинд бодитойгоор хэрэгжиж байх нь илүү чухал юм. Дотоод аудитын нэгжээс банкны салбар нэгжид хийх аудит нь хязгаарлагдмал, аудиторууд нь ажлын байран дээрээ байнга ажиллах боломжгүй тул зөвхөн дотоод аудитаас хийсэн шалгалтанд тулгуурлан зохистой засаглалыг хангах нь учир дутагдалтай. Түүнчлэн дотоод аудитын шалгалт нь банкинд өмнө нь бий болсон асуудлыг илрүүлэх зорилгоор хийгддэг учраас дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагыг тогтмол чангатгах (тухайлбал, давхар шалгах, ажил үүргийн хуваарийг давхардуулахгүй байх гм) нь цаашид банкинд үүсэх эрсдэл, хууль бус үйл ажиллагаанаас сэргийлэх ач холбогдолтой бөгөөд зохистой засаглалыг хангах үндэс болно.

Тухайлбал, банкны дотоод аудит болон эрсдэлийн удирдлагын нэгж нь банкны дотоод хяналтын тогтолцоонд байнга үнэлэлт, дүгнэлт өгч алдаатай, сул талуудыг залруулах, сайжруулах арга хэмжээг тогтмол авдаг банкны хувьд зохистой засаглалын түвшинг харьцангуй сайн байна гэж үздэг.

2.2.4. Банкны эрхэмлэх үнэт зүйлс болон ёс зүйн хэм хэмжээг тогтоож, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах тогтолцоог бүрдүүлсэн байх. Үүнд ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй гэрээ, хэлцэлд онцгой анхаарал хандуулна;

Банк нь хууль, журмын хэрэгжилтийг чандлан мөрдсөнөөр банкинд ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох гэрээ, хэлцэл, бизнесийн аливаа үйл ажиллагаанаас сэргийлэх боломжтой. Банкуудын хувьд аливаа ашиг сонирхлын зөрчил үүсч болох гэрээ хэлцлээс сэргийлэх зорилгоор тодорхой хяналт шалгалтын систем, аргачлалыг дотооддоо нэвтрүүлж, холбогдох ажилтныг томилон ажиллуулах нь олонтоо тохиолддог боловч тухайн ажилтны үнэт зүйлс, ёс зүйн хэм хэмжээ нь шаардлага хангахгүй үед хяналтын систем нь үр дүнгээ

өгч чадахгүйд хүрдэг. Иймд ажилтан бүр банкинд мөрдөгдөж буй ёс зүйн дүрэм болон бусад шаардлагатай дотоод журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа сайтар мөрдөх нь чухал бөгөөд банкны зүгээс ажилтнуудад сургалт семинар зохион байгуулах зэрэг арга хэмжээг авах замаар дээрх үүргийг хангах шаардлагатай.

Банкны зүгээс ашиг сонирхлын зөрчил үүссэнд тооцож буй гэрээ, хэлцлийн үйл явцыг нарийвчлан хянах тогтолцоог дотооддоо нэвтрүүлэх шаардлагатай. Харин ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлалтай гэж үзсэн бусад гэрээ, хэлцлийг банкнаас боловсруулсан дүрэм, журмын дагуу хянан зохицуулах, цаашид зохистой засаглалыг сайжруулах үүднээс дээрх асуудалд банкны ажилтнуудаас гадна, ТУЗ, гүйцэтгэх удирдлагууд анхаарлаа хандуулан ажиллах нь зүйтэй.

2.2.5. Банкны ТУЗ, гүйцэтгэх захирал болон ажиллагсдын хувьд эрх үүргээ зүй ёсоор биелүүлэхэд хөшүүрэг болох шагнал, урамшуулал олгох, шийтгэл ногдуулах зэрэг зүйлсийг тогтоосон байна. Шагнал урамшууллын хэлбэр хэмжээг банкны хэтийн зорилго, үйл ажиллагааны үр дүн болон ёс зүйн хэм хэмжээтэй уялдуулан тогтооно.

Банкны ТУЗ, гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад олгох шагнал урамшууллыг тооцохдоо ажлын гүйцэтгэл болон ёс зүйн хэм хэмжээний талаар ахиц гарсан гэж үзэх нотолгоонд үндэслэн тогтоох ба банкны хэтийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан бодлогыг харгалзана. Өнөөгийн нөхцөлд ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ банкны санхүүгийн үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлтөд үндэслэн шагнал, урамшууллын хэмжээг тодорхойлох нь олонтоо тохиолддог. Харин банкны зүгээс баримтлах үнэт зүйлс, ёс зүйн хэм хэмжээ доройтох нь харилцагчдын банкинд итгэх итгэлийг бууруулж урт хугацаанд санхүүгийн үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг дагуулдаг. Иймд банкинд тулгарч болох дээрх эрсдэлээс зайлсхийх үүднээс ажлын гүйцэтгэлийг үнэлэх стандарт, ёс зүйн хэм хэмжээг нарийвчлан тодорхойлж банкны ажилтнууд, гүйцэтгэх удирдлагад сайтар ойлгуулах нь чухал юм.

2.2.6.Мэдээллийн дотоод болон гадаад урсгалын нээлттэй байдлыг хангах

Банкны салбарын үйл ажиллагаа нь тухайн орны нийгэм эдийн засагт чухал нөлөө үзүүлдэг тул банкны талаарх мэдээллийн үнэн зөв байдалд анхаарал хандуулах шаардлагатай. Мэдээллийн гадаад урсгалын хувьд, банкнаас гаргаж буй мэдээллийн үнэн зөв байдлаас гадна мэдээллээ нээлттэй болгох тал дээр тохирох арга хэмжээ авдаггүй асуудлыг залруулах шаардлагатай. Нөгөөтэйгүүр, мэдээллийн дотоод урсгал буюу гадаад эх сурвалжаас банкинд ирүүлж буй мэдээлэлд тулгуурлан банкны зүгээс бизнесийн шийдвэр гаргадаг тул дээрх мэдээллийн үнэн зөв, нийцтэй байдалд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй. Банкны хүлээн авч буй мэдээлэл нь зөвхөн хүүгийн түвшин, зах зээлийн хандлага, мөнгөний нийлүүлэлт зэрэг тоон чанарын мэдээллүүд байхаас гадна хууль зүй, нийгмийн зэрэг чанарын мэдээллийг цуглуулан шинжилгээ, дүгнэлт хийх шаардлагатай. Ялангуяа өөрсдийн үйлчилгээний чанарт үнэлэлт, дүгнэлт өгөхийн тулд харилцагчдын сэтгэл ханамжийн талаарх мэдээллийг цуглуулах нь чухал бөгөөд ингэснээр цаашид шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, одоо үзүүлж буй үйлчилгээгээ сайжруулахад эерэг нөлөөг үзүүлнэ.

ГУРАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1.ТУЗ нь банкны үйл ажиллагаа болон санхүүгийн тогтвортой байдлын талаар хариуцлага хүлээх үндсэн нэгж байна.

ТУЗ-ийг банкны хувь нийлүүлэгчдийн хурлаас томилох бөгөөд банкны удирдлагын үйл ажиллагааны талаар хүлээх эрх, үүрэг, хариуцлагаа ухамсарлан ажиллана. ТУЗ нь банкны баримтлах хэтийн стратеги төлөвлөгөөг боловсруулан төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотойгоор удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавина.

Одоогоор үйл ажиллагаа явуулж буй ихэнх банк хаалттай бүтэцтэй бөгөөд нэг эсвэл цөөн тооны хувь нийлүүлэгчтэй байна. Энэ төрлийн удирдлагын бүтэц нь богино хугацаанд зохистой засаглалыг хангахад төдийлэн хүндрэл учруулдаггүй боловч бусад улсуудын жишээнээс харахад гэр бүлийн эсвэл цөөн тооны иргэд, хуулийн этгээдээс бүрдсэн хувь нийлүүлэгчидтэй банкуудад дараах асуудал тулгарах нь элбэг бөгөөд Монголд ч тохиолдох боломжтой. Үүнд:

- Үүсгэн байгуулагч гэр бүлээс банкийг урт хугацаанд удирдах
- Удирдлагын зүгээс хэт их дарамт үзүүлэх (автократ)
- Цөөн тооны зээлдэгчдэд их хэмжээний зээл олгож занших

Дээрх асуудлуудтай тулгарахаас зайлсхийхийн тулд банкны ТУЗ, аудитын хорооны бүрэлдэхүүнд гадны хараат бус гишүүнийг оруулах нь зүйтэй бөгөөд ингэснээр банкны удирдлагын үйл ажиллагааг буруу чиглүүлэхээс сэргийлнэ.

3.2.ТУЗ-ийн гишүүдийн тоо, мэргэжлийн ур чадвар болон хувийн зан чанар нь банкны үйл ажиллагааны стратегийн ач холбогдол бүхий асуудлыг хараат бус байдлаар шийдвэрлэх бололцоог бүрдүүлнэ.

Банкны ТУЗ-ийн бүрэлдэхүүнд ажиллах гишүүдийн тоо нь зохистой байх бөгөөд бүрэлдэхүүнийг гүйцэтгэх удирдлагын үзэл бодлоос ангид түүнчлэн улс төр, бусад зохисгүй ашиг сонирхлын нөлөөнд үл автан бие даан шийдвэр гаргах чадвар бүхий гишүүдээс бүрдүүлнэ. Түүнчлэн ТУЗ нь банкны нийтлэг ашиг сонирхолд харшлах, хохирол учруулж болзошгүй томоохон хувь нийлүүлэгчдийн зохисгүй үйлдэл болон нөлөөнөөс сэргийлэх үүргийг давхар хүлээдэг. ТУЗ-ийн үйл ажиллагааны шударга, хараат бус байдлыг хангах үүднээс хараат бус гишүүнийг сонгон ажиллуулах эсвэл ТУЗ-ийн дэргэдэх хяналтын зөвлөлийг байгуулан ажиллуулах нь тохиромжтой байдаг. Энэ төрлийн арга хэмжээ нь ТУЗ-ийн шийдвэр гаргалтад улс төрийн болон гүйцэтгэх удирдлагын зүгээс хэт давамгай нөлөө үзүүлэх, дээрх нөлөө нь банкны нийтлэг эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсвэл ажил үүргийн хуваарийн аль нэг хэсэгт ноцтой ашиг сонирхлын зөрчил үүсэх боломжтой банкны хувьд нэн чухал юм. Ажил үүргийн хуваарьт үүсэх ашиг сонирхлын зөрчил гэдэгт санхүүгийн болон санхүүгийн бус тайлангийн найдвартай байдлыг хангах, холбогдох этгээдтэй хийх арилжаа, гүйлгээнд хяналт тавих, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад ажиллах хүмүүсийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, холбогдох шагнал урамшууллын асуудал шийдвэрлэх зэрэг асуудàл багтана. Дээр дурьдсан эрсдэл Монголын банкны салбарт үүсэх магадлал èð áàéíà. Иймд шаардлагатай мэдлэг чадвар бүхий хараат бус этгээдийг гүйцэтгэх удирдлагад томилон ажиллуулах нь банкийг хэтийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөв чиглэлд хандуулах, банкинд тулгараад буй нөхцөл байдалтай нарийвчлан танилцах,

шаардлагатай мэдлэг чадварыг тохирох цаг үед үр ашигтайгаар ашиглах ач холбогдолтой юм.

ТУЗ-ийн бүрэлдэхүүний 1/3-ээс багагүй хувийг хараат бус гишүүдээс бүрдүүлэх нь тохиромжтой бөгөөд хараат бус гишүүд нь банкны удирдлагын үйл ажиллагаа хянах хангалттай мэдлэг туршлагатай, үнэнч шударга байх нь чухал байдаг.

ТУЗ-ийн гишүүдийн хараат бус байдал нь банкны удирдлага болон бусад таагүй гадны нөлөөнд авталгүйгээр, шаардлагатай гэж үзсэн бүх мэдээлэлтэй нарийвчлан танилцсаны үндсэн дээр шударга, оновчтой шийдвэр гаргаж байгаагаар илэрдэг. Банкны тухай (øинэчилсэн найруулга) хуулийн 33 дугаар зүйлд ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавих шаардлагыг нарийвчлан зааж өгсөн.

ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлыг хангах нь чухал бөгөөд юуны түрүүнд ТУЗ-ийн гишүүдийг сонгох журам, сонгогдож буй гишүүдийн ажлын туршлага, боловсролын талаарх мэдээлэл, гишүүдэд тавигдах шалгуур болон холбогдох бусад мэдээллийг нээлттэй болговол зохино.

Банкны үйл ажиллагаа болон хэтийн төлөвтэй холбоотой шийдвэрүүдийг банкны ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэдэг учраас ТУЗ-ийн бүх гишүүдийг хуралд хэлэлцэгдэх асуудал, агуулгын талаар урьдаас мэдээллээр хангаж, бүх гишүүдийн ирцийг хангах зорилгоор хурлын товыг тохиромжтой хугацаанд зарлах нь зүйтэй. Түүнчлэн, ТУЗ-ийн хурлын ирцийн талаарх мэдээллийг нийтэд нээлттэй болгох нь ТУЗ-ийн ил тод байдлыг хангахад эерэгээр нөлөөлөх, хурал нь үр ашигтай явагдаж байгааг харуулах ач холбогдолтой.

3.3.ТУЗ нь БЗУ-г бэхжүүлэх үүднээс дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1.Банкны стратеги төлөвлөгөөг батлах. Үүнд банкны үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, хяналттай холбоотой бодлогын шинж чанартай баримт бичиг, дүрэм, журам, заавар, зөвлөмж хамаарна;

Дээрх асуудал (*журмын 3.3*)-ын талаар буюу стратеги төлөвлөгөөний төслийг гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн аливаа гишүүнээс оруулах саналыг тусгаж, ТУЗ-ийн хурлаар сайтар танилцаж, үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр батлах эсэх талаар шийдвэрийг гаргана. Дээрх баримт бичгийг гүйцэтгэх удирдлагаас боловсруулж буй үед удирдлагын бүрэлдэхүүнд алба хашиж буй хүн бүр дээрх бичигтэй сайтар танилцах хэрэгтэй бөгөөд энэ нь цаашид албан үүргээ хариуцлагатайгаар гүйцэтгэхэд дөхөм болдог. Ìºí гүйцэтгэх удирдлагад ажиллаж буй этгээдийг ажил үүргээ гүйцэтгэхэд туршлага, чадвар дутах тохиолдолд тэдэнд техникийн туслалцаа үзүүлэх (*тухайлбал, шаардлагатай сургалтад хамрагдахаас гадна, гадны мэргэжилтнүүдээс туслалцаа авах*) байдлаар дээрх дутагдлуудыг орлуулах оновчтой тогтолцоог бүрдүүлэн ажиллах нь тохиромжтой. Ялангуяа банкнаас боловсруулсан дүрэм, журам нь хууль òîãòîîìæòîé çөрчилдөж байгаа талаар мэргэжлийн хуульчаас туслалцаа авах нь олонтоо тохиолддог.

3.3.2.Ашиг сонирхлын зөрчлийн улмаас банкны өмнө хүлээсэн эрх үүргээ зүй ёсоор хэрэгжүүлэхэд саад тотгор үзүүлэх үйлдэл (эс үйлдэл) гаргахгүй байх;

ТУЗ-ийн гишүүнтэй холбоотой үүсэх ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж санал хураахад ашиг сонирхлын зөрчилтэй гишүүнийг санал хураалтад

оролцуулахгүй байх нь зүйтэй бөгөөд ашиг сонирхлын зөрчлийн талаарх асуудал нь зөвхөн ТУЗ-ийн гишүүдээр хязгаарлагдахгүй. Тухайлбал, доорх ашиг сонирхлын зөрчил үүсч болох асуудàлд банк болон ТУЗ-ийн зүгээс анхаарал хандуулах шаардлагатай. Үүнд:

- Банкны эдийн засагч, ажилтнууд, удирдах албан тушаалтан болон хяналтын багцыг эзэмшигч нарт зээл олгох,
- Банкны удирдах албан тушаалтны эзэмшдэг компанитай бизнесийн харилцаанд орох,
- Банк нь групп/нэгдэл компанид хамаарагддаг тохиолдолд толгой болон охин компаниудтай бизнесийн харилцаанд орох.

Банк болон холбогдох этгээдүүд, ялангуяа хувь нийлүүлэгчид, удирдах албан тушаалтнууд, ТУЗ-ийн гишүүд, холбоотой хуулийн этгээдийн хооронд хийгдэх гэрээ, хэлцлийг банкны болон хадгаламж эзэмшигчдийн нийтлэг эрх ашгийг зөрчихгүйгээр, *Хараат бус байдлын (arm's length)* дүрэмд үндэслэн хийх шаардлагатай байдаг. *Хараат бус байдлын дүрэм*-ийн дагуу холбоотой талуудын хооронд хийгдэж буй гүйлгээний үнийг хараат бус талуудын хооронд хийгдэх гүйлгээний үнэтэй адилаар тогтоодог.

3.3.3.Банкны гүйцэтгэх захирлыг Банкны хуульд заасан шаардлагыг хангасан хүмүүсээс сонгон шалгаруулж, ажилд томилох, шаардлагатай бол ажлаас чөлөөлөх;

Банкны тухай хуульд гүйцэтгэх захиралд тавигдах шаардлагуудыг тусгасан боловч банкны үйл ажиллагааны цар хүрээ өргөжих, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл нэмэгдэхийн хирээр удирдах албан тушаалтнуудын мэргэжлийн түвшинг дээшлүүлэх шаардлагатай болдог.

ТУЗ нь банкны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чадвартай этгээдийг банкны гүйцэтгэх удирдлагад сонгох, томилох, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд ажлаас нь чөлөөлж мэргэжлийн шалгуур хангасан, банкны үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн тогтвортой удирдах этгээдийг шинэчлэн томилох үүрэг хүлээнэ. Нөгөө талаас ТУЗ нь банкинд хэрэгжиж буй удирдлагын тогтолцоо нь үр дүнтэй эсэх талаар үнэлэлт өгөх, ялангуяа ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, сонирхлын зөрчилтэй асуудлуудыг зохицуулах, банкны үйл ажиллагааны сул талыг тогтоох, залруулах талаар арга хэмжээг авах шаардлагатай.

3.3.4.Банкны гүйцэтгэх захирал болон бусад шийдвэр гаргах шатны удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, ажлын үр дүнгийн тайланг тодорхой цаг хугацааны давтамжтайгаар авч хэлэлцэх, шаардлагатай гэж үзсэн асуудлаар тайлбар гаргуулан авах. Шаардлагатай гэж үзсэн асуудалд дараахь зүйл хамаарна:

ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавихдаа тэдний боловсруулсан тайлантай танилцахаас гадна бодит байдал дээр гүйцэтгэх удирдлагын ажил үүргийн биелэлт, хууль òîãòîîìæèéí хэрэгжилт болон эрсдэлийн удирдлагын өнөөгийн байдлын талаар сайтар танилцаж, тайланд шаардлагатай мэдээллийг тодорхой тусгаагүй гэж үзвэл нэмж тусгуулах талаар арга хэмжээ авах нь зүйтэй. Үүнээс гадна гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй дотоод аудитын нэгж, ажилтнаас нэмэлт тайланг гаргуулж танилцах, шаардлагатай тохиолдолд тавих хяналтыг чангатгах арга хэмжээг авна.

3.3.4.1.Холбогдох хууль тогтоомжид заасан зохистой харьцаа, хязгаарлалтыг зөрчин хийсэн ажил гүйлгээ,

3.3.4.2.Банкны хяналтын багцыг эзэмшдэг хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтан болон тэдгээрийн холбогдох этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцэл, үүнтэй холбоотойгоор үүссэн эрсдэл,

Одоогийн байдлаар томоохон хувь нийлүүлэгчтэй, хаалттай бүтэцтэй хэд хэдэн банк үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд банкны зүгээс дээрх хувь нийлүүлэгч эсвэл хувь нийлүүлэгчдийн эзэмшлийн компаниудтай гэрээ, хэлцэл байгуулах нь өндөр эрсдэлийг дагуулдаг. Үүний адилаар банкны зүгээс ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагад ажиллах этгээдүүдтэй гэрээ байгуулах нь мөн адил эрсдэл үүсгэíэ. ТУЗ-ийн зүгээс дээрх гэрээ хэлцýё *Хараат бус байдлын дүрм*ийн дагуу хийлгэх нь зүйтэй бөгөөд банкинд хохирол учруулахаар хууль бус гэрээ хэлöýё хийсэн гэж үзвэл эрсдэл, алдаа дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авах шаардлагатай.

3.3.4.3.Банкны санхүүгийн тогтвортой байдалд ноцтой нөлөө үзүүлэх ажил гүйлгээ.

Банкинд үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах бүрт эрсдэл дагалддаг тул ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь дээрх эрсдэлүүдийн банкинд бий болгох хохирол, үзүүлэх нөлөөнд үндэслэн хооронд нь эрэмбэлэх шаардлагатай тохиолдолд эрсдэлээс хамгаалах арга хэмжээг авах нь зүйтэй. Иймд банкинд ноцтой эрсдэл учруулах магадлал өндөртэй, холбогдон гарах эрсдэлийг удирдах боломж багатай гүйлгээ, арилжаанд банкны зүгээс онцгой анхаарал хандуулах шаардлагатай юм.

Алдагдалд орсон зарим банкуудын жишээнээс харахад, цөөн тооны ажилòíû чадварт хэт найдах, тэдэнд тавих хяналтыг сулруулснаас дээрх ажилтнууд их хэмжээний алдагдлыг банкинд бий болгосон байдаг. Дээрх асуудал бий болсон үгүйгээс үл хамааран банкны зүгээс дээрх ажилтнуудын үйл ажиллагаанд ижил ажил үүргийн хуваарьтай өөр ажилтан, эсвэл хараат бус этгээдээр хяналт тавиулах замаар үүсч болох эрсдэлээс сэргийлэх боломжтой юм. Түүнчлэн эрсдэлтэй арилжаа, гүйлгээ хийснээр банкинд их хэмжээний алдагдал учруулах эцэстээ банкны имиж, нэр төрд сөргөөр нөлөөлдөг тул банкны зүгээс цаашид зөвхөн холбогдох гүйлгээний мөнгөн дүн бус бизнесийн үйл ажиллагааны чанарт анхаарлаа хандуулан ажиллах шаардлагатай.

3.3.5.Банкны дотоод аудитын асуудал эрхэлсэн нэгжийг гүйцэтгэх захирлаас хараат бус байдлаар зохион байгуулах;

Дотоод аудитын нэгж нь банкны үйл ажиллагааны орчинд шалгалт хийгээд зогсохгүй гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлд үнэлгээ дүгнэлт өгөх үүрэгтэй. Дотоод аудитын нэгжээс хийж байгаа шалгалтад банкны гүйцэтгэх удирдлагын зүгээс зохисгүй байдлаар нөлөө үзүүлэх, үр дүнг нуун дарагдуулахаас сэргийлэн шалгалтын тайланг шууд ТУЗ-д эсвэл ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад зэрэг хүргүүлэх тогтолцолцоог бүрдүүлэх нь зүйтэй.

3.3.6.Банкны дотоод аудитын асуудал эрхэлсэн нэгжээс хийсэн шалгалтын акт материал, ажлын тайлан зэргийг цаг тухайд нь авч хэлэлцсэний үр дүнд зохистой засаглал болон дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох талаар банкны гүйцэтгэх захиралд үүрэг даалгавар өгөх, авсан арга хэмжээний үр дүнг тооцох;

Дотоод хяналтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх нь банкны зохистой засаглалыг хангах гол бүрэлдхүүн хэсэг болíî. Банкны гүйцэтгэх удирдлага нь банкинд дотоод хяналтыг бүрдүүлэн ажиллуулах үүрэг хүлээх бөгөөд нөгөө талаас ТУЗ нь гүйцэтгэх удирдлагаас бүрдүүлсэн дотоод хяналтын тогтолцоо нь үр нөлөөтэй, оновчтой бүрдсэн эсэхэд хяналт тавин ажиллана. Банкны дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд дотоод аудитын нэгж хяналт тавих бөгөөд шалгалтын тайланг ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад зэрэг хүргүүлэх, танилцуулах үүрэг хүлээнэ. Дотоод аудитын нэгжээс хүргүүлсэн тайланд дурьдсан дотоод хяналтын тогтолцооны сул талыг арилгахад шаардлагатай арга хэмжээг гүйцэтгэх удирдлага авдаг бол ТУЗ нь хэрэгжүүлсэн арга хэмжээ нь үр дүнгээ өгч байгаа эсэх тал дээр хяналт тавьж ажиллана.

3.3.7.Банкны удирдлага, зохион байгуулалтын асуудлыг жилд нэгээс доошгүй удаа авч хэлэлцэн, боловсронгуй болгох талаар санаачилга гарган ажиллах;

Банкны гүйцэтгэх удирдлагûí òàëààð яаралтай шийдвэрлэх асуудал тулгарсан тохиолдолд ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулна. Õуралд ТУЗ-өөс олон гишүүнийг хамруулах үүднээс хурлын тов, газрыг аль болох эртнээс зарлан түгээх нь чухал бөгөөд хэлэлцэх асуудàл болон агуулгын талаарх мэдээллийг хуралд оролцогсдод урьдчилан хүргүүлсэн байвал зохино. Түүнчлэн түр хурлыг хуралдуулах, хурлын талаар мэдээлэх журмыг хурал болохоос өмнө ТУЗ-ийн бүх гишүүдэд нээлттэй болгож хуралд оролцогсдын гарын үсгээр баталгаажсан хурлын протоколыг үйлдэж, баримтжуулах шаардлагатай.

3.3.8.Банкны өмнө хүлээсэн эрх үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэж, хууль тогтоомжийг чандлан сахих;

ТУЗ нь банкны харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, түүнд орох нэмэлт, өөрчлөлтийн талаар сайтар ойлголттой байх, хувь нийлүүлэгчид, харилцагчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд хүчээ дайчлан ажиллах шаардлагатай.

3.3.9.Банкны үйл ажиллагааны цар хүрээ өргөжихийн хэрээр удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, дадлага, туршлагыг хуримтлуулах. Шаардлагатай бол ТУЗ-ийн гишүүдийг сургалтад хамруулах, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг батлан гаргаж, хэрэгжүүлэх;

ТУЗ-èéí ãèø¿¿ä нь банкнаас шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг гаргах, шинэ зах зээлд нэвтрэх үйл явц нь зөв чиглэл, бодлогын дагуу хэрэгжиж байгаа эсэхэд оновчтой дүгнэлт өгөх, хяналт тавих, банкны гүйцэтгэх удирдлагыг буруу арга хэмжээ авахаас сэргийлэхэд шаардагдах хангалттай туршлага мэдлэгийг эзэмшсэн байна. ТУЗ нь дээрх асуудлыг дүгнэх хангалттай мэдлэгийг эзэмшээгүй гэж үзвэл гадны зөвлөхөөс туслалцаа хүсэх, мэдлэг туршлагаа тухай бүрт дээшлүүлэх арга хэмжээг тогтмол авна.

3.3.10.Банк, санхүүгийн хяналт шалгалтын тогтолцооны талаар зохих хэмжээний мэдлэгтэй байх, төрийн эрх бүхий байгууллагатай жигд, тогтвортой харилцах;

Банкны ТУЗ нь хяналт шалгалтын эрх бүхий байгууллага (*Монголбанк болон бусад холбогдох байгууллагууд*)-тай жигд, тогтвортой харилцаа тогтоож банкны удирдлагыг сайжруулахад шаардагдах мэдээ, мэдээллийг авах хүсэлтээ тухай бүрт тавих нь зүйтэй.

3.3.11.Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд зүй бусаар оролцохоос зайлсхийх (Энэ заалт нь ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орох гүйцэтгэх захиралд хамаарахгүй);

Банкны эрх мэдлийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор ТУЗ нь банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохоос аль болох зайлñхийх, дээрх үүргийг гүйцэтгэх удирдлагад даалгах нь тохиромжтой бөгөөд гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллана. ТУЗ нь банкны өдөр тутмын үйл ажиллагаанд зүй бусаар оролцвол банкин дахь эрх мэдлийн тэнцвэртэй байдал алдагдахад хүрнэ.

3.3.12.Гүйцэтгэх захирлын урамшууллын асуудлыг банкны эрхэм зорилго, стратеги төлөвлөгөө, ёс зүйн хэм хэмжээ болон хяналтын тогтолцоо зэрэгтэй уялдуулан шийдвэрлэх;

ТУЗ нь гүйцэтгэх удирдлагад олгох шагнал урамшууллын хэмжээг банкны эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан тогтоох аргачлалыг нэвтрүүлэх нь зүйтэй бөгөөд энэ нь цаашид банкны гүйцэтгэх удирдлагыг ажлаа богино хугацааны ашиг орлого бус урт хугацааны хэтийн зорилгод үндэслэн гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.

3.3.13.Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартад заасан шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллагыг хөндлөнгийн (гадаад) аудитороор сонгон шалгаруулах.

Банкинд хөндлөнгийн аудит хийх найдвартай, хараат бус гадны компанийг сонгон шалгаруулах нь чухал бөгөөд банкны санхүүгийн тайланд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрсдэлийн үнэлгээний аргачлалд тулгуурлан хөндлөнгийн аудитыг хийлгэнэ. Түүнчлэн ТУЗ нь хөндлөнгийн аудитаас ирүүлсэн тайлангаас гадна, банкны дотоод хяналтын тогтолцоо нь үр ашигтай эсэх, цаашид тогтолцоог сайжруулахад авах арга хэмжээний талаарх тэдний үзэл бодолтой танилцах нь чухал юм.

3.4.ТУЗ нь эрх, үүргээ хэрэгжүүлэх үүднээс дараахь хороог байгуулж болно:

Дараах удирдлага зохион байгуулалтын нэгжүүд нь өөрт оногдсон ажил үүргээ гүйцэтгэх шаардлагатай бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааны найдвартай, ил тод байдлыг хангах үүднээс хороонд ажиллах гишүүдийн тоо, бүрэлдэхүүн (*хараат бус гишүүд*) болон үйл ажиллагааны журмын талаар нарийвчлан тодорхойлж холбогдох мэдээллийг ил тод болгох нь тохиромжтой. Түүнчлэн хороодын үйл ажиллагааг идэвхижүүлэх үүднээс хорооны дарга, гишүүдийн бүрэлдэхүүнийг зарим үед өөрчлөх нь эерэг үр дүнд хүргэдэг.

3.4.1.Эрсдэлийн удирдлагын асуудал эрхэлсэн хороо. Тус хороо нь банкны гүйцэтгэх захирлын зүгээс зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын, үйл ажиллагааны, хууль эрх зүйн, нэр хүндийн болон бусад төрлийн эрсдлийн удирдлагын талаар авч буй арга хэмжээ нь хангалттай байгаа эсэхэд хяналт тавина;

Эрсдэлийн удирдлагын хороо нь дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үүнд: Банкны үйл ажиллагааны нэгж бүрт үүсч болох эрсдэлийн түвшинг тодорхойлох, илрүүлэх, эрсдэлийг бууруулах, арилгахад шаардлагатай арга хэмжээг авах, оновчтой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх. Тухайлбал, эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийг хэмжихэд ашиглаж буй аргачлалын сул талууд, хязгаарлалтууд (техник, таамаглал)-ын талаар сайтар ойлголттой байж дээрх дутагдлыг залруулах талаар баримтлах бодлогыг тодорхойлно.

3.4.2.Урамшууллын асуудал эрхэлсэн хороо. Тус хороо нь энэхүү журмын 3.3.12-д заасан асуудлыг шийдвэрлэнэ;

Урамшууллын асуудал эрхэлсэн хороо нь дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үүнд: Банкинд мөрдөгдөж буй цалин, урамшууллын бодлогын дагуу ТУЗ, гүйцэтгэх удирдлагад олгох цалин, урамшууллын хэмжээг тодорхойлох бөгөөд тогтоосон хэмжээ нь банкны соёл, хяналтын орчин болон банкны хэтийн стратеги төлөвгөөтэй нийцэж байвал зохино.

Банкны гүйцэтгэх удирдлагад олгогдох урамшууллын хэмжээг ажлын гүйцэтгэл, үр дүнд, цалин нөхөн олговрын хэмжээг банкны урт хугацааны үнэт зүйлсýд тулгуурлан тус тус тогтоох бөгөөд хэт их эрсдэлтэй үйл ажиллагаа явуулах, богино хугацааны ашиг орлого олоход анхаарлаа хандуулах эрсдэлийг үүсгэхгүйн тулд урамшуулал болон цалингийн түвшинг банкны баримтлах ерөнхий бодлогод нийцүүлэн оновчтой тогтооно.

3.4.3.Аудитын асуудал эрхэлсэн хороо. Тус хороо нь гадаад болон дотоод аудитын асуудлыг хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргийнхээ хүрээнд хариуцан ажиллана;

Аудитын асуудал эрхэлсэн хороо нь дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үүнд: Банкинд хийгдэх дотоод болон хөндлөнгийн аудитаар ажиллах аудиторуудын үйл ажиллагааг хянах, ТУЗ болон хувь нийлүүлэгчдэд нэрсийг санал болгох, сонгон шалгаруулах, цалин, урамшуулал олгох, ажлаас чөлөөлөх, аудитын хүрээ, давтамжийг тогтоох, тайлантай танилцах, аудитын дүгнэлтэд дурьдсан банкны дотоод хяналтын тогтолцооны сул талууд, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаарх саналыг гүйцэтгэх удирдлага нь хууль òîãòîîìæèéí дагуу, тохиромжтой цаг хугацаанд хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавин ажиллах үүрэгтэй.

3.4.4.Хүний нөөцийн асуудал эрхэлсэн хороо. Тус хороо нь ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүнг дүгнэх, боловсронгуй болгох, ТУЗ-ийн гишүүнийг томилох, ажлаас чөлөөлөх асуудалд дэмжлэг үзүүлнэ.

Хүний нөөцийн асуудал эрхэлсэн хороо нь дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үүнд:
ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх, хувь нийлүүлэгчдийн хурлаар удирдах албан тушаалд ажиллах этгээдүүдийн нэрсийг дэвшүүлэх, сонгох, үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг оруулах, шаардлагатай тохиолдолд холбогдох асуудлаар удирдлага болон ажилòíаас тайлан гаргуулан авах үүргийг хүлээнэ. Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулсан зохистой засаглалын журамд хүний нөөцийн асуудал эрхэлсэн хороо нь дараах байдлаар үйл ажиллагаагаа явуулна гэж заасан байдаг. Үүнд:

3.4.4.1. Хүний нөөцийн хороо нь хувь нийлүүлэгчдээс ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг хүлээн авч нэр дэвшигчид нь банкны талаар хууль тогтоомж, ТУЗ-ийн дүрэм, банкны дүрэм, бусад дотоод журамд заасан мэргэжлийн болон бусад асуудлаар тавигдах шаардлагуудыг хангасан эсэх талаар дүгнэлт гаргах, хэрэв хангаагүй гэж үзсэн тохиолдолд нэр дэвшигчид бичгээр хариу мэдэгдэх,

3.4.4.2. ТУЗ-ийн гишүүн нас барах, эсвэл óááàí хугацаанд хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд дараагийн хувь нийлүүлэгчдийн хурал болох хүртэл үүрэгт ажлыг орлон гүйцэтгэгчийг тус хорооноос томилон ажиллуулах,

3.4.4.3. ТУЗ-ийн гишүүдийн ажлын үүрэгт хугацаа дуусахад гишүүн бүрийн ажлын гүйцэтгэлийн тайланг хувь нийлүүлэгчдийн хурлаар танилцуулах бөгөөд танилцуулгад гишүүний хурлын ирц, оролцооны талаарх мэдээллийг тусгасан байна.

3.4.4.4. Áанкны гүйцэтгэх удирдлагад багтан ажиллах албан тушаалтныг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, тэдэнд холбогдох мэдээллийг цуглуулах, ТУЗ-д танилцуулах болон ажлын гүйцэтгэлд үнэлэлт өгөх үүргийг гүйцэтгэнэ.

Групп компанийí талаар нэмэлт тайлбар

Энэхүү зөвлөмжид тусгагдсан зарчмууд нь банкийг групп компанийн охин компани эсвэл толгой компани байх тохиолдолд үйлчлэх бололцоотой ч групп компанийн бүтцээс шалтгаалан банкны зохистой засаглалын талаарх нэмэлт асуудлуудыг охин болон толгой компаниуд хамтран шийдвэрлэх шаардлага тулгардаг. Групп компанийн бүтцэд хамаарах банкны үйл ажиллагаанд хянан шалгагчийн зүгээс үнэёэлт, дүгнэлт өгөхдөө толгой болон охин компанийн зүгээс зохистой засаглалын талаар хүлээх үүргээ ухамсарлан үйл ажиллагаанд мөрдлөг болгодог талыг сайтар харгалзан үзвэл зохино.

Толгой компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь нийт групп компанийн хэмжээнд зохистой засаглалыг хангах зорилгоор ерөнхий стратеги, бодлогыг боловсруулж, салбар компаниудад зориулсан зохистой засаглалын оновчтой бүтцийг нэвтрүүлэх, толгой болон нийт салбар компаниудын үйл ажиллагааны дотоод хяналтын тогтолцоог хянахад тохиромжтой аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллах үүргийг хүлээнэ. Салбар банкны ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь зохистой засаглалын талаар хүлээх өөрийн үүргээ биелүүлэх буюу банкны үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болон холбогдох хууль тогтоомжийг чандлан сахиж ажиллана.

Толгой компанийн ТУЗ нь толгой болон салбар компаниудад учирч болох материаллаг эрсдэл болон компанийг хүндэлд оруулж болзошгүй асуудлын талаар нарийн ойлголттой байх шаардлагатай бөгөөд салбар компаниудын үйл ажиллагаанд зохистой хяналтыг тогтмол тавьж ажиллана. Энэ зөвлөмж нь толгой компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлага нь салбар компани буюу банкны ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагаас илүү ач холбогдолтой эсвэл нөлөөтэй талаар тусгаагүй бөгөөд групп компанийн үйл ажиллагаанд ажил үүргийн давхардал тулгарсан гэж үзвэл холбогдох ажил үүргийн хуваарийг нэгтгэх замаар оновчтой хяналтын бүтцийг бүрдүүлэх бололцоотой.

Банк нь санхүүгийн үйл ажиллагаа ýððýëäýггүй групп компанийн салбар компани бол юуны ºìíº банкны тогтвортой үйл ажиллагааг хангаж, зохистой засаглалын хэрэгжилтэд илүүтэйгээр анхаарлаа хандуулан ажиллах нь зүйтэй. Банк болон групп компанид хамаарагдах салбар компаниудын хооронд гэрээ, хэлцэл хийгдэх үед ТУЗ-өөс баримтлах оновчтой бодлого болон *Хараат бус байдлын* зарчмыг баримтлана. Ялангуяа төлбөрийн чадварын хувьд эргэлзээтэй салбар компанитай гэрээ, хэлцэл хийхгүй байвал зохино. Иймд, банк нь санхүүгийн бус үйл ажиллагаа явуулж буй группэд хамаарагдаж байгаа тохиолдолд аль болох бие даасан, тусдаа хуулийн этгээд хэлбэрээр үйл ажиллагаа явуулах нь тохиромжтой.

ДӨРӨВ. БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ШАТНЫ УДИРДЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1.Банкны гүйцэтгэх шатны удирдлага гэдэгт гүйцэтгэх захирал, ерөнхий захирал болон банкны газар, хэлтсийн захирлуудыг хамруулан ойлгоно.

Дээрх албан тушаалтнууд нь дээд удирдлагын хяналтан дор банкны үйл ажиллагааг удирдах, тухайн үйл ажиллагаанд голлох үүрэг гүйцэтгэх ажилтнуудад хяналт тавьж ажиллах үүрэгтэй. Банкны гүйцэтгэх удирдлагад ажиллах албан тушаалтнууд нь ТУЗ-өөс зохистой засаглалын талаар баталсан бодлого, аргачлалын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор банкны тухайн үйл ажиллагаа хариуцсан салбарын удирдлагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

4.2.Гүйцэтгэх шатны удирдлага нь банкны зохистой засаглалын талаар дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.2.1.Банкны стратегийн төлөвлөгөө болон эрсдэлийн удирдлагын талаарх дотоод заавар, дүрэм, журмыг боловсруулж, ТУЗ-д өргөн барьж, батлуулах;

Гүйцэтгэх шатны удирдлага нь үйл ажиллагаандаа мөрдөх удирдлагын төлөвлөгөө, дүрэм журам, аргачлалыг боловсруулах үүрэгтэй бөгөөд ТУЗ-д танилцуулж батлуулсны дараа банкинд хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимтэй авна.

4.2.2.ТУЗ-өөс баталсан стратеги төлөвлөгөө болон дүрэм, журам, заавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах;

4.2.3.Банкны ажилтнуудын хувьд өөрт ногдсон үүргээ аливаа ашиг сонирхлын зөрчилгүйгээр гүйцэтгэх нөхцөл бололцоог бүрдүүлэх;

Гүйцэтгэх удирдлага нь банкны удирдлага зохион байгуулалт, банкинд хэрэгжих тогтолцоог бүрдүүлэхдээ банкны ажилтнуудыг сонирхлын зөрчилд орохоос сэргийлэх байдлыг хангана. Тухайлбал, банкинд баг (хос)-ийн хяналтын тогтолцоо буюу ажилтнууд нь бие биенийхээ ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах аргачлалыг нэвтрүүлэх, тодорхой хугацааны давтамжтайгаар хянах үүрэгтэй ажилтнуудыг солих арга хэмжээ нь сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлнэ.

4.2.4.Банкны үндсэн үйл ажиллагаа болон эрсдэлийн талаарх бүхий л төрлийн заавар, журам болон стандартыг ажилтнуудаараа мөрдүүлэн хэвшүүлэх, энэ талаар зохих гарын авлага болон зөвлөмжийг батлан гаргасан байх;

Банкнаас боловсруулсан заавар журам, стандартуудын агуулга, зорилгыг ажилтнууд сайтар ойлгох, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох нь чухал юм. Ажилтнуудын хууль журмыг чандлан сахиж байгаа тал дээр банкны дотоод аудитын нэгжээс ажиглалт хийх замаар үнэлгээ өгөх хэрэгтэй бөгөөд холбогдох аргачлалыг боловсруулах шаардлагатай.

4.2.5.Банкны дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн, жигд ажиллагааг хангах;

Банкны гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-өөс өгсөн чиглэлийн дагуу үр ашигтай дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн банкинд нэвтрүүлэх үүрэг хариуцлагыг хүлээдэг.

Удирдлагын талаарх гаргах шийдвэрийг жижиг банкны хувьд ч мөн адил нэгээс дээш албан тушаалтны оролцоотойгоор гаргадаг бөгөөд гүйцэтгэх удирдлага нь дараах нөхцөл байдал үүсэхээс сэргийлж ажиллана. Үүнд:

- Бизнесийн төрөлжсөн, анхан шатны үйл ажиллагаанд зохисгүй байдлаар оролцох,
- Шаардлагатай мэдлэг, туршлагыг эзэмшээгүй этгээдийг холбогдох албан тушаалд томилох,
- Банкинд ашиг орлого оруулдаг, нэр хүнд бүхий ажилтны үйл ажиллагаанд шаардлагатай хяналтыг тавих эрмэлзэл хүсэлгүй эсвэл боломжгүй байх,
- Банкинд төлөвлөснөөс их хэмжээний ашиг оруулдаг ажилтныг алдах болгоомжлол удирдлагад бий болсон тохиолдолд тус ажилтанд хяналт тавих асуудлыг шийдвэрлэхэд хүндрэл учирдаг.

Банкинд үр ашигтай дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлэх нь гүйцэтгэх удирдлагын чухал үүргийн нэг бөгөөд банкны үйл ажиллагааны нэгж бүрт үүсэх эрсдэлийг үнэлэх замаар нэгж тус бүрт тохирох дотоод хяналтыг бүрдүүлнэ. Банкны үйл ажиллагааны аль нэг хэсэгт ноцтой эрсдэл бодитоор үүсэхээргүй байгаа ч тохирох дотоод хяналтын тогтолцоог яаралтай нэвтрүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээг авах шаардлагатай. Банкинд үүсэх эрсдэл нь ноцтой эсэхийг эрсдэл учирснаар банкинд учруулах боломжит алдагдал, хүндрэлд үндэслэн шийдвэрлэнэ.

4.2.6.Дотоод хяналтын тогтолцоонд гажуудал үүссэн, түүнчлэн эрсдэлийн удирдлагыг хангах талаар тогтоосон үйл ажиллагааны хязгаарлалт зөрчигдсөн бол холбогдох мэдээллийг цаг тухайд нь авч, зохих арга хэмжээг авсан байх;

Дотоод хяналттай холбоотой дараах үндсэн хоёр асуудлыг юуны түрүүнд шийдвэрлэх шаардлагатай. Үүнд:

- Банкны үйл ажиллагаанд учрах эрсдэл оршин байгаа ч тохиромжтой дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлээгүй,
- Банкны бүрдүүлсэн дотоод хяналтын тогтолцоо нь үр дүн багатай, оновчгүй байдлаар бүрдүүлсэн.

Тухайлбал, банкны ажилтан нь харилцагчаас гүйлгээ хийлгэхээр өгч буй төлбөрийг хүлээн авдаг, түүнчлэн холбогдох гүйлгээг бүртгэх үүргийг давхар гүйцэтгэж байвал банкны дотоод хяналтын тогтолцоо оновчтой бус байгааг харуулах бөгөөд дээрх үүргийг хоёр хүнээр гүйцэтгүүлэх буюу ажил үүргийн хуваарийг салгах нь дотоод хяналтын тогтолцоо бүрдсэний илрэл ìºí. Нөгөөтэйгүүр, банкны зүгээс ажил үүргийн хуваарийг салгасан боловч бодит байдал дээр ганц ажилтан дээрх үүргийг давхар гүйцэтгэх тохиолдîл их гардаг бөгөөд энэ нь дотоод хяналтын тогтолцоог бий болгосон боловч хэрэгжилт нь хангалтгүй байгааг харуулж байгаагийн жишээ юм. Дээрх эрсдлүүд банкинд оршин байгаа тохиолдолд гүйцэтгэх удирдлагаас дотоод хяналтын тогтолцоонд үүссэн сул талыг залруулах арга хэмжээг цаг алдалгүй авах шаардлагатай.

4.2.7.Банкны үндсэн эрсдэлүүдэд тогтмол хяналт тавьж, зохистой түвшинд барих талаар санаачилга гарган ажиллах;

Банкны дотоод хяналтын тогтолцоо болон дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулахад дараах арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай. Үүнд:

- Дотоод хяналтын үйл ажиллагаа болон аудитын ач холбогдлын талаар нарийн ойлголттой байж, банкны ажилòíóóдад танилцуулах ажлыг зохион байгуулах,
- Дотоод аудитын нэгжээс банкны удирдлагын үйл ажиллагааны талаарх алдаа дутагдлууд, санал дүгнэлтийг тодорхой хугацаанд залруулах, хэрэгжүүлэх арга хэмжээг авч байх,
- Дотоод аудитын нэгжийн тайланг шууд банкны ТУЗ эсвэл аудитын хороонд хүргүүлэх замаар тэднийг гүйцэтгэх удирдлагаас хараат бус байх нөхцлийг бүрдүүлэх,
- Дотоод хяналтын тогтолцооны үр ашигтай байдлыг дотоод аудиторуудаар хянуулах,

4.2.8.Дотоод аудитын тусламжтайгаар банкны дотоод хяналтын тогтолцоо болон үйл ажиллагааны зохистой хэм хэмжээг хангаж ажилласан байдалд үнэлэлт дүгнэлт өгөх;

Банкнаас дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлсэн боловч хэрэгжихгүй байгаа тохиолдолд банкинд дотоод хяналтын тогтолцоо нь бодит байдалд хэрэгжиж буй эсэхийг урьдчилан боловсруулсан тест, сорилын тусламжтайгаар тогтоох боломжтой.

Дээрх үнэлгээг ихэвчлэн хөндлөнгийн аудитын байгууллага олон улсын стандартад үндэслэн хийдэг боловч зөвхөн банкны санхүүгийн тайланд хийх аудитаар хязгаарлагддаг бөгөөд аудит хийх хугацааны давтамжийн хувьд ч хязгаарлагдмал байдаг. Иймд дээрх асуудлаас зайлсхийх үүднээс банкны дотоод аудитын нэгж нь холбогдох үнэлгээг хийх нь тохиромжтой юм. Гэвч одоогийн банкуудын дотоод аудитын нэгж нь дотоод хяналтын тогтолцоонд шинжилгээ хийхээс илүүтэйгээр банкны ажилтнуудын үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэлд газар дээр нь хяналт тавих ажлыг ихэвчлэн гүйцэтгэж байна. Түүнчлэн зарим банкны гүйцэтгэх удирдлага нь банкны дотоод аудит нь дотоод хяналттай адил ойлголт гэж үздэг нь ажиглагдсан бөгөөд цаашид уг ойлголтын ялгаа буюу дотоод аудит нь банкны дотоод хяналтын тогтолцооны нэг чухал бүрэлдýðүүн хэсэг гэдгийг сайтар ойлгох, улмаар гүйцэтгэх удирдлагын зүгээс оновчтой дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй юм.

4.2.9.Банкны үйл ажиллагааны онцлог болон хүлээж болзошгүй эрсдэлийн нэр төрөлтэй уялдаатай удирдлагын мэдээллийн тогтолцоог бий болгосон байх

Энэ хэсэгтэй холбоотой тайлбарыг IT (мэдээллийн технологи) хяналт шалгалтын гарын авлагад дэлгэрэнгүй тусгасан болно.

ТАВ. АУДИТЫН ХОРОО БОЛОН ДОТООД АУДИТЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Дотоод аудитын үүрэгт дор дурдсан үйл ажиллагааг хамруулна:

Зөвлөмжийн 3.4.3-д дурьдсанчлан аудитын хороо нь банкны дотоод болон хөндлөнгийн аудиторуудын үйл ажиллагааг хянах үүрэгтэй. Түүнчлэн банкны дотоод хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор дараах асуудлуудыг ТУЗ болон аудитын хорооны зөвшөөрлийг авсны үндсэн дээр шийдвэрлэнэ. Үүнд:

- Банкны дотоод аудитын талаар баримтлах бодлогыг боловсруулж, банкинд нэвтрүүлэх, танилцуулах,

- Дотоод аудитын дүрэм, журмыг боловсруулах.Журамд дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:
    - Дотоод аудитын зорилго
    - Дотоод аудитын нэгжийн хараат бус байдал
    - Дотоод аудитын нэгжийн эрх, үүрэг, хүлээх хариуцлага
    - Шаардлагатай мэдээллийг гаргуулах тогтолцоо
    - Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ
    - Дотоод аудитын тайлан мэдээг хүргүүлэх, тайлагнах тогтолцоо

- Дараах асуудлуудыг багтаасан дотоод аудитын гарын авлагыг боловсруулах. Үүнд:
    - Дотоод аудитын обьект буюу аудит хийгдэх нэгжүүд
    - Дотоод аудит хийх аргачлал

- Банкны хууль тогтоомжèéí хэрэгжилт, харилцагчдын эрх ашгийг хамгаалах арга хэмжээ болон банкны эрсдэлийн удирдлагын өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулах, түүнчлэн дотоод аудит хийх хугацааны давтамж, аудитын цар хүрээний үр ашиг, үр нөлөөг давхар харгалзан үзнэ.

Банкны дотоод аудитыг цаашид сайжруулахын тулд дараах асуудлыг анхаарах шаардлагатай. Үүнд:

(1) Банкны ТУЗ, аудитын хорооноос хангалттай мэдлэг, туршлагатай ажилтныг дотоод аудитын нэгжийн захирлаар томилж, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх мэдлийг олгоно. Дотоод аудитын нэгжийн захирал нь банкны бусад газар, хэлтсийн захирлын ажлыг давхар хашдаг бол дотоод аудитын нэгжийн бие даасан, хараат бус байдлыг хангах нь чухал юм.

(2) Банкны ТУЗ, аудитын хорооноос хангалттай мэдлэг, туршлагатай ажилтныг дотоод аудитын нэгжийн аудитор/ажилтнаар томилж, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх мэдлийг олгоно. Дотоод аудитын нэгжийн захирал, ажилтнууд нь мэдлэг чадвараа дээшлүүлэх тал дээр байнга анхаарч сургалт, семинарт хамрагдах нь зүйтэй бөгөөд банкны зүгээс ажилтнуудыг сургалт, семинарт тогтмол хамруулах тогтолцоог боловсруулах нь зîõèñòîé.

(3) ТУЗ болон аудитын хороо нь дотоод аудитын нэгжийн хараат бус байдлыг хангах үүрэг хүлээх бөгөөд дотоод аудитын нэгж нь оногдсон ажлаа шалгалтанд хамрагдаж буй нэгжийн зүгээс үзүүлэх зүй бус нөлөө, саадгүйгээр гүйцэтгэх боломжоор хангана. Түүнчлэн ТУЗ-өөс дотоод аудиторуудыг аудит хийгдэх газар, нэгжид ажилладаггүй байхаар зохицуулах нь зүйтэй.

(4) Банкинд зөрчил гаргах, хууль зөрчих магадлал өндөртэй, эрсдэл ихтэй зохион байгуулалтын нэгж, салбаруудад хийх дотоод аудитын тогтолцоог энгийн нэгж салбарынхаас өөрөөр боловсруулах шаардлагатай. ТУЗ болон аудитын хороо нь гаднаас буюу хөндлөнгөөс дотоод хяналтын тогтолцоонд аудит хийхээр томилсон аудиторуудын тайлангийн үр дүн, ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллах, тайлангийн үнэн зөв эсэхэд давхар хариуцлага хүлээн ажиллана.

(5) Шаардлагатай тохиолдолд ТУЗ, аудитын хороо нь дотоод аудитын журмын дагуу дотоод аудиторуудыг банкны бүх ажилòíаас ярилцлага авах, шаардлагатай мэдээллийг гаргуулан авах эрхээр хангана.

(6) ТУЗ, аудитын хороо нь банкны бүх ажилòíóóäàд дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны зорилго, үүрэг хариуцлагын талаар дэлгэрэнгүй таницуулах, ойлгуулах үүрэг хүлээнэ.

(7) Банкны гадаад улс дахь салбар нэгжийн үйл ажиллагааны эрсдэл нь зөвшөөрөгдөх түвшнээс хэтэрсэн гэж үзвэл дотоод аудитын нэгжийн хяналтын дор ажиллах аудитын багийг тус улсын салбарт байгуулан ажиллуулах нь зүйтэй.

(8) ТУЗ нь дотоод аудиторуудаас ирүүлэх аудитын тайланг хугацаанд үнэн зөв ирүүлж байгаа тал дээр анхаарал хандуулан ажиллана.

Дээр дурьдсан асуудлаас гадна, дотоод аудитор нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

5.1.1. Банкны гүйцэтгэх шатны удирдлага нь ТУЗ-өөс баталсан бодлого болон дүрэм, журмыг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;

5.1.2. Банкны зохистой засаглал, хяналтын үйл ажиллагаа болон эрсдэлийн удирдлага зэрэг нь тогтоосон хэм хэмжээний хүрээнд явагдаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;

5.1.3. Гүйцэтгэх шатны удирдлагаас банкны хувь нийлүүлэгчдэд болон ТУЗ-д хүргүүлж буй тайлан мэдээ нь үнэн зөв байсан эсэхэд хяналт тавих;

5.1.4. Бодлогын хэрэгжилтийн талаар ТУЗ-д улирал тутам тайлагнах;

5.1.5. ТУЗ болон гүйцэтгэх шатны удирдлага хоорондын харилцаа, ажлын уялдаа холбоог сайжруулах талаар санаачилга гарган ажиллах;

5.1.6. Банкны хувьд эрсдэлийн удирдлагын талаар авсан арга хэмжээ нь хүлээж болзошгүй алдагдал, гэрээ хэлцлийн дүн зэрэгтэй уялдаж байсан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;

5.1.7. Банкны нээлттэй позиц болон хүлээж болзошгүй эрсдэлийн мөн чанарын талаар нарийвчилсан судалгаа, шинжилгээ хийсэн байх;

5.1.8. Банкны шалгуур үзүүлэлтүүд хангагдаж байгаа эсэх, хангагдаагүй тохиолдолд авсан арга хэмжээнд хяналт тавих;

5.1.9. Гүйцэтгэх шатны удирдлага нь банкны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын талаар зохих хэмжээний ойлголттой байх бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэх талаар хангалттай хэмжээний туршлагатай эсэхийг баталгаажуулах;

5.1.10. Банкны үйл ажиллагаанд үнэлэлт өгч, шаардлагатай бол боловсронгуй болгох талаар тодорхой санал боловсруулж, ТУЗ-д танилцуулах.

5.2. Дотоод аудитын асуудал эрхэлсэн газар, нэгж нь ТУЗ болон Хяналтын зөвлөлийн шууд удирдлага дор ажиллана.

ЗУРГАА.ГАДААД АУДИТЫН ЭРХ, ҮҮРЭГ

6.1.Гадаад аудитор нь банкны зохистой засаглалыг бэхжүүлэх, эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох үүднээс дараахь эрх үүргийг хэрэгжүүлнэ:

Банкны ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь хөндлөнгийн аудиторын үйл ажиллагааг үр ашигтай явуулах, санхүүгийн тайлан нь банкны үйл ажиллагааны тодорхой хугацааны нөхцөл байдлыг зохистой илэрхийлж буй эсэхэд бодитой дүгнэлтийг гаргахад доорх асуудаёд анхаарна. Үүнд:

- Хөндлөнгийн аудит хийж буй аудиторууд нь олон улсын мэргэжлийн болон бусад шаардлагûã хангасан байх,
- Аудитын үндэсний стандартын дагуу, хөндлөнгийн аудит хийж буй компанийн ахлах аудитор нь салбарын аудиторуудын банкуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын үнэн зөв эсэхэд давхар хариуцлага хүлээлгэхэд анхаарах, ингэснээр нийт аудитын үйл ажиллагааны эрсдлийг бууруулах, санхүүгийн тайлангийн бодитой эсэх талаар давхар баталгаа болох ач холбогдолтой юм.
- Гадаад аудиторууд нь банкны дотоод аудитын тогтолцоог шалгахдаа санхүүгийн тайланг олон нийтэд тогтмол, нээлттэй мэдээлж байсан талаар хянах,
- Гадаад аудиторууд нь өөрсдийн банкны өмнө хүлээх үүргээ бүрэн ухамсарлаж, ажлаа мэргэжлийн түвшинд хийх,
- Байнга үйлчлүүлдэг нэр хүнд бүхий аудитын компанийг хугацааны давтамжтайгаар сольж буй эсэх,

1/Банкны аудитыг хэрэгжүүлэх явцдаа үйл ажиллагаатай холбоотой бүхий л төрлийн эрсдэлээр зохих хэмжээний үнэлэлт, дүгнэлтийг өгсөн байх;

2/Банкнаас аудитын хүрээнд гаргаж өгсөн аливаа төрлийн мэдээ, мэдээлэл нь үнэн зөв байсан эсэхийг магадлан шалгаж, баталгаажуулах;

3/Банкны зүгээс гүйцэтгэж буй ажил гүйлгээний талаар мэдээлэл хуримтлуулж, санхүүгийн бүтээгдэхүүний бүрэлдэн бий болгох үйл явцын талаар тодорхой ойлголттой болсон байх;

4/Банкны гүйцэтгэх шатны удирдлага нь ТУЗ-өөс баталсан бодлого болон дүрэм, журмыг хэрхэн биелүүлж байгаад үнэлэлт дүгнэлт өгөх;

5/Банкны хувь нийлүүлэгч, ТУЗ болон төрийн хянан шалгалтын эрх бүхий байгууллагад хүргүүлсэн мэдээ, мэдээлэл нь үнэн зөв байсан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;

6/Банкны зүгээс хууль эрхийн актын хүрээнд тавьж буй зүй ёсны шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх.

ДОЛОО. ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ

Банкны ил тод байдлыг хангаснаар харилцагчдын эрх ашгийг хамгаалахад сайнаар нөлөөлөхөөс гадна, банкны зохистой засаглалын хэрэгжилтийг батжуулах ач холбогдолтой байдаг. Ялангуяа хаалттай бүтэцтэй, томоохон хувь нийлүүлэгч олонтой банкуудын зүгээс хувь нийлүүлэгчдийн бүтцийн талаарх мэдээллээ ил тод болгох нь илүү чухал юм.

Ил тод байдлыг хангах асуудал нь зохистой засаглалын хэрэгжилттэй нягт холбоотой. Учир нь ил тод байдлын түвшин òàâðóóõàí банкны хувь нийлүүлэгчид, харилцагчид болон бусад оролцогч талууд нь ТУЗ, гүйцэтгэх удирдлагыг үүрэгт ажлаа хангалттай гүйцэтгэж буй эсэхэд хяналт тавихад ихээхэн хүндрэлтэй тулгардаг. Энэ төрлийн хүндрэл нь банкны хувь нийлүүлэгчид, харилцагчид нь банкны дүрмийн сан, эзэмшлийн бүтцийн талаар шаардлагатай мэдээллийг авч чадахгүй, улмаар ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг дүгнэх боломжгүй байгаа үед голчлон үүсдэг.

Шаардлагатай мэдээллийг олон нийтэд нээлттэй болгосноор зах зээлийн сахилга батыг идэвхжүүлэх, нөгөөтэйгүүр банкнаас хяналт шалгалтын байгууллага (Монголбанк)-д ирүүлэх шаардлагатай тайлан мэдээг хугацаанд нь үнэн зөв ирүүлснээр тухайн байгууллагын зүгээс банкны үйл ажиллагаа, эрсдлийн талаар үнэлгээ дүгнэлт хийх нөхцөл, бололцоог бүрдүүлдэг. Хэдийгээр хаалттай буюу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр зохион байгуулагдсан банкуудын хувьд зах зээлийн сахилга батыг сайжруулах асуудал нь нээлттэй бүтэцтэй (хувьцаат компани) банктай харьцуулахад ач холбогдол багатай мэт боловч бодит байдалд нээлттэй бүтэцтэй банктай адилхан эрсдлийг агуулíà. Тухайлбал, төлбөр тооцооны системд оролцох, харилцагчдаас хадгаламж татах гэх мэт. Банкны хууль тогтоомж болон хяналтын байгууллагаас тавьж буй шаардлагын дагуу зохистой засаглалыг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээ мэдээлэл, санхүүгийн болон бусад тайланг нээлттэй болгосноор банкны харилцагчид болон зах зээлд оролцогчдын зүгээс банкны тогтвортой байдалд хяналт тавих боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.

Түүнчлэн банкны жилийн тайлангаас гадна, өөрийн байгууллагын цахим хуудсанд шаардлагатай мэдээллийг байршуулах нь ил тод байдлыг хангах үр дүнтэй аргуудын нэг хэлбэр юм. Учир нь цахим хуудас нь олон нийтээс банкны талаарх мэдээллийг авах харьцангуй хялбар, хурдан арга бөгөөд банкуудын хувьд ч мэдээллээ тухай бүрт шинэчлэх боломжтой байдаг. Банкнаас гаргаж буй тайлан мэдээг олон нийтэд хүргэх хэрэгслийг банкны харилцагчдын ая тухтай байдал, банкны үйл ажиллагааны зардал болон мэдээллийн технологийн чадавхид үндэслэн сонгоно.

7.1.Банк дараахь мэдээллийг нийтэд ил тод болгосон байх шаардлагатай:

1/Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан;

Банкны аудитлагдсан санхүүгийн тайланд нэр томьёоны тайлбараас гадна аудитын тайланг хавсаргана.

2/Банкны эрхэм болон хэтийн зорилт;

Банкны эрхэм зорилгоос гадна дараах мэдээллийг нийтэд ил тод болгох шаардлагатай. Үүнд: Банкны бизнесийн бодлого, ёс зүйн хэм хэмжээний журам болон зохистой засаглалтай холбоотой эрх зүйн áóñàä актууд.(*ÿлангуяа, банкны зохистой засаглалын*

талаарх бодлого, журмын агуулга, хэрэгжүүлэх үйл явц, ТУЗ-ийн ажлын гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгөх талаарх мэдээллийг агуулна)

3/Банкны томоохон хувь нийлүүлэгчид болон тэдгээрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцааны талаарх мэдээлэл;

Үүнд: Хувь эзэмшил, саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад томилогдон ажиллаж буй томоохон хувь нийлүүлэгчид болон хувь нийлүүлэгчдийн хурлын талаарх мэдээлэ́л багтана.

4/ТУЗ-ийн дарга, гишүүд болон гүйцэтгэх захирлын мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага туршлагын талаарх мэдээлэл;

Дээрх мэдээлэлд: ТУЗ-ийн бүтэц (*тухайлбал, ТУЗ-ийн дүрэм, гишүүний тоо, гишүүнчлэл, сонгон шалгаруулах үйл явц, боловсролын түвшин, гүйцэтгэх удирдлагын чадвар, хараат бус байдлын талаар тавигдах шаардлага, банкинд нөлөөлж буй асуудлууд, арилжаа гүйлгээ хийхэд үүсэх материаллаг ашиг сонирхол, хорооны гишүүнчлэл, дүрэм, үүрэг хариуцлага гэх мэт*) болон гүйцэтгэх удирдлагын бүтэц (*тухайлбал, үүрэг хариуцлага, тайлан мэдээг хүлээн авах тохиолдол, боловсрол, туршлага гэх мэт*)-ийн талаарх мэдээлэ́л. Түүнчлэн банкны урамшуулал, нөхөн олговрын талаарх мэдээллийг (*тухайлбал, цалин, урамшууллын бодлого, захирал, гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал, хувьцаагаар солих опшин эрх гэх мэт*) ил тод болгох нь тохиромжтой.

5/Холбогдох этгээдэд хамаарах ажил гүйлгээ, тухайлбал холбогдох этгээдэд олгосон зээл, гаргасан батлан даалт болон аккредитив;

Одоогоор үйл ажиллагаа явуулж буй ихэнх банкууд нь хаалттай бүтэцтэй, цөөн тооны томоохон хувь нийлүүлэгчидтэйгээс шалтгаалан хувь нийлүүлэгчдийн хооронд хийгдсэн гэрээ хэлцэл, гүйлгээний талаарх мэдээлэл нь хаалттай байдаг. Иймд банкны удирдлагын зүгээс дээрх гүйлгээг *Хараат бус байдлын зарчим*-д үндэслэн гүйцэтгэх, гүйлээтэй холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй болгоход банкны удирдлагын зүгээс хичээн ажиллах нь зохистой засаглалын хэрэгжилтэд сайнаар нөлөөлнө.

6/Банкны санхүүгийн тогтвортой байдалд ноцтойгоор нөлөөлж болзошгүй эрсдэл;

7/Банкны бүтэц, зохион байгуулалт.
Энэ төрлийн мэдээлэлд удирдлага зохион байгуулалтын бүтцийн схем, бизнесийн төрөлжилт, салбар, нэгдэл болон удирдлагын хороодын талаарх мэдээлэ́л орно.

7.2.Банк нь шаардлагатай гэж үзвэл энэхүү журмын 7.1-д зааснаас бусад төрлийн өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг жилийн тайландаа тусгаж болно.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 311 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

УХИ0014

Мэдээллийн технологийн хяналт шалгалтын зөвлөмж

I. Мэдээллийн технологийн хяналт шалгалтын зорилго

Мэдээллийн систем нь санхүүгийн байгууллагын удирдлагад онцгой үүрэг гүйцэтгэнэ. Мэдээллийн системийн удирдлага оновчтой байдлаар зохион байгуулагдаж чадаагүй тохиолдолд, тухайн санхүүгийн байгууллагын хэрэглэгчдийн нийгэм эдийн засгийн орчин, компанийн бизнесийн үйл ажиллагаанд, цаашилбал Монгол Улсын эдийн засагт бүхэлд нь сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Банкны хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч Монголбанк нь банкуудын мэдээллийн системийн эрсдэлийн дотоод хяналтын тогтолцоог хянаж, санхүүгийн байгууллагуудын зохистой удирдлага, тогтвортой байдлыг хангах зорилготой ажиллана.

II. Мэдээллийн технологийн хяналт шалгалтын бодлого

Мэдээллийн технологийн хяналт шалгалт нь тухайн банкны удирдлага болон нягтлан бодох бүртгэлийн аудиторын үнэн зөв хөндлөнгийн хяналт дээр тулгуурлах бөгөөд “зах зээлийн сахилга бат”-ыг бэхжүүлэх үр дагавартай юм. Мэдээллийн системийн удирдлагын оновчтой эсэхийг тайлбарлах үүрэг зөвхөн тухайн санхүүгийн байгууллагад ногдох бөгөөд хяналт, шалгалт хийх талын хувьд тэдгээр тайлбар, нотолгоог шинжлэх байр сууринаас хандах ёстой болно.

Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэн, бэхжүүлэх явдал нь тухайн санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа зөв оновчтой явагдахад чухал ач холбогдолтой байдаг. Ийм учраас байгууллагын удирдлагын хувьд энэ ажиллагаанд идэвхи санаачлагатайгаар хандах шаардлагатай. Мэдээллийн системийн эрсдэл нь санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны гол эрсдэл нь болдог учир удирдлагын зүгээс үүнийг зөв тодорхойлон холбогдох арга хэмжээг авч байгаа эсэхийг хянах хэрэгтэй.

Санхүүгийн байгууллага нь мэдээллийн системийн эрсдэлийг хянахын тулд дотоод удирдлагын тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэх үүрэгтэй ажиллана.

Хяналт шалгалтын явцад хянан шалгагч нь тухайн байгууллагын мэдээллийн систем нь холбогдох хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шинжилж, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд чигэлсэн хяналт шалгалтыг явуулна. Мөн мэдээллийн системийн нэгж тус бүрийн оновчтой байдлыг харгалзахаас гадна, тухайн санхүүгийн байгууллагын удирдлагын тогтолцооны хүрээнд хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. Түүнчлэн, санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой байдал алдагдагдсан эсвэл эрсдэлийн удирдлагын тогтолцоонд хүндрэл учирсан тохиолдолд үйл явцыг нарийвчлан шалгах үүднээс гүйлгээ тус бүрийг шалгах шаардлагатай байдгийг анхаарах хэрэгтэй юм.

Шалгалтаар (i)Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагатай холбоотой бодлого боловсруулалт, (ii)Байгууллагын дотоод дүрэм, журам болон бүтэц зохион байгуулалтын бэхжилт, (iii)Системийн үнэлгээ, сайжруулалтын механизмын бүрдүүлэх тал дээр удирдлагын зүгээс оновчтой байдлаар зохион байгуулж буй эсэхийг шалгах замаар мэдээллийн системийн эрсдэлийн удирдлага холбогдох газар, нэгж дээр үр дүнтэй ажиллаж, удирдлага өөрийн үүрэг, хариуцлагаа биелүүлж байгаа эсэхийг шалгана.

Компьютерийн системийн гацалт, зүй бус программ (вирус), доголдол зэргээс болж санхүүгийн байгууллага хохирол учрах эрсдэл, компьютерийн зүй бус ашиглалтаас болж гарах хохирлын эрсдэл, мэдээллийн системийн стратеги бизнесийн стратегитэй үл зохицсоноос үүдэн гарах эрсдэл, мэдээллийн системийн хөрөнгө оруулалт болон технологи нь үр ашиггүй болох эрсдэл, мэдээллийн технологийн зардлын өсөлтөөс болж банкны санхүүгийн байдал муудах эрсдэл, мэдээллийн системийг нэвтрүүлэх болон боловсруулах үйл ажиллагаа амжилтгүй болсоноос үүдэн гарах мэдээллийн системийн ашиглалт, үр бүтээмж болон чанар муудах эрсдэл зэрэг мэдээллийн системийн олон төрлийн эрсдэл байдаг.

Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагыг шалгах явцад хянан шалгагч систем тус бүрийн онцлог, ач холбогдлыг ихээхэн анхаарч үзэх хэрэгтэй.

III. Мэдээллийн технологийн хяналт шалгалтын үзэл баримтлал, чиглэл

Мэдээллийн технологийн хяналт шалгалтын хувьд доорхи мэдээллийн системийн зорилтуудыг биелүүлэх үүднээс түүнд саад хориг болж байгаа мэдээллийн системийн эрсдэлийг бууруулах эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн эсэхийг шалгах шаардлагатай юм. Хяналт шалгалтын

ажлын хүрээнд мэдээллийн системийн эрсдэлийг нэгдсэн байдлаар хянах дотоод удирдлагын тогтолцоо, түүнчлэн эрсдэл тус бүрийн хүрээн дэх дотоод удирдлагын тогтолцоог хамааруулж ойлгоно.

a) Мэдээллийн системийн зорилт

1. Мэдээллийн системийн үр ашигтай байдал

Мэдээллийн систем нь бизнесийн болон стратегийн бодлого боловсруулалт, хэрэгжилтийн явцад үр ашигтай мэдээлэл болон үйл ажиллагаанд шаардлагатай функцээр хангана. Үүнд зорилгыг оновчтой томьёолсон байдал, цаг үеэ олсон байдал, ашиг тустай ба хэрэглээ сайтай байх зэрэг багтана.

2. Мэдээллийн системийн бүтээмж

Мэдээллийн системийн мэдээлэл, үзүүлж байгаа үйлчилгээ нь өндөр бүтээмжтэй эдийн засгийн үр ашигтай байна. Үүнд нөөцийн үр дүнтэй ашиглалтаас гадна системийн ирээдүйд хийгдэх өргөтгөл, бусад системтэй нийцэх уян хатан байдал мөн хамаарна.

3. Мэдээллийн системийн найдвартай байдал

Үүнд мэдээллийн системийн үзүүлэх мэдээлэл, үйлчилгээ нь тухайн мэдээллийн системийг зайлшгүй эх үүсвэрээ болгож байх явдал хамаарах бөгөөд энэхүү зорилтын хүрээнд мэдээллийн системийн үйлчилгээний үйл явц, үр дүнгийн алдаагүй, найдвартай байдал мөн багтана.

4. Мэдээллийн системийн аюулгүй байдал

Мэдээллийн систем нь байгалийн гамшиг, осол, системийн уналт, гэмт хэрэг, зүй бус хэрэглээ болон бусад аюулаас хамгаалагдсан байна. Энэхүү зорилтод нууцлал (гуравдагч этгээдэд нууц мэдээллийг задрахаас хамгаалах), бүрэн бүтэн байдал (системийн доголдол эсвэл зүй бус хэрэглээнээс үүдэн мэдээллийн цогц шинж чанар алдагдахаас сэргийлэх), бэлэн байдал (шаардлагатай үед хэрэгцээтэй мэдээлэл бэлэн байж, хэрэгцээт нөөцийг найдвартай эх үүсвэрээр хангасан байна).

5. Мэдээллийн системийн нийцтэй байдал

Мэдээллийн систем, түүнд холбогдох бизнесийн үйл ажиллагаа хууль, тогтоомж, санхүүгийн байгууллагын бодлого, ажиллагаатай нийцсэн байна. Түүнчлэн мэдээллийн систем болон холбогдох үйл ажиллагааны үйл явц нь эдгээр хязгаарлалтад нийцсэн байна.

b) Хяналт шалгалтын талбар

1. Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлага

Санхүүгийн байгууллагын бизнесийн орчин, бизнесийн стратеги байнга хувьсан өөрчлөгдөж байдаг тул мэдээллийн системийн эрсдэл мөн олон янз байдаг. Ийм нөхцөлд санхүүгийн байгууллага нь мэдээллийн системийн эрсдэлийг бизнесийн гол хүчин зүйл гэж үзэж, эрсдэлийг үнэлж, түүний хяналтыг зогсолтгүй найдвартай хэрэгжүүлж байх хэрэгтэй. Мэдээллийн технологийн эрсдэлийг бизнесийн эрсдэлийн гол хэсэг гэж үзэхийн зэрэгцээ байгууллагын хэмжээнд мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, эрсдэлийн үнэлгээ, түүнд тулгуурлан эрсдэлийн хяналтыг бий болгон хэрэгжүүлэх гэх мэт эрсдэлийн удирдлагын ерөнхий үйл явц нь үр ашигтай явагдаж байх нь зохистой.

2. Системийн аудит

Аудитын газар нь мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлага юуг хянаж шалгах гэж байгаагаа оновчтой тодорхойлж, аудитаар шалгах үзүүлэлтүүд болон аудитыг хэрэгжүүлэх шат дараалыг тодорхой тусгасан удирдамж, дотоод аудитын төлөвлөгөөг оновчтой боловсруулах хэрэгтэй юм. Дотоод аудитын шалгалтыг шалгуулж байгаа газар, нэгжээс хараат бус, бие даасан байдлаар улирал тутам хийх хэрэгтэй.

Бизнесийн үйл ажиллагааны эрсдэлийг танин мэдэх, зохистой удирдлагыг үнэлэх, эрсдэлийн удирдлагын үйл явцыг дэмжих зэрэг урьдчилан сэргийлэх ажлыг дотоод аудит гүйцэтгэнэ.

3. Мэдээллийн системийн удирдлага, төлөвлөлт

Санхүүгийн байгууллага нь үйл ажиллагааныхаа ерөнхий стратегид үндэслэн мэдээллийн системийн стратегийг төлөвлөж, түүнд тулгуурлан мэдээллийн системийн төлөвлөгөөг боловсруулдаг. Мөн мэдээллийн системийн төлөвлөгөөн дээр үндэслэн мэдээллийн системийг нэвтрүүлсэний дараа санхүүгийн байгууллага түүнийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах, системийн үр ашгийг үнэлэх зэрэг үйл ажиллагааг хийдэг. Эдгээр үндсэн үе шатыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж чадахгүй бол санхүүгийн байгууллагын мэдээллийн технологийн үйл ажиллагаа бүхэлдээ системийн үр ашиг, бүтээмжээ алдах ноцтой эрсдэлд орно. Мэдээллийн системийн стратеги төлөвлөлт, энэхүү стратегид тулгуурласан үйл ажиллагаа, мэдээллийн системийн төлөвлөлт болон төсвийн тооцоолол, удирдлагын тогтолцоо, шийдвэр гаргах үйл явц нь мэдээллийн системийн удирдлага төлөвлөлтийн хувьд гол хяналт болно. Ийм учраас эдгээр хяналтыг зохистой бүрдүүлэх шаардлагатай.

4. Мэдээллийн аюулгүй байдал

Мэдээллийн технологийн хөрөнгө, нууц мэдээллийг таньж, хянахын тулд санхүүгийн байгууллага аюулгүй байдлын бодлого, стандартыг боловсруулж, зүй зохистой зохион байгуулсан

хяналт дор тэдгээрийг аюулгүйн стандартад нийцсэн холбогдох мэдээллийн системд хэрэгжүүлэх хэрэгтэй. Тодруулбал, “байгууллагын хэмжээний аюулгүй байдлын удирдлага”, “барилга, тоног төхөөрөмжийн аюулгүйн арга хэмжээ”, “нууц зэрэглэлтэй мэдээ болон харилцагчийн талаархи өгөгдлийн удирдлага”, “хэрэглэгчийн хяналт” зэргээр дамжуулан биет болон хүний нөөцийн түвшин дэх аюулгүй байдлыг баталгаажуулах хэрэгтэй.

5. Мэдээллийн системийн боловсруулалт

Мэдээллийн системийн боловсруулалтын явцад үүсэх эрсдэлийн төрөл тус бүрийг зохистой байдлаар хянах ёстой. Бие даасан системийн боловсруулалт, томоохон системийн засвар үйлчилгээний хувьд өдөр тутмын энгийн ажил шиг бус харин төсөл хэлбэрээр (эхлэх, дуусах хугацаа тодорхой, өдөр тутмын ажлаас ялгаатай) хийнэ. Төслийн ажил дараах үе шатаас бүрдэх бөгөөд үе шат болгонд учирч болох эрсдлийг төсөл тус бүрт анхаарч хяналт тавина.

- Системийн шинжилгээ;
- Боловсруулалтын судалгаа;
- Системийн загварчлал;
- Програмын загварчлал;
- Програмчлал (кодчилол);
- Тест;
- Системийн шилжүүлэлт (суулгалт);
- Системийг шилжүүлсний дараах дахин хяналт;
- Үйлчилгээ, сайжруулалт.

6. Мэдээллийн системийн үйл ажиллагаа

Мэдээллийн системийг тасралтгүй, найдвартай ажиллуулахын тулд хяналтад суурилсан системийн үйл ажиллагааг зохистой хэрэгжүүлэх нь чухал юм. Эдгээрт мэдээллийн системийн үйл ажиллагаа, мэдээллийн системийг ажиллуулж байгаа байгууллагын удирдлагын үйл явц зэрэгт тавих хяналт орно. Энэхүү хяналт нь үр ашигтайгаар хэрэгжиж байх шаардлагатай. Мэдээллийн системийн удирдлагын тогтолцоонд тавих хяналт шалгалтын бүрэлдэхүүнд одоо ашиглагдаж байгаа системээс гадна, нөөцийн систем, боловсруулалт болон шалгалтын явцад бий болсон систем багтана. Мэдээллийн системийн үйл ажиллагааны нөөцөд бүх техник, программ хангамж, үйл ажиллагаанд ашиглагдаж буй

бүх төрлийн тайлан маягт (хэвлэмэл болон хэвлэмэл бус байдлаар), мөн эдгээр нөөцөд тавигдаж буй хяналт хамаарна.

7. Мэдээллийн системийн ашиглалт

Мэдээллийн системийн хэрэглэгч газрын мэдээллийн системийн үйл ажиллагааны бүтэц, тоног төхөөрөмж, өгөгдлийн файл, карт (ID гэх мэт), терминалийн үйл ажиллагааны удирдлагын систем үр ашигтай хэлбэрээр зохион байгуулах нь зүйтэй. Зөвшөөрөлгүй хэрэглэгчийн зүй бус хандалт, мэдээллийг гаргаж авахад ашиглагдах бүх төрлийн хэрэгсэлийг зүй бусаар ашиглах явдалаас болж чухал мэдээллийн нууцлал алдагдах эрсдэл, хэрэглэгчийн зааврыг зохисгүй боловсруулснаас болон хэрэглэгчдийг сургалтад хамруулаагүйгээс шалтгаалан мэдээллийн системийн үр ашиг, хүчин чадал буурах эрсдэлд тавих хяналтыг мөн адил хэрэгжүүлнэ. АТМ, салбар зэрэгтэй холбогдон гарч ирдэг онцгой эрсдэлийн хяналтыг мөн харгалзсан байх хэрэгтэй.

8. Орц-гарцын үйл явц

Орц-гарцын үйл явцын үед орох мэдээллийн бүрэн бүтэн, үнэн, зөв, алдаагүй, шалгагдсан байдал нь маш чухал байдаг. Эдгээрийг хангах процедурыг бизнес үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байх хэрэгтэй эсвэл холбогдох мэдээллийн системд оруулж өгөх хэрэгтэй юм. Энэхүү хяналт нь үр ашигтай зохион байгуулагдаж, хэрэгжиж байх шаардлагатай.

9. Сүлжээ

Санхүүгийн байгууллагын мэдээллийн систем байгууллагын бүх хэсгийг хамарсан өргөн хүрээтэй байна. Санхүүгийн байгууллагын сүлжээг ашиглахаар гаднаас маш олон тооны хэрэглэгчид (чухал харилцагчид), аж ахуйн нэгж түүний мэдээллийн системд ханддаг. Сүлжээний аюулгүй, найдвартай, үр ашигтай байдлыг зохистой удирдлагын тогтолцоогоор хангаж, холбогдох мэдээллийн системд нэвтрүүлэн хэрэгжүүлнэ. Тухайлбал, тэдгээр нь сүлжээний системийг бүрдүүлэх нөөц, сүлжээний аюулгүй байдлын ажиллагаа, мэдээллийн хөрөнгийн удирдлага, тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа, мэдээллийн ашиглалтын үе шат болон процедур зэрэг болно.

10. Нөөцийн удирдлага

Мэдээллийн системийн хөрөнгө, нөөц болох техник хангамж, программ хангамж, өгөгдлийн сан (мэдээлэл) нь зохистой удирдлагатай байх ёстой.

11. Аутсорсинг

Санхүүгийн байгууллагууд системийн холбогдох үйл ажиллагаа (боловсруулалт, хадгалалт, ажиллагаа)-г илүү боловсронгуй болгох үүднээс өөрсдийн мэдээллийн системийн үйл ажиллагааны заримыг буюу бүхэлд нь ихэвчлэн мэдээллийн системийн интегратор зэрэг гадны мэргэжлийн компаниар гүйцэтгүүлдэг. Мэдээллийн системийн боловсруулалт, хадгалалт, өдөр тутмын ажиллагааны зарим хэсгийг эсвэл бүхэлд нь гадны мэргэжлийн байгууллагад хариуцуулах тохиолдолд, аутсорсингийн төлөвлөгөө (төлөвлөлт, сонгон шалгаруулалт, гэрээ байгуулах) болон аутсорсингийг хэрэгжүүлсний дараах зохион байгуулалт зэргийг өөрсдөө хариуцан явуулах тохиолдолд төлөвлөөгүй, гэнэт үүсч болзошгүй аутсорсингийн зориулалттай тусгай арга хэмжээ оновчтой хэрэгжүүлэх шаардлагтай.

12. Онцгой байдлын төлөвлөгөө

Урьдчилан таамаглаагүй гамшиг, гэмтэл, гэмт хэрэг, бусад үйл ажиллагаанаас болж компьютерийн төв, банкны төв болон салбарт ноцтой хохирол учирсан, санхүүгийн байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болсон үед тухайн байгууллагын үйлчилгээ зогсох хугацаа болон хамрах хүрээг багасгаж, бизнесийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн, системийг аль болох шуурхай сэргээхийг зорилго болгон онцгой байдлын төлөвлөгөөг боловсруулна. Энэхүү онцгой байдлын төлөвлөгөөг оновчтой байдлаар боловсруулан, түүний үр ашигтай байдлыг сургалт, дасгал явуулах замаар баталгаажуулсан байх хэрэгтэй.

13. Баримтжуулалт

Мэдээллийн тодорхойлолт, дамжуулалт, бичлэг зэргээс бүрдэх баримтжуулалтын үйл ажиллагаа нь мэдээллийн системийг боловсруулах, ашиглах, сайжруулах үед хяналтыг үр ашигтай байлгахад чухал үүрэгтэй. Энэ үйл ажиллагааг баримтжуулалтын зохицуулалтын стандарт, журамд заасны дагуу оновчтой зөв явуулах ёстой.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 5 дугаар сарын ...26...-ны өдрийн 311..... дугаар тушаалын 3 дугаар хавсралт (Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь иж бүрэн шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журмын IX хавсралт)

Банкны зохистой засаглалын хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний загвар

Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийг үнэлэх зорилгоор боловсруулсан тус загварыг "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх тухай журам"-тай хавсран ашиглана.

Уг загварт дурьдсан бодлого, аргачлалыг нь банкны үйл ажиллагааны цар хүрээ, онцлог, хэмжээтэй нийцэж байхаар боловсруулна. Жижиг банкуудын хувьд зохистой засаглалын зарим бодлого, аргачлалуудыг албан бус байдлаар хэрэгжүүлдэг бол томоохон банкууд илүү дэлгэрэнгүй, албаны баримт бичиг боловсруулан мөрдөх тохиолдол олонтой гарна. Иймд оновчтой, зохистой засаглалыг банкны үйл ажиллагаа, онцлогт тохируулан хэрэгжүүлбэл зохино.

I. Ил тод байдал

№	Тайлбар	Үнэлгээ
1	**Дараах мэдээллийг банкны цахим хуудас болон жилийн тайланд тусгах замаар олон нийтэд тайлагнадаг эсэх**	
(1)	**1/ Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан г.м** Аудитлагдсан санхүүгийн тайлан, холбогдох тайлбар, аудитын дүгнэлт тайлан г.м.	
(2)	**2/ Компанийн эрхэм зорилго:** Компанийн эрхэм зорилгоос гадна банкны бизнесийн үйл ажиллагаа, ажилчид албан хаагчид, удирдлагын ёс зүйн талаар баримтлах бодлого болон зохистой засаглалын талаар холбогдох үйл ажиллагааны журам, бодлого (*Тухайлбал, зохистой засаглалын тухай журам, эс үйл ажиллагааны бусад журамд зохистой засаглалын талаарх хэсгийг багтаасан эсэх, тэдгээрийн бодит хэрэгжилт, түүнчлэн дээрх журам, бодлогын хүрээнд ТУЗ-нь өөрийн үйл ажиллагааг дүгнэн үнэлж байгаа эсэх*)-ыг тодорхойлж боловсруулсан эсэх.	
(3)	**3/ Банкны дүрмийн санд хяналтын багц эсвэл томоохон хувийг эзэмшдэг хувь нийлүүлэгчдийн нэрс тэдгээрийн талаарх мэдээлэл** Банкны шийдвэр гаргалтад голлох үүрэг гүйцэтгэх хувь нийлүүлэгчдийн хувьцаа эзэмшлийн байдал, саналын эрх, хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад ажиллаж байгаа голлох хувь нийлүүлэгчдийн талаарх мэдээлэл.	

(4)	**4/Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын боловсрол, ажлын туршлагын талаарх мэдээлэл** - ТУЗ-ийн бүтэц (*Тухайлбал ТУЗ-ийн журам, гишүүдийн тоо, гишүүнчлэл, гишүүдийг сонгох аргачлал, гишүүдийн бие даасан байдлыг тодорхойлох шалгуур үзүүлэлт, банкны үйл ажиллагаанд ихээхэн нөлөөлж болох гүйлгээ, бусад үйлдлийг хийх материаллаг/биет/ сонирхол байгаа эсэх,* - *ТУЗ-ийн дэргэдэх хороод, түүний гишүүнчлэл, дүрэм, хүлээх үүрэг, хариуцлагà*) болон гүйцэтгэх удирдлагын бүтэц (*òухайлбал, үүрэг хариуцлага, ТУЗ-д тайлагнах журам/аргачлал, боловсрол, ажлын туршлага*)-ийн талаарх мэдээллийг олон нийтэд танилцуулж байгаа эсэх, - Банкны зүгээс цалин, урамшуулалтай холбоотой мэдээллийг (*Тухайлбал, цалин урамшууллын бодлого, дарга, захирлуудын авах нөхөн төлбөр, бонус/урамшуулал, банкны ðóâü íèéë¿¿ëñýí õºðºíãºä хувьцаа эзэмшдэг эсэх г.м*) нээлттэй түгээж байгаа тохиолдолд тус банкны ил тод байдлын түвшин сайн ãýæ ¿çíý.	
(5)	**5/ Банкны холбогдох этгээдэд олгосон зээл болон түүнтэй адилтгах актив хөрөнгийн талаар (баталгаа, аккредитив гм)** Банкны дүрмийн сангийн ихээхэн хувийг эзэмших хувь нийлүүлэгчид, тэдгээрийн холбогдох этгээд, ТУЗ-ийн гишүүдийн хооронд хийгдсэн их дүнтэй гүйлгээг Хараат бус байдлын дүрэм (*Arm's Length Rule*)-ийн дагуу хийж байгаа чадаж байгаа эсэх	
(6)	**6/ Банкийг төлбөрийн чадварын хүндэлд оруулж болзошгүй их хэмжээний зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийг олгосон эсэх**	
(7)	**7/ Үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт** Удирдлагын бүтэцийг харуулсан схем, үйл ажиллагаа явуулах бизнесийн салбар, салбар нэгж, удирдлагын түвшинд ажиллах хороод,	

II. Хувь нийлүүлэгчдийн бүтэц

№	Тайлбар	Үнэлгээ
1	**Гэр бүлийн гишүүд хамтран эзэмшдэг банк буюу "Хаалттай" бүтэцтэй банк**	
(1)	• Хяналтын багцыг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчдээс зохистой засаглалын хэрэгжилтэд саад учруулж байгаа эсэх, • Банкны үйл ажиллагааны нэгж, ялангуяа ТУЗ нь жинхэнэ утгаараа үүргээ гүйцэтгэж байгаа эсэх, • Дүрэм журам, зөвлөмж боловсруулсан боловч хэрэгжилт нь дутагдалтай байгаа тохиолдîл байгаа эсэх, • Тус банкинд "*Хаалттай*" бүтэцтэй банкинд үүсдэг дараах нийтлэг дутагдлууд ажиглагдаж байгаа эсэх. Үүнд: - Үүсгэн байгуулагчид нь гүйцэтгэх удирдлагын үүргийг удаан хугацаанд хашиж байгаа, - Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд нэг хүний шийдвэр хэт их давамгайлдаг, - Зарим хувь нийлүүлэгчдэд давуу тал олгох, их хэмжээний санхүүжилт	

	удаан хугацаанд олгох,	
(2)	1(1)-д заасан дутагдàл илэрсэн үед хувь нийлүүлэгчид болон ТУЗ нь банкны үйл ажиллагаанд эрсдэл учирч байгааг ойлгож байгаа эсэх,	
(3)	1(1)-дахь үүссэн эрсдэлийг арилгах зорилгоор банкны зүгээс зохистой арга хэмжээ авч байгаа эсэх. Тухайлбал, ТУЗ болон аудитын хорооны бүрэлдхүүнд бие даасан гишүүнийг томилон ажиллуулах, эсвэл ТУЗ-ийн зүгээс банкны үйл ажиллагаанд оновчтой чиглэл өгч ажиллуулж байгаа эсэх,	
2	**Банк нь өөр хуулийн этгээдийн ðàðàà̀ áîëîí охин компани эсэх**	
(1)	• Банк нь групп/нэгдэл-ийн салбар эсвэл ðàðàà̀ áîëîí охин компани эсэх, • Хэрэв тийм бол толгой компанийн ТУЗ-өөс банкийг Зохистой засаглалын зарчмын дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхүйц стратеги, бодлогоор хангадаг эсэх, түүнчлэн групп компани, түүний салбар болох банкны удирдлага, зохион байгуулалтын бүтэц нь зохистой засаглалыг хэрэгжүүлэхэд тохиромжтой эсэхэд оновчтой үнэлэлт өгч байгаа эсэх	
(2)	• Толгой компанийн гүйцэтгэх удирдлага эсвэл ТУЗ нь Зохистой засаглалын зарчимд заасны дагуу үүргээ оновчтойгоор хэрэгжүүлэхэд учирч болох биет эрсдэл болон эрсдэл үүсгэх хүчин зүйлñийн талаарх ойлголт сайн эсэх нь чухал бөгөөд сайтар ойлгосон эсэх? Түүнчлэн толгой компанийн ТУЗ-ийн зүгээс салбар банкны үйл ажиллагааг тогтвортой явуулахын тулд шаардлагатай арга хэмжээ авах, оновчтой бодлого баримтлан ажиллаж байгаа эсэх?	
(3)	• Банкны ТУЗ нь банкинд Зохистой засаглалын зарчимд үл нийцэх тохиолдîл илэрсэн гэж үзвэл толгой компанийн ТУЗ-аас өгсөн чиглэлээс үл хамааран банкны төлбөрийн чадвар болон тогтвортой байдал, хадгаламж эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах арга хэмжээг хугацаа алдалгүй авах үүргийг ухамсарлаж буй эсэх? Түүнчлэн банкны ТУЗ нь банкны үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхэд хяналт тавин ажилладаг эсэх?	
(4)	• Санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэггүй групп/нэгдлийн охин компани хэлбэрээр ажиллаж байгаа банкны хувьд аюулгүй, тогтвортой үйл ажиллагааг эрхлэх нөхцлийг хангах нь нэн чухал юм бөгөөд энэ талаар толгой компани болон банкны ТУЗ нь мэдлэг сайтай байгаа эсэх?	

III. Хувь нийлүүлэгчдийн зохистой удирдлага

№	Тайлбар	Үнэлгээ
1	**Хувь нийлүүлэгчид нь өөрт олгогдсон эрхээ бүрэн утгаар нь хэрэгжүүлж байгаа эсэх**	
(1)	• Банкны хувь нийлүүлэгчид нь эзэмшиж буй хувьцааны хэмжээтэй дүйцэх эрх мэдлийг бодитойгоор хэрэгжүүлдэг эсэх, эзэмшиж буй хувьцаагаа хуулийн дагуу бусдад чөлөөтэйгээр худалдан борлуулах, шилжүүлэх эрхээр бүрэн хангагдсан эсэх?	
(2)	• Хувь нийлүүлэгчид нь банкны хувь нийлүүлэгчдийн хуралд идэвхтэй	

	оролцож, хөндөгдөж буй асуудлуудад олгогдсон эрхийнхээ дагуу саналаа өгөх замаар банкны удирдлагын үйл ажиллагаанд оролцдог эсэх? Дээрх эрхийг хэрэгжүүлэхэд, дараах нөхцөёийг хангасан эсэх. Үүнд: - Банкны хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах дотоод журамд хувь нийлүүлэгчдийг хуралд бэлтгэхэд шаардлагатай хугацаагаар хангах талаар тодорхой заасан, - Хувь нийлүүлэгчдийн хуралд оролцох иргэд, аж ахуйн нэгж болон эрх барих байгууллагын төлөөлөгчдийн жагсаалтыг хувь нийлүүлэгчдэд урьдчилан хүргүүлсэн, - Хурлын тов, он сар өдөр, болон хурал болох газрыг хувь нийлүүлэгчдэд тохиромжтой байдлаар тогтоосон, - Хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах, хэлэлцэгдэх асуудлыг нэмж оруулах эрхээ хэрэгжүүлэхэд нь хувь нийлүүлэгчдэд саад учруулдаггүй,	
(3)	• Хувь нийлүүлэгчид нь ногдол ашиг хуваарилах үйл ажиллагаанд оролцох, ногдол ашгаа авах эрхээр хангагдсан эсэх? • Хэрэв тийм бол доорх нөхцлийг хангасан эсэх? - Банкны ногдол ашгийн хэмжээг тогтоох, хуваарилах аргачлалыг хувь нийлүүлэгчдэд нээлттэй, ил тодоор хэрэгжүүлж байгаа эсэх, - Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр, банкны дүрэм болон бусад хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол, компанид бүртгэлтэй байгаа цэвэр ашгийг ногдол ашиг хэлбэрээр хуваарилдаг эсэх, - Хувь нийлүүлэгчид нь ногдол ашиг хуваарилах болон ногдол ашгийн төлбөрийг шилжүүлэх дэлгэрэнгүй нөхцөлтэй танилцсан эсэх, - Ногдол ашгийн төлбөрийг шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн болон бусад төрлийн мэдээлэ́л нь хувь нийлүүлэгчдэд нээлттэй ил тод байгаа эсэх, - Хувь нийлүүлэгчид нь ногдол ашгийн төлбөрөө ямар нэгэн хүндрэлгүйгээр хүлээн авч байгаа эсэх, - Ногдол ашгийг тогтоосон цаг хугацаанд нь хуваарилах нөхцлийг бүрдүүлсэн эсэх, - Ногдол ашгийг тохиромжтой цаг хугацаанд хуваарилах боломжгүй байгаа тохиолдолд хувь нийлүүлэгчид нь хожим өөрсдийн хүссэн хугацаанд авах боломжоор хангагдсан эсэх,	
(4)	• Хувь нийлүүлэгчдийг компанийн талаарх мэдээллээр тогтоосон хугацаанд, тогтмол хангаж байгаа эсэх, • Мэдээллийг дараах байдлаар хангадаг эсэх? - Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх асуудлын талаар шийдвэр гаргахад шаардагдах баримт материалуудаар хувь нийлүүлэгчдийг хангасан эсэх, - Хувь нийлүүлэгчдийг компанийн үйл ажиллагааны талаар санал дүгнэлтээ хэлэх бололцоогоор хангах үүднээс жилийн тайланд компанийн үйл ажиллагаатай холбоотой шаардагдах мэдээллийг тусгасан эсэх, - Банкны үйл ажиллагааны талаар хувь нийлүүлэгчдэд мэдээлэх	

	үүрэгтэй этгээд *(тухайлбал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга)*-ийг томилон ажиллуулж буй эсэх,	
(5)	• Хувь нийлүүлэгчдийг өөрт ногдсон эрхээ урвуулан ашиглахыг хориглосон эсэх, • Хувь нийлүүлэгчдийн зүгээс банк болон бусад хувь нийлүүлэгчдэд хохирол учруулахаар үйлдэл, эс үйлдэл хийсэн эсэх,	
2	**Ижил төрлийн хувьцаа эзэмшиж буй хувь нийлүүлэгчдэд тэгш эрхтэйгээр хандаж байгаа эсэх**	
(1)	• Хувь нийлүүлэгчдийн банкинд итгэх итгэлийн сайжруулах зорилгоор хувь нийлүүлэгчдэд тэгш байдлаар хандаж байгаа эсэх? • Эрхийн тэгш байдлыг дараах байдлаар хангасан эсэх. Үүнд: - Хувь нийлүүлэгчдийн хурлыг зохион байгуулахад, хувь нийлүүлэгчдийг санал гаргах, хэлэлцэгдэж буй асуудлын талаар лавлагаа хийх боломжоор адил тэнцүү байдлаар хангасан эсэх, - Дотоодын болон гадаадын хувь нийлүүлэгчид нь саналын хуудас болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан саналаа өгөх эрхээр хангагдсан эсэх, - Банкны хувьцааны арилжаанд давуу тал үүсгэх, хувьцааны үнэд нөлөөлөхөөр нууцын зэрэглэлтэй мэдээллийг нээлттэй болгохыг хориглодог эсэх, - Банкны ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирлыг сонгох, томилох үйл ажиллагаа нь хувь нийлүүлэгчдэд нээлттэй явуулдаг эсэх, холбогдох мэдээллээр хангаж байгаа эсэх, - Банкны удирдлага, гүйцэтгэх захирал болон бусад сонирхлын зөрчил үүсгэх арилжаа, гүйлгээг хийснээр холбогдох этгээд болох боломжтой ажилчид нь өөрсдийн талаарх мэдээллийг хувь нийлүүлэгчдэд нээлттэй болгодог эсэх, - Банк, хувь нийлүүлэгч болон бусад хувь нийлүүлэгчдийн хооронд үүсэх сонирхлын зөрчил үүсч болохоор нөхцөл, тохиолдол бүрт банкны зүгээс шаардлагатай арга хэмжээг авч байгаа эсэх,	

IV. Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)- ийн эрх, үүрэг

№	Тайлбар	Үнэлгээ
1	**ТУЗ-ийн гишүүд эрх, үүргээ ухамсарлаж байгаа эсэх**	
(1)	• ТУЗ-ийн гишүүн нэг бүр нь банкны үйл ажиллагаа, удирдлагатай холбоотой асуудлын талаар шийдвэр гаргах эрх, үүрэгтэй гэдгээ ухамсарлаж байгаа эсэх? • Түүнчлэн, ТУЗ-ийн гишүүн нэг бүр банкны үйл ажиллагаа нь бизнесийн ёс зүйг баримтлан ажиллахыг урьтал болгож (*үнэт зүйлс, ёс зүйн хэм хэмжээ*), шаардлагатай арга хэмжээ аван ажиллаж байгаа эсэх, • ТУЗ-ийн гишүүн нь өөрийн үндсэн үүргийн дагуу, ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлыг банкны үйл ажиллагааны тогтвортой байдлыг урьтал болгон шийдвэрлэж байгаа эсэх,	
2	**ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаа хараат бус, шударга байдлаар явагддаг эсэх**	

(1)	• ТУЗ дэх гишүүдийн тоо нь оновчтой эсэх, түүнчлэн ТУЗ-ийн дарга, гишүүд нь банкны удирдлага, улс төр болон бусад гадны зохисгүй нөлөөнөөс үл хамааран шийдвэр гаргаж байгаа эсэх, • Түүнчлэн, ТУЗ-ийн гишүүд нь банкийг хууль бус үйл ажиллагаа явуулах, банк болон дийлэнх хувь нийлүүлэгчдийн ашиг сонирхолд хохирол учруулж болох том хувь нийлүүлэгчдийн хэт их нөлөөнөөс хамгаалах үүрэг хүлээсэн эсэх,	
(2)	• ТУЗ-ийн гишүүдийн тодорхой хувийг (2/3 бол илүү тохиромжтой) хараат бус гишүүдээс бүрдүүлсэн эсэх, • Хараат бус ТУЗ-ийн гишүүд нь Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан болон дараах шаардлагыг хангаж байгаа эсэх: - Банкны удирдлагад сүүлийн 3 жилд ажиллаагүй бөгөөд одоогоор тус банкинд ажиллаагүй байгаа, - Банкны хяналтын багцыг эзэмшдэг хувь нийлүүлэгчид болон гүйцэтгэх удирдлагатай, садан төрлийн болон ажил хэргийн (хамтран компани эзэмших гм) холбоогүй байгаа, - Банкны том үйлчлүүлэгч бус эсвэл том албан тушаал хашдаггүй (*Хэрэв тухайн харилцагчтай хийж нийт арилжаа, гүйлгээ нь банкны нийт активын 10-аас дээш хувийг эзэлж байгаа тохиолдолд тухайн үйлчлүүлэгчийг том үйлчлүүлэгчид тооцно*) байх,	
3	**ТУЗ-ийн гишүүдийн тоо**	
(1)	ТУЗ-ийн гишүүдийн тоо нь зохимжтой эсэх	
4	**ТУЗ-ийн боловсрол, чадвар**	
(1)	• ТУЗ-ийн гишүүд нь хараат бус, үнэнч шударга эсэх, түүнчлэн банкны удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих чадвартай, туршлагатай эсэх,	
(2)	• Банкны гүйцэтгэх удирдлага шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргахтай холбоотойгоор үүсч болох эрсдэл, алдаа дутагдал гаргах боломжтой эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх чадвар, туршлагыг ТУЗ-ийн гишүүд эзэмшсэн эсэх, • ТУЗ-ийн гишүүд нь банкны үйл ажиллагаа болон удирдлагын үйд ажиллагааг хянах хангалттай мэдлэг, боловсрол эзэмшээгүй гэж үзвэл шаардлагатай мэдлэгт гадны эх сурвалж, зөвлөх, багшийн тусламжтайгаар суралцаж байгаа эсэх,	
5	**Банкинд ажилладаггүй ТУЗ-ийн гишүүдийн боловсролын түвшин**	
(1)	• Банкнаас гадуурх ТУЗ-ийн гишүүд нь банкны бизнесийн талаар мэдлэгтэй байх шаардлагатай тул банкны зүгээс шаардлагатай сургалт, зөвлөгөөг явуулах ажлыг зохион байгуулах албан тушаалтныг томилон ажиллуулж байгаа эсэх (*тухайлбал, банкны гүйцэтгэх захирал, банкны ТУЗ-ийн гишүүн, болон банкны ажилчид гм*)	
6	**ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах**	
(1)	• ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах банкны дотоод дүрэм, журам нь нийтэд ил тод, ойлгомжтой эсэх, • ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах дүрэм нь гишүүдийн хараат бус, шударга байдал болон туршлага, чадварт тавигдах шаардлагын талаар тодорхой заасан эсэх	
(2)	• Одоогоор ТУЗ-д ажиллаж буй гишүүдийн мэдлэг, боловсролын түвшин,	

	ажлын туршлага нь банкны дотоод дүрэмд заасан ТУЗ-ийн гишүүдэд тавигдах зайлшгүй шаардлагыг хангасан эсэх, •	
(3)	• ТУЗ-ийн хурлын даргаар банкинд ажилладаггүй этгээдийг томилсон эсэх?	
7	**ТУЗ-ийн хурлыг зарлах, хуралдуулах**	
(1)	• ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулах журмыг боловсруулсан эсэх, • ТУЗ-ийн хурлын товыг зарлахдаа гишүүд хуралд хэлэлцэх асуудалд бэлдэх, бүрэн хэмжээгээр хамрагдахуйц байдлаар тогтоосон эсэх, • Түүнчлэн, ТУЗ-ийн хурлын ирцийн талаарх мэдээллийг нийтэд мэдээлэх нь ТУЗ-ийн ил тод байдлыг сайжруулах ач холбогдолтой бөгөөд энэ нь ТУЗ-ийн хурал үр ашигтай явагдаж байгаагийн илрэл болдог. Банкны зүгээс дээрх арга хэмжээг авч байгаа эсэх, • ТУЗ-ийн хурлыг сар бүр хуралдуулах нь тохиромжтой бөгөөд банкнаас ТУЗ-ийн хурлыг жилд 2-оос доошгүй давтамжтайгаар зарлан хуралдуулж байгаа эсэх, Хэрэв шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн яаралтай хурлыг дурын хугацаанд товлон хуралдуулдаг эсэх,	
(2)	• Банкинд тулгарч буй чухал асуудлуудыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэгдэх асуудлын жагсаалтад багтааж, үр ашигтайгаар хэлэлцэж байгаа эсэх, • ТУЗ-ийн гишүүн нэг бүр нь банкны удирдлагын үйл ажиллагааг зөв чиглүүлэх, хянах үүргийнхээ хүрээнд ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж буй асуудалд ул суурьтай хандаж, банкийг гүйцэтгэх захирлын хэт туйлширсан бодлого, үйлдлээс хамгаалах арга хэмжээ авч байгаа эсэх, • Хурлаар сонирхлын зөрчил үүсгэх магадлалтай арилжаа, гүйлгээ болон ТУЗ-ийн гишүүд, банкны гүйцэтгэх удирдлагын томилгоо, шагнал урамшууллын талаарх тайланд онцгой анхаарал хандуулж байгаа эсэх,	
(3)	• Банкны дотоод хяналтыг сайжруулах хүрээнд, тодорхой мөнгөн дүнгээс хэтэрсэн зээл олгох асуудлыг гүйцэтгэх удирдлагаас гадна, ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх талаар ТУЗ-ийн дотоод дүрэмд тусгасан, мөрдөж ажилладаг эсэх,	
8	**ТУЗ-ийн хурлын протокол**	
(1)	• ТУЗ-ийн хурлын протоколыг оролцсон этгээдийн гарын үсгээр баталгаажуулан, хадгалж байгаа эсэх**,** • ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн дараах асуудлын талаар хурлын протоколд тусгахдаа онцгой анхаарал хандуулан, шаардлагатай, тайлбар, дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргаж байгаа эсэх, Үүнд: - Эрсдэлийн удирдлага - Үүрэг даалгавар, дүрэм, журмын биелэлт - Хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах - Шударга бус байдал, тулгарч буй хүндрэл - Гаргасан шийдвэр, биелэлт • ТУЗ-ийн дотоод журам, хурлаар хэлэлцэгдсэн асуудалтай холбоотой нотлох баримт, материалуудыг протоколд хавсаргаж, хадгалах талаар тусгаж мөрдлөг болгон ажиллаж байгаа эсэх,	
(2)	• Аудитын хороо болон хяналтын зөвлөл нь ТУЗ-ийн хурлын протокол болон бусад шаардлагатай мэдээллийг гадны саадгүйгээр хүлээн авч,	

	ТУЗ болон банкны удирдлагын үйл ажиллагааг хянаж байгаа эсэх,	
9	**Бизнесийн бодлого, төлөвлөгөө боловсруулалт**	
(1)	• ТУЗ нь банкны эрхэм зорилгод хүрэх бизнес төлөвлөгөөг боловсруулдаг эсэх, • Түүнчлэн, ТУЗ нь банкны бизнесийн бодлогод тулгуурлан боловсруулсан бизнес төлөвлөөг банкны удирдлага, ажилчдад танилцуулах ажлыг зохион байгуулдаг эсэх, • Банкны эрхэм зорилго, бизнесийн бодлого болон бизнес төлөвлөгөөний төслийг банкны гүйцэтгэх удирдлагаас боловсруулж байгаа тохиолддолд ТУЗ-өөс нарийвчлан танилцаж, үнэлэлт дүгнэлт өгдөг эсэх, • ТУЗ-өөс банкны эрхэм зорилго, бизнесийн бодлого болон бизнес төлөвлөгөөний талаар банкны газар, хэлтэс бүрт дэлгэрэнгүй тайлбарлах ажил зохион байгуулдаг, газар хэлтэс нь сайтар ойлгож буй эсэх,	
10	**Хуулийн хэрэгжилтийг хянах**	
(1)	• ТУЗ нь банкны газар, хэлтсийн захирлуудын мэдлэг, чадвар дутагдаж буй ажилд туслалцаа үзүүлэх тогтолцоог боловсруулж, мөрдөн ажилладаг эсэх, ялангуяа банкнаас боловсруулан дүрэм, журам нь хууль òîãòîîìæòîé зөрчилдөж байгаа эсэх талаар хуулийн зөвлөх, хуульчаар үйлчлүүлэхэд туслалцаа үзүүлж байгаа эсэх,	
11	**Сонирхлын зөрчлийг шийдвэрлэх, зохицуулах**	
(1)	• Сонирхлын зөрчил үүсгэж болохоор арилжаа, гүйлгээг зохицуулах дүрэм, журмыг боловсруулсан эсэх, Тухайлбал, ТУЗ болон банкны зүгээс дараах сонирхлын зөрчил үүсгэх боломжит хувилбарууд, авах арга хэмжээний талаар тусгасан эсэх, Үүнд: - Банкны ажилòàí, зээлийн эдийн засагч, захирал, хяналтын багцыг эзэмшигч хувь нийлүүлэгчдэд зээл олгох, - Банкны аль нэг үйл ажиллагаа хариуцсан захирлын эзэмшдэг, эсвэл холбоотой аж ахуйн нэгжтэй харилцаа тогтоох, - Банк нь санхүүгийн нэгдэлд хамаарагддаг тохиолдолд тус нэгдлийн аль нэг ðàðàà òáîëîí охин компанитай харилцаа тогтоох, • ТУЗ-ийн аль нэг гишүүн (гишүүд)-ний сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг хурлаар хэлэлцэж санал хураах үед дээрх гишүүн (гишүүд)-ий саналын эрх нь эцсийн шийдвэрт нөлөөлөхөөр байвал түүний холбогдох асуудлын талаар санал өгөх эрхийг түдгэлзүүлдэг эсэх,	
12	**Хараат бус байдал (Arm's length)-ийн дүрэм**	
(1)	• Сонирхлын зөрчил үүсгэж болохоор арилжаа, гүйлгээ нэг бүрийг (*Банкны сонирхлын зөрчлийн талаар баримтлах бодлогоор зөвшөөрөхөөс бусад тохиолдолд*) хараат бус байдал (Arm's length)-ын дүрмийн дагуу хийдэг эсэх,	
13	**Хяналт шалгалтын байгууллагад тайлагнах**	
(1)	• Сонирхлын зөрчил үүсч болохоор эсвэл үүссэн чухал тохиолдлууд гарах тухай бүрт хяналт шалгалтын байгууллагад мэдэгддэг эсэх (Монголбанк),	
14	**Банкны гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулахад тавигдах шаардлага, нөхцөл**	
(1)	• Банкны гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулахад тавигдах	

	шаардлага, нөхцлийг боловсруулсан эсэх • Банкны одоогийн гүйцэтгэх удирдлага нь дээрх шаардлагыг хангаж байгаа эсэх,	
15	**Хувь нийлүүлэгчдэд олгосон шагнал урамшууллын талаарх мэдээллийг нийтэд нээлттэй болгох**	
(1)	• Банкнаас хувь нийлүүлэгчид болон гүйцэтгэх удирдлага (гүйцэтгэх захирал гм)-д олгосон шагнал урамшууллын хэмжээг нийт хувь нийлүүлэгчдэд жил бүр мэдээлдэг эсэх,	
16	**Хяналт, мониторинг**	
(1)	• Банкны гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хянах, дүгнэх тогтолцоо боловсруулан, мөрдөн ажиллаж байгаа эсэх, • Дээрх тогтолцоо нь банкны үйл ажиллагааны онцлогт тохирсон, оновчтой эсэх, • Дээрх тогтолцоо нь хэрэгжих, үр дүнгээ өгч байгаа эсэх,	
(2)	• Банкны гүйцэтгэх удирдлагаас ТУЗ-ийн хуралд танилцуулж буй сар, улирал, жилийн тайлантай танилцахдаа гишүүд нь удирдлагын үйл ажиллагааны үр дүн, үйл явц, үүрэг даалгаварын биелэлт болон эрсдэлийн удирдлагын талаарх асуудалд онцгой анхаарал хандуулдаг эсэх, • ТУЗ-ийн гишүүд дээрх тайланд хангалттай мэдээллийг тусгаагүй гэж үзвэл, холбогдох нэмэлт мэдээлэл, тайлангуудыг гаргуулдаг эсэх, • Шаардлагатай тохиолдолд ТУЗ нь банкны гүйцэтгэх удирдлагаас гадна гадаад, дотоод аудитор зэрэг бусад холбогдох албан тушаалтнуудаас мэдээлэл, тайлан гаргуулж шийдвэр гаргалтандаа ашигладаг эсэх,	
17	**Хууль тогтоомжèéã ñàõèí áèåë¿¿ëýõ, хэрэгжилт (Compliance)**	
(1)	• Хууль тогтоомжèéí хэрэгжилт нь банкны гүйцэтгэх удирдлагын үнэнч шударга байдал, ажлын чадвартай нягт холбоотой гэдгийг ТУЗ-ийн гишүүн бүр ухамсарласан эсэх, • ТУЗ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар баримтлах бодлого боловсруулсан эсэх, банкны ажилòàí дээрх бодлогын талаар сайтар ойлголттой эсэх,	
(2)	• ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь хууль журмын õýðýãæèëòèéí талаар дотоод журам эсвэл холбогдох асуулгыг боловсруулсан эсэх, • Дээрх журам болон асуулга нь эрх зүйн актуудтай нийцэж байгаа эсэх, • ТУЗ болон гүйцэтгэх удирдлагаас хууль журмын сахилтыг хянах үүрэгтэй ажилтíûг томилон ажиллуулж байгаа эсэх,	
(3)	• Хууль журмыг сахих талаар бодлогын хүрээнд дотоод журам болон асуулгын хүснэгтэд дараах зүйлсийг тусгасан эсэх. Үүнд: - Банкны хууль, журмын хэрэгжилтийг хангуулах газар, хэлтэс болон ажилтнуудын хүлээх эрх, үүрэг, хариуцлага, - Банкны хууль, журмын хэрэгжилтийг хангуулах газар хэлтэс, ажилòíû боловсрол, чадвар, туршлагын хувьд тавигдах шаардлага, - Банкны хууль, журмын хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цуглуулах, шинжлэх, удирдах талаар зөвлөмж боловсруулсан эсэх, - Мониторинг, хяналттай холбоотой зөвлөмж,	

	- Шинээр эсвэл өөрчлөлт оруулж буй журам болон бусад актыг хууль эрх зүйн актуудтай нийцүүлэх зөвлөмж, - Ажилòíû сургалт, мэргэжил дээшлүүлэх талаарх зөвлөмж, - Баримт, бичиг бүртгэх, хадгалах зөвлөмж, - Зах зээлд гаргах шинэ бүтээгдхүүн боловсруулах зөвлөмж, - ТУЗ болон аудитын хороонд ажил тайлагнах талаар зөвлөмж	
(4)	• Банкинд хянан нийцүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотойгоор газар хэлтэс бүрт хянан нийцүүлэх хэлтэс/ажилтантай харилцах ажилтанг томилон ажиллуулж байгаа эсэх,	
(5)	• ТУЗ нь гүйцэтгэх удирдлага болон хянан нийцүүлэх хэлтсээс хууль тогтоомжийн хэрэгжилтийн гарын авлагыг гаргуулан авсан эсэх, • ТУЗ нь дээрх гарын авлагыг дагаж мөрдөх талаар банкны бүх нэгж, ажилòàíä шаардлага тавьдаг эсэх, • Хууль тогтоомжийн хэрэгжилтийн гарын авлагад дараах зүйлсийг тусгасан эсэх, Үүнд: - Холбогдох хууль, журмын талаарх тайлбар, - Хууль, журам хянан нийцүүлэхтэй холбоотой ямар нэгэн хүндрэл гарсан тохиолдолд авах арга хэмжээ,	
(6)	• ТУЗ болон гүйцэтгэх удирдлагаас банкны хянан нийцүүлэх тогтолцоо нь үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхэд холбогдох хяналтыг тавьдаг эсэх, • Банкинд одоогоор хэрэгжиж буй хянан нийцүүлэх систем нь учир дутагдалтай, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа тохиолдолд ТУЗ болон гүйцэтгэх удирдлагаас дээрх хүндрэлүүдийг арилгах талаар шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч байгаа эсэх,	
18	**Мөнгө угаалтын асуудал**	
(1)	• Мөнгө угаалтын эсрэг авах арга хэмжээний талаар дотоод журам, асуулга боловсруулсан эсэх, • Дээрх эрх зүйн баримт бичиг нь хууль зүйн зохицуулалттай нийцэж байгаа эсэх, • Дээрх журам, асуулгын талаар холбогдох газар хэлтэс, ажилчид нь нарийн ойлголттой байгаа талаар ТУЗ-аас хяналт тавьдаг эсэх, • Мөнгө угаалтын асуудал хариуцсан ажилтан ТУЗ болон гүйцэтгэх удирдлагаас томилон ажиллуулдаг эсэх, • Мөнгө угаалтын талаарх журам, асуулгад дараах асуудлыг тусгасан эсэх, Үүнд: - Мөнгө угаалтын эсрэг авах арга хэмжээний талаарх зөвлөмж, - Мөнгө угаасан үйлдэл илэрсэн тохиолдолд авах шаардлагатай арга хэмжээний талаар зөвлөмж (тухайлбал, дансны гүйлгээг хаах, гм) - Мөнгө угаалтын талаар банкны холбогдох нэгжид тайлагнах зөвлөмж - Холбогдох баримтыг бүртгэх, хадгалах зөвлөмж	
(2)	• Банкнаас мөнгө угаалтын талаар холбогдох газар, хэлтэс, ажилтнуудад сургалт явуулах, зөвлөмж өгөх арга хэмжээг авдаг эсэх, • Банк нь мөнгө угаалттай холбоотой сэжигтэй гүйлгээ болон харилцагчийг таньж чадаж байгаа эсэх, • Бүртгэгдсэн сэжигтэй гүйлгээний тоо нь бусад банктай харьцуулахад харьцангуй цөөн байгаа банкны хувьд сэжигтэй гүйлгээний талаар	

	нийтлэг тавигдах шалгуурыг ашиглах нь зохимжгүй байх талтай бөгөөд ТУЗ нь энэ талаар анхаардаг эсэх,	
19	**Шагнал, урамшуулал**	
(1)	• Банкны гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудын ажлын бүтээмжийг үнэлэхэд, тэдний хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар гаргасан үр дүн нь шийдвэрлэх хүчин зүйлñийн нэг болдог эсэх, • Тухайлбал, банкны ажилтнуудад олгох шагнал урамшууллаас өмнө нь эсвэл одоогоор хууль, журмын хэрэгжилттэй холбоотой зөрчил гаргасан ажилтнуудыг хасдаг эсэх,	
20	**Дотоод хяналт**	
(1)	• ТУЗ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд үр ашигтай дотоод хяналтын тогтолцоо, харилцагчдаа хамгаалах бодлого болон эрсдэлийн удирдлагыг бүрдүүлэх нь өндөр ач холбогдолтой талаар бүрэн ойлгож байгаа эсэх, • ТУЗ нь банкны бизнес төлөвлөгөөнд тулгуурлан дотоод хяналт болон дотоод аудитын талаар баримтлах бодлогыг боловсруулсан эсэх, • Хэрэв дээрх бодлогыг банкны гүйцэтгэх удирдлагаас боловсруулдаг тохиолдолд ТУЗ нь өөрийн үндсэн үүргийнхээ хүрээнд дээрх бодлоготой нарийн танилцаж үнэлэлт дүгнэлт өгдөг эсэх, • Түүнчлэн, ТУЗ-ийн зүгээс дээрх бодлогыг банкны ажилòàí, албан хаагчдад дэлгэрэнгүй танилцуулах ажлыг зохион байгуулдаг эсэх, • ТУЗ-аас банкны дотоод аудитын нэгж болон тус нэгжийн ажилтнуудыг дотоод аудитын журам боловсруулан ажиллахыг шаарддаг эсэх, • Дээрх журмыг банкны баримтлах дотоод хяналтын бодлоготой уялдуулж нягтлан судалсны үндсэн дээр ТУЗ-өөс баталж, мөрддөг эсэх,	
(2)	• Банкны удирдлага нь дотоод хяналтын бодлогод тулгуурлан дотоод хяналтын тогтолцоог оновчтой бүрдүүлсэн байгаа эсэхэд ТУЗ хяналт тавьдаг эсэх, • ТУЗ нь дотоод хяналтын үйл ажиллагаа хэвийн, үр ашигтай явагдаж байгаа талаар дотоод аудитын нэгжээс оновчтой хяналт тавьж байгаа эсэх хяналт тавьдаг эсэх, • Түүнчлэн дээрх шалгалтын тайлан, үр дүнгийн талаар ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад тайлагнадаг эсэх,	
(3)	• Банкны гүйцэтгэх удирдлага нь дотоод хяналтын тогтолцоонд учирч байгаа хүндрэлийг нээн илрүүлж, залруулах арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлж байгаа талаар ТУЗ-өөс хяналт тавьдаг эсэх, • ТУЗ нь банкинд учирч болох эрсдэлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл, ойлголттой эсэх, • ТУЗ нь хяналт шалгалтын байгууллагуудтай тогтмол, ойр дотно харилцаж (Жишээ нь Монголбанк), шаардлагатай тохиолдолд банкны тогтвортой үйл ажиллагааг явуулахад шаардагдах мэдээ мэдээллийг гаргуулах хүсэлтийг тавьдаг эсэх,	
21	**Гадаад аудитын үйл ажиллагаа**	
(1)	• Банк нь Олон улсын аудитын стандартын дагуу найдвартай, бие даасан гадаад аудит хийлгэдэг эсэх,	
(2)	• ТУЗ нь гадаад аудиторт тулгардаг дараах асуудлыг шийдвэрлэх арга	

	хэмжээг авдаг эсэх, Үүнд: - Гадаад аудитор нь мэргэжлийн талаар тавигдах стандартыг хангасан эсэх, - Гадаад аудитор нь банкинд аудит хийхдээ өөрийн үүргээ бүрэн ухамсарлаж байгаа эсэх, тухайлбал, шаардлагатай асуудалд мэргэжлийн үүднээс хандах гм - Гадаад аудит нь банкинд санхүүгийн аудит хийх замаар дотоод хяналтын хэрэгжилтийг дүгнэдэг, - Байнга аудит хийлгэдэг гадаад аудиторыг тодорхой давтамжтайгаар өөрчилдөг эсэх, - Гадаад аудитор нь банкны талаарх зарим асуудалд аудит хийлгэхдээ өөр аудитороор шалгуулж байгаа ч, бүрэн хариуцлага хүлээнэ гэдгийг ухамсарлаж байгаа эсэх,	
(3)	• ТУЗ нь гадаад аудитын үр дүнгээс гадна, дотоод хяналтын үнэлгээний үр дүнтэй давхар танилцдаг эсэх, • ТУЗ нь банкны дотоод хяналтыг сайжруулахад шаардагдах мэдлэг, чадвартай эсэх,	
(4)	• Банк нь гадаад улс оронд салбар нэгжтэй бол тэдгээрийг гадаад аудитад хамруулдаг эсэх,	
(5)	• ТУЗ нь банкны бүх газар, хэлтэс, нэгжийг гадаад аудиторуудтай хамтран ажиллах боломжоор хангаж байгаа эсэх,	
(6)	• ТУЗ нь тодорхой давтамжтайгаар гадаад аудитыг банкинд оновчтой явагдаж байгаа талаар хяналт тавьж, баталгаажуулж байгаа эсэх, • Банкны бусад салбар нэгжийг шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гадаад аудитад хамруулдаг эсэх,	
(7)	• Гадаад аудитын тайланд тусгагдсан санал зөвлөмж, банкны үйл ажиллагааны талаарх алдаа дутагдлыг засаж, залруулах арга хэмжээг заасан хугацаанд ТУЗ-өөс хэрэгжүүлж байгаа эсэх, • Гадаад аудитороос өгсөн саналыг хэрэгжүүлэх арга хэмжээг ТУЗ-өөс цаг алдалгүй авч байгаа эсэх, • Дээрх саналыг хэрэгжүүлэх үйл явцад дотоод аудитын газар, хэлтэс тогтмол хяналт тавьж байгаа эсэх,	
22	**Харилцагчдын эрх ашгийг хамгаалах**	
(1)	Харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах нь банкны биелүүлэх ёстой онцгой үүрэг бөгөөд дээрх асуудлаар шаардлагатай арга хэмжээ авахгүй тохиолдолд банк нь нэр хүндийн эрсдэлд орох магадлалтай. • ТУЗ нь банкны харилцагчдын эрх ашгийг хамгаалах, тэдний сэтгэлд нийцэх үйлчилгээ үзүүлэхийн ач холбогдлыг ухамсарласан эсэх, • ТУЗ нь банкнаас хэрэгжүүлж буй харилцагчдын эрх ашгийг хамгаалах арга хэмжээний талаар мэдээлэлтэй эсэх, тэдгээрийг сайжруулах арга хэмжээг тогтмол авдаг эсэх,	
(2)	• ТУЗ-өөс харилцагчдын эрх ашгийг хамгаалах бодлого боловсруулж, банкны ажилòíыг дээрх бодлогын талаар сайтар ойлголттой болгох талаар арга хэмжээ авдаг эсэх,	
(3)	• Дараах асуудлыг харилцагчдын эрх ашгийг хамгаалах бодлогод тусгасан	

	эсэх, Үүнд: - Харилцагчдаа таньж, мэдэх (зорилтот харилцагч нарыг хамруулдаг эсэх), - Бизнесийн нэр төрөл, - Харилцагчдад банкны бүтээгдүхүүн болон бусад холбогдох мэдээллийг өгөх аргачлал, - Харилцагчдын зүгээс ирүүлсэн санал дүгнэлтийг хүлээн авах, холбогдох арга хэмжээг авах талаар, - Харилцагчдын хувийн мэдээллийг хадгалах, аюулгүй байдлыг хангах талаар,	
(4)	• ТУЗ нь харилцагчдыг хамгаалах арга хэмжээний тайланг тодорхой давтамжтайгаар хүлээн авч, үнэлэлт, дүгнэлт өгдөг эсэх, • Шаардлагатай тохиолдолд банкны харилцагчдыг хамгаалах тогтолцоог сайжруулах арга хэмжээг тухай бүр авч байгаа эсэх,	
(5)	• ТУЗ-өөс харилцагчдыг хамгаалах бодлогод тулгуурлан банкинд хэрэгжүүлэх дотоод журам, гарын авлагыг боловсруулж ажилòíóóäàд танилцуулж, ойлгуулах арга хэмжээ авдаг эсэх,	
(6)	• Банкны харилцагчдыг хамгаалах асуудал хариуцсан ажилтны үүрэг хариуцлага, эрх үүргийг тогтоож, дээрх албан тушаалд шаардлага хангасан, боловсрол туршлагатай ажилтнûг томилон ажиллуулж байгаа эсэх,	
(7)	• ТУЗ нь харилцагчдын эрх ашигт нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлж, тэдгээрийн өөрчлөлтийн талаарх мэдээ тайланг хариуцсан ажилтнаар бэлдүүлэн тодорхой давтамжтайгаар эсвэл шаардлагатай хугацаанд тайлагнах тогтолцоог бүрдүүлсэн эсэх, • Ялангуяа, банк болон банкны харилцагчдын эрх ашигт ноцтойгоор нөлөөлөхөөр асуудлын үйл явцын талаар тодорхой давтамжтайгаар ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад тайлагнадаг эсэх,	
(8)	• ТУЗ нь аудитын хороо болон гадаад, дотоод аудиторуудаас ирүүлсэн тайланд үндэслэн харилцагчдын эрх ашгийг хамгаалах талаар банкнаас авч буй арга хэмжээний үйл явцад үнэлэлт дүгнэлт өгдөг эсэх, • Дээрх дүгнэлтэд үндэслэн, харилцагчдын эрх ашгийг хамгаалахад тулгарч буй хүндрэлийг илрүүлж, засаж залруулах арга хэмжээг боловсруулж байгаа эсэх,	
(9)	• Дээрх асуудлыг сайжруулах, залруулах талаар ТУЗ-өөс төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж байгаа эсэх,	
23	**Хороодууд**	
(1)	• Дараах хороодыг байгуулсан эсэх, Үүнд: - Эрсдэлийн удирдлагын хороо - Урамшууллын асуудал эрхэлсэн хороо - Аудитын хороо - Хүний нөөцийн хороо	
(2)	• Банкны хороо бүрт мөрдөгдөх дотоод журам, зааврыг боловсруулсан эсэх, • Дээрх заавар, жураìд дараах асуудыг тусгасан эсэх, Үүнд: - Хорооны гүйцэтгэх үүрэг	

	- Хорооны бүтэц, хороонд ажиллах хараат бус гишүүдийн тоо	
(3)	• Хорооны талаар баримтлах бодлого, журам зааврыг ТУЗ-өөс баталдаг эсэх,	
(4)	• Хороонд үндсэн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай эрх мэдлийг хэрэгжүүлэхийг ТУЗ-өөс зөвшөөрсөн эсэх, • ТУЗ-өөс хороонд ажиллах хангалттай мэдлэг туршлагатай, чадвартай ажилтнûг томилон ажиллуулсан эсэх,	
(5)	• Хорооны дарга, гишүүдийг тодорхой давтамжтайгаар сольдог эсэх,	
(6)	• Дээрх мэдээллийг банкны хувь нийлүүлэгчдэд нээлттэй байлгадаг эсэх,	
24	**Эрсдэлийн удирдлагын хороо**	
(1)	• Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүд нь дараах асуудлын талаар сайтар мэдлэгтэй эсэх, - Банкинд учирч болох төрөл бүрийн эрсдэл (жишээ нь, зээл, зах зээл, хөрвөх чадвар, үйл ажиллагаа, нэр хүндийн, болон бусад төрлийн эрсдэл) - Эрсдэл гарч болох банкны нэгж, газар хэлтэс - Эрсдэлийн учир шалтгаан - Эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, хяналт тавих аргачлал - Эрсдэлийн удирдлагын ач холбогдол	
(2)	• Эрсдэлийн удирдлагын хороо нь одоогийн эрсдэлийн удирдлагын үйл явцыг үнэлж, оновчтой эрсдэлийн удирдлагыг явуулах бодлого, тогтолцоог боловсруулдаг эсэх, • Тухайлбал, эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийг хэмжихэд ашиглаж буй загвар, судалгаа шинжилгээний хязгаарлагдмал, дутагдалтай талуудын талаар дэлгэрэнгүй мэдлэгтэй эсэх, • Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлагын талаар стратегийн бодлогыг боловсруулсан эсэх (тухайлбал, банк нь хэдий хэмжээний эрсдэл даах чадвартай эсэхийг тодорхойлох) • Дээрх бодлогыг боловсруулахдаа банкны балансын бүтэц (жишээ нь актив, пассив), өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон эрсдэлийн түвшинг харгалзан үзсэн эсэх, • Түүнчлэн, хороо нь дараах зүйлсýд анхаарал хандуулдаг эсэх. Үүнд: - Банкны орлого нь тодорхой эрсдэлийг дагуулж байдаг. Банкны зүгээс эрсдэлийг хамгийн бага байлгах, эсвэл эрсдэл өндөртэй боловч их хэмжээний орлого олох бодлогын аль чиг хандлагыг нь баримтладаг болох, - Банк нь орлогоо нэмэгдүүлэхэд хэт их анхаарч байгаа нь эрсдэлийн удирдлагын ач холбогдлыг бууруулах хандлагатай байгаа эсэх, - Банкны үйл ажиллагааны үр дүнг дунд болон урт хугацааны зорилттой холбон дүгнэх нь тохиромжтой боловч банк нь богино хугацааны зорилт дээр тулгуурлан үнэлэх хандлагатай байгаа эсэх,	
(3)	• Хороо нь банкны эрсдэлийн удирдлагын бодлогод тулгуурлан дотоод журам боловсруулж холбогдох ажилтнуудад танилцуулах, сургалт явуулах ажлыг хийдэг эсэх,	
(4)	• Дээрх журмыг хууль зүйн áóñàä акттай зөрчилдөхгүй байх тал дээр хорооны зүгээс анхаардаг эсэх,	

(5)	• Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн нэгдсэн удирдлагын ач холбогдлын талаар ойлголт сайтай эсэх, Эрсдэлийн нэгдсэн удирдлагаар бизнесийн төрөл бүрийн үйл ажиллагаанаас үүсэх нийт эрсдэлийг хэмжиж, банкны өөрийн хөрөнгийн хэмжээтэй уялдуулан хуваарилах асуудлыг шийдвэрлэдэг бөгөөд банкинд учирч болох эрсдэлийн төрлийг нэгтгэдэг (Зах зээлийн, зээлийн, үйл ажиллагааны гм) • Банкны эрсдэлийн нэгдсэн бодлогын талаар боловсруулсан баримт бичгийг банкны үйл ажиллагааны цар хүрээ, эрсдэлийн түвшинтэй зохицуулан боловсруулсан эсэх, • Тухайлбал, баримт бичигт дараах асуудлыг тусгасан эсэх, Үүнд: - Банкны эрсдэлийн удирдлагын нэгжийн үүрэг хариуцлага, - Эрсдэлийг нээн, илрүүлэх асуудлууд, аргачлал, - Эрсдэлийг лимитийг тогтоох, - Нэг төрлийн болон нийт эрсдэлийг хэмжих аргачлал, - Эрсдэлийг нэгдсэн хэмжээгээр үнэлэх аргачлалын бодитой эсэх талаар тодорхой давтамжтайгаар шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгдөг эсэх, - Шинэ бүтээгдэ́хүүн гаргахтай холбоотой асуудàл, - ТУЗ-д тайлагнах талаар, гýõ ìýò	
(6)	• Эрсдэлийн удирдлагын хороо нь банкны актив, пассивын эрсдэлийг удирдуулах зорилгоор Актив, пассивын удирдлагын хороо эсвэл ижил үүрэгтэй хороог байгуулан ажиллуулж байгаа эсэх, • Актив, пассивын хороо байгуулаагүй банкны хувьд тус хороог орлохуйц эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсруулсан эсэх,	
(7)	• Банк нь эрсдэлийн удирдлагын хороог байгуулахдаа бүтээгдэхүүн борлуулалт болон зээлийн газраас үл хамааран, бие даан үйл ажиллагаа явуулж болохуйцаар зохион байгуулсан эсэх,	
25	**Шинэ бүтээгдэ́хүүн**	
(1)	• Эрсдэлийн удирдлагын хороо нь банкнаас зах зээлд шинэ бүтээгдэ́хүүн гаргахын өмнө учирч болох эрсдэлийн талаар шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгдөг эсэх,	
(2)	• Шинээр зах зээлд гаргаж байгаа бүтээгдэ́хүүнд үйлчилгээнд тавигдах шаардлагыг тогтоох, бүтээгдэ́хүүн нь шаардлага хангасан эсэхийг шалгах үүрэгтэй ажилтнû хорооноос томилсон эсэх, • Эрсдэлийн удирдлагын хороо нь дээр заасан шаардлагын талаар холбогдох зөвлөмж, журмын заалтад тусгасан эсэх,	
(3)	• Эрсдэлийн удирдлагын хороо нь банкинд үүсч болох хямралыг нээн илрүүлэх, хямралын эсрэг авах арга хэмжээний оновчтой тогтолцоог бүрдүүлсэн эсэх, • Тухайлбал, дараах арга хэмжээг авдаг эсэх, Үүнд: - Банкинд ноцтой хохирол учруулах хямралын үед авах арга хэмжээний талаарх гарын авлага боловсруулах, - Бизнесийг тасралтгүй явуулах төлөвлөгөө боловсруулах, - Банкинд ноцтой хүндрэл учрах, хүндрэлийг арилгахад авах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулах тогтолцоог боловсруулах, - Хямралын үед ихэвчлэн гардаг цуурхал, сөрөг мэдээллийг залруулах,	

	арилгахад авах шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах,	
(4)	• Банкны эрсдэлийн удирдлагын хороо нь банкны өнөөгийн үйл ажиллагаа болон эрсдэлийн түвшингийн талаар холбогдох мэдээллийг тодорхой давтамжтайгаар эсвэл шаардлагатай тохиолдолд тухай бүрт цуглуулж, шинжилгээ хийдэг эсэх, • Дээрх шинжилгээний үр дүнд эрсдэлийн удирдлагын хороо нь дараах асуудлûн үр ашиг, найдвартай байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, шаардлагатай тохиодолд нэмэлт, өөрчлөлт хийж сайжруулахыг шаарддаг эсэх, Үүнд: - Бизнес төлөвлөгөө, - Дотоод хяналтын талаар боловсруулсан бодлого, - Бизнесийн стратегийн зорилт, - Эрсдэлийн удирдлагын бодлого, - Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах (compliance) бодлого, - Харилцагчдын эрх ашгийг хамгаалах талаар баримтлах бодлого гм	
(5)	• Эрсдэлийн удирдлагын хороонд тайлагнах, батлуулах шаардлагатай асуудлын талаар хороо нь санаа дэвшүүлдэг эсэх, • Түүнчлэн, дээр дурьдсан асуудал хариуцсан ажилтныг холбогдох тайланг эрсдэлийн удирдлагын хороонд тодорхой давтамжтайгаар эсвэл шаардлагатай тохиолдол бүрт тайлагнаж байхыг даалгасан эсэх, мөн эрсдэлийн удирдлагын хороо нь мэдээллийн тайлагнах оновчтой тогтолцоо бүрдсэн эсэх дээр давхар хяналт тавьж байгаа эсэх, • Ялангуяа, банкинд ноцтойгоор нөлөөлөхөөр байгаа асуудлын талаар ТУЗ, хороод болон гүйцэтгэх удирдлагад цаг алдалгүй мэдээлэх тогтолцоо бүрдсэн эсэх,	
(6)	• Дотоод аудитын нэгжээс банкны эрсдэлийн удирдлагад аудит хийхэд илэрсэн асуудлын талаар саналаа уламжилахыг эрсдэлийн удирдлагын хорооноос шаарддаг эсэх, Түүнчлэн эрсдэлийн удирдлагын хорооноос аудитын төлөвлөгөө болон хөтөлбөрийг баталдаг эсэх, • Тухайлбал, дотоод аудитын төлөвлөгөө болон хөтөлбөрт дараах асуудлыг тусгасан эсэх, Үүнд: - Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны одоогийн нөхцөл байдал, - Эрсдэлийн удирдлагын талаар баримтлах бодлого, дотоод журмын хэрэгжилтийн үйл явц, - Банкны эрсдэлийн удирдлага нь банкны үйл ажиллагааны цар хүрээ, онцлог, эрсдэлийн түвшинтэй уялдсан эсэх, - Банкны нэгдсэн эрсдэлийн үнэлгээнд ашиглаж буй аргачлалын сул тал, хязгаарлалт болон тооцооны нарийвчлал, - Нэгдсэн эрсдэлийг үнэлсний ач холбогдол, - Нэгдсэн эрсдэлийн үнэлгээнд ашиглаж буй тоо, мэдээллийн найдвартай, үнэн зөв эсэх, - Огцом хэлбэлзлийн шинжилгээнд (стресс тест) ашиглаж буй сценари (зохиомж) нь оновчтой эсэх, - Өмнө нь хийгдсэн дотоод аудитаас өгсөн санал, дүгнэлтийн хэрэгжилтийн үйл явц,	
(7)	• Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн нэгдсэн үнэлгээг хийхдээ	

	банкны салбар, нэгж болон голлох харилцагч байгууллагуудын эрсдэлийг харгалзан үздэг эсэх,	
(8)	• Эрсдэлийн удирдлагын хороо нь банкны эрсдэлийн удирдлагын үр ашигтай байдалд үнэлэлт, дүгнэлт өгөхдөө гадаад/дотоод аудитын тайлангаас гадна бусад холбогдох нэгжээс ирүүлсэн тайлантай танилцдаг эсэх, • Дээрх дүгнэлтээс үндэслэн эрсдэлийн удирдлагын хороо нь одоогийн ашиглаж буй эрсдэлийн удирдлагын аргачлалын сул, дутагдалтай талууд болон шалтгааныг илрүүлж чадаж байгаа эсэх, • Шаардлагатай тохиолдолд, эрсдэлийн удирдлагын хорооноос бие даасан, банктай холбоогүй гишүүдээр бүрдүүлсэн хяналтын хороог байгуулан дээрх шалтгааныг илрүүлэх ажлыг даалгадаг эсэх,	
(9)	• Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн тулгарч буй хүндрэлийг арилгах төлөвлөгөө боловсруулан, заасан хугацаанд хэрэгжүүлж байгаа эсэх,	
(10)	• Банкинд тулгараад буй хүндрэл нь цаашид банкны төлбөрийн чадварт ноцтойгоор нөлөөлөх, бий болох эрсдэлийг удирдахад хүндрэлтэй байгаатай холбогдуулан ТУЗ-өөс тухайн бизнес, ажил үйлчилгээ явуулахыг зогсоох, хумих талаар шийдвэрийг гаргахад эрсдэлийн удирдлагын хороо нь шаардлагатай тайлан мэдээгээр цаг алдалгүй хангадаг эсэх,	
(11)	• Банкны алдагдлын хэмжээ нь зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэнтэй холбоотойгоор ТУЗ-өөс банкны эрсдэлийг бууруулах, алдагдлын лимитийн хэмжээнд өөрчлөлт оруулах шийдвэрийг гаргахад эрсдэлийн удирдлагын хорооноос ТУЗ-д шаардлагатай мэдээ, тайлангаар цаг алдалгүй хангаж байгаа эсэх,	
26	**Урамшууллын асуудал эрхэлсэн хороо**	
(1)	• Урамшууллын асуудал эрхэлсэн хорооны гишүүн бүр нь өөрийн хүлээх үүрэг хариуцлагыг ухамсарласан эсэх,	
(2)	• Банкны урамшууллын бодлогыг банкны соёл, урт хугацааны бизнесийн стратеги төлөвлөгөө болон дотоод хяналтын орчинд тулгуурлан боловсруулдаг эсэх,	
(3)	• Банкны олох ашигт үндэслэн хувь нийлүүлэгч, гүйцэтгэх удирдлагад олгох урамшууллын хэмжээг тооцохдоо урт хугацаанд банкны үнэ цэнийг өсгөх зорилгыг харгалзан үздэг эсэх, • Түүнчлэн дээрх шийдвэрийг гаргахдаа ёс зүй, дотоод хяналтын ажиллагааны үйл явцыг харгалзан үздэг эсэх,	
27	**Аудитын хороо**	
(1)	• Аудитын хорооны гишүүн бүр өөрт оногдсон үүрэг хариуцлагаа ухамсарлаж буй эсэх, Аудитын хорооны үүрэгт банкны дотоод хяналтын үйл ажиллагааг дүгнэх, гадаад аудитын цар хүрээг тодорхойлох, гадаад аудит хийх аудиторыг дэвшүүлэх, батлах, Аудиторуудыг гүйцэтгэх удирдлагаас бусад ажилтнуудтай ууёзалт хийх, асуудлыг хэлэлцэх боломжоор хангах, гүйцэтгэх удирдлага болон гадаад аудиторуудтай хамтран жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт хийх болон хяналт	

	шалгалтын байгууллагуудтай уулзалт хийх зэрэг үйл ажиллагааг багтана.	
(2)	• Банк нь аудитын хорооны шударга, хараат бус байдлыг хангах зорилгоор хорооны гишүүдийн талаас доошгүй хувийг зохистой удирдлага, эрсдэлийн удирдлагын талаар гүнзгийн мэдлэгтэй, хараат бус, гадны ТУЗ-ийн гишүүдээс бүрдүүлж байгаа эсэх,	
(3)	• Аудитын хорооны гишүүд нь хангалттай туршлага, мэдлэг эзэмшсэн эсэх, • Тухайлбал, аудитын хорооны гишүүдийг аудит, нягтлан бодох бүртгэл болон тайлан мэдээний талаар өргөн мэдлэгтэй хүмүүсээс бүрдүүлэх замаар хорооны тэнцвэртэй үйл ажиллагааг хангаж байгаа эсэх, мөн хорооны нэгээс доошгүй гишүүд нь туршлагатай мэргэшсэн нягтлан бодогч (CPA) эсвэл санхүүч (CFO) байгаа эсэх,	
(4)	• Аудитын хороо нь ТУЗ-ийн гишүүд, гадаад, дотоод аудиторууд, хууль, журмын хэрэгжилт хариуцсан ажилòàí болон салбар компанийн ТУЗ-èéн гишүүдээс ирүүлэх тайлангаар байнгын харилцааа холбоо тогтоон ажиллах тогтолцоог бүрдүүлж буй эсэх,	
(5)	• Аудитын хороо нь гадаад аудиторыг томилох, шагнаж урамшуулах, чөлөөлөх талаар ТУЗ-д саналаа өгдөг эсэх,	
(6)	• Аудитын хороо нь дотоод аудит хийхэд гарах зардал, ач холбогдолд тулгуурлан банкинд хийгдэх аудитын цар хүрээ (жишээ нь дотоод хяналтын тогтолцооны үр ашигт дүгнэлт өгөх)-ний талаар нарийвчлан судалсан эсэх, • Аудитын хороо нь аудитын дүгнэлтэд тусгагдсан санал, шүүмжлэлд үндэслэн гүйцэтгэх удирдлагад дотоод хяналтын тогтолцооны сул талыг арилгах, залруулах талаар чиглэл өгдөг эсэх,	
(7)	• Банк нь áàíêíû íýãäýëä хамаарагдах эсвэл толгой компани болох тохиолдолд салбар, õàðààò áîëîí охин компанийн удирдлага, дотоод хяналтын системийн үйл ажиллагаа тогтвортой, үр ашигтай явагдаж байгаа талаар банкны аудитын хорооноос судалгаа хийдэг эсэх,	
(8)	• Аудитын хорооны гишүүд нь ТУЗ-ийн хуралд оролцох, гишүүдэд асуулт тавих замаар ТУЗ-ийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг эсэх, • Түүнчлэн, аудитын хороо нь шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн гишүүдийн эсрэг арга хэмжээ авдаг эсэх,	
(9)	• Аудитын хороо нь хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулж, банкны гүйцэтгэх удирдлагатай сайн харилцаа тогтоон ажилладаг эсэх,	
(10)	• ТУЗ-ийн гишүүн (гишүүд) нь хууль бүс үйлдэл хийсэн, эсвэл хийх магадлалтай гэж үзвэл аудитын хорооны гишүүн (гишүүд) нь хороо болон ТУЗ-д цаг алдалгүй мэдэгддэг эсэх, • Дээрх хууль бус үйлдэл нь банкинд сөргөөр нөлөөлөхөөр байгаа бол аудитын хорооноос шаардлагатай арга хэмжээг авч, хүндрэлээс зайлсхийж байгаа эсэх,	
(11)	• Аудитын хороон дахь гадны гишүүд нь хараат бус гишүүний үүргээ биелүүлэн ажилладаг эсэх,	
(12)	• Аудитын хорооны гишүүд ажил үүргээ биелүүлэхэд гадны мэргэжлийн туслалцаа шаардлагатай гэж үзвэл хуульч, мэргэшсэн нягтлан бодогч	

	зэрэг мэргэжилтний туслалцааг авч ашигладаг эсэх,	
28	**Хүний нөөцийн хороо**	
(1)	• Хүний нөөцийн хорооны гишүүн бүр өөрийн үүрэг хариуцлагыг ухамсарласан эсэх,	
(2)	• Хүний нөөцийн хороо нь ТУЗ-д нэр дэвшигчдийн талаарх шаардлагатай мэдээллийг итгэмжлэгдсэн хувь нийлүүлэгчдээс хүлээн авсан эсэх, • Дээрх мэдээллийг хүлээн аваад, нэр дэвшигчид нь банкнаас ТУЗ-ийн гишүүнд тавигдах шалгуур (хууль, банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны дүрэм гм)-ыг хангаж байгаа эсэхийг нягтлан шалгадаг эсэх, • Нэр дэвшигч нь банкнаас ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлагыг хангахааргүй байгаа бол хорооноос энэ талаар нэр дэвшигчид хариу мэдэгддэг эсэх, • ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулж байгаа тохиолдолд, нэр дэвшигчийн хараат бус гэдгээ нотолсон гарын үсэг бүхий баримтыг хороо хүлээн авч, дагалдах нотолгоог давхар шалгадаг эсэх, • Дээрх мэдээлэлд тулгуурлан, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрсийг баталгаажуулан ТУЗ-èéн хурлаар оруулдаг эсэх,	
(3)	• ТУЗ-ийн гишүүн нас барах, хуралд удаан хугацаагаар оролцох боломжгүй болсон тохиолдолд хүний нөөцийн хороо нь дараагийн хувь нийлүүлэгчдийн хурал хүртэлх хугацаанд орлон ажиллах гишүүнийг дэвшүүлэх үүрэг хүлээн ажилладаг эсэх,	
(4)	• Хүний нөөцийн хороо нь гишүүдийнхээ ажлын гүйцэтгэлийг дүгнэн хувь нийлүүлэгчдийн хурлаар танилцуулж, мэдээлэл өгдөг эсэх, уг мэдээлэлд хорооны хурлын ирцийн асуудлыг тусгасан эсэх,	
(5)	• Түүнчлэн, энэ хороо нь банкны гүйцэтгэх удирдлагад ажиллах хүмүүсийг дэвшүүлэх, холбогдох мэдээллийг цуглуулах, удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үүрэг хүлээдэг эсэх,	

V. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа

№	Тайлбар	Үнэлгээ
	Гүйцэтгэх удирдлага	
1	**Гүйцэтгэх удирдлага нь банкны үйл ажиллагааны талаар сайтар ойлголттой эсэх**	
(1)	• Гүйцэтгэх удирдлагын багт ажиллаж буй гишүүн бүр ТУЗ-өөс боловсруулсан банкны баримтлах бодлого, үйл ажиллагааны арга барилын талаар өргөн ойлголттой байгаа эсэх, • Гүйцэтгэх удирдлагын гишүүн бүр нь өөрт оногдох үүрэг хариуцлагаа сайтар ухамсарлаж буй эсэх,	
	Мэдлэг, чадвар	
(1)	• Гүйцэтгэх удирдлагын гишүүн бүр өөрийн хариуцаж буй ажлын салбартаа удирдах, хяналт тавихад шаардагдах мэдлэг чадвартай эсэх,	
(2)	• Гүйцэтгэх удирдлага нь бизнес төлөвлөгөө, дүрэм, журам (*жишээ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар*) болон банкны удирдлагын аргачлалыг боловсруулдаг эсэх,	
(3)	• Дээрх дурьдсан дүрэм, журам, аргачлалыг боловсруулахдаа ТУЗ-өөс	

	зөвшөөрөл авдаг эсэх, • ТУЗ-өөс зөвшөөрсөн тохиолдолд дээрх баримтуудыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэдэг эсэх,	
(4)	• Гүйцэтгэх захирлын банкны бизнесийн талаар баримтлах бодлого, бизнес төлөвлөгөө, дотоод хяналтын бодлого, стратеги болон эрсдэлийн удирдлагын бодлогод тулгуурлан банкны ажиллах хүчийг тохирсон ажил үүрэгт оновчтой хуваарилсан эсэх, • Гүйцэтгэх захирал нь тохиромжтой цаг үед өөрт ногдсон эрх мэдлээ хэрэгжүүлдэг эсэх,	
(5)	• Гүйцэтгэх захирал нь хууль, журам сахих, хэрэгжүүлэх болон харилцагчийн эрх ашгийг хамгаалах бодлогын ач холбогдлыг таниулах арга хэмжээ авдаг эсэх, Тухайлбал, гүйцэтгэх захирал нь баяр ёслолын арга хэмжээ болон менежерүүдийн хуралд тавих илтгэлдээ дээрх асуудлын талаар дурьдаж байгаа эсэх,	
	Дүрэм, журмын хэрэгжилт, мөрдлөг болгон ажиллах	
(1)	• Энэ загварын IV бүлэг (*ТУЗ-ийн хүлээх эрх, үүрэг*)-т дурьдсаны дагуу гүйцэтгэх удирдлагын зүгээс хууль, журмыг чандлан сахихын ач холбогдлын талаар нарийн ойлголттой бөгөөд холбогдох бодлого, дүрэмд үндэслэн гарын авлагыг боловсруулсан эсэх, • Дүрэм, журмыг чандлан сахихын ач холбогдол, түүнтэй холбоотой гарын авлага боловсруулсан талаар банкны ажилòíóóдад мэдээлэх, таниулах ажлыг хийсэн эсэх,	
(2)	• Энэ загварын IV бүлэг (ТУЗ-ийн хүлээх эрх, үүрэг)-т дурьдсаны дагуу гүйцэтгэх удирдлага нь дүрэм, журмын хэрэгжилтийг хариуцсан ажилтан томилох эсвэл тусгай нэгжийг байгуулан ажиллуулдаг эсэх,	
(3)	• Банкин дахь хууль журмын хэрэгжилтийн үйл явцад тодорхой хугацааны давтамжтайгаар шаардлагатай хяналтыг тавих эсвэл хяналтын тогтолцоог бүрдүүлсэн эсэх,	
(4)	• Гүйцэтгэх удирдлагад ирүүлсэн хууль журмын хэрэгжилттэй холбоотой мэдээллийн үнэн зөв эсэхийг хэрэгжилт хариуцсан ажилтан эсвэл нэгжээр шалгуулж байгаа эсэх, • Дээрх мэдээлэл нь үнэн, зөв гэдэг нь батлагдсан тохиолдолд хэрэгжилт хариуцсан нэгж, ажилтнаар холбогдох асуудалд хяналт, шалгалт хийдэг эсэх, • Гүйцэтгэх удирдлага нь банкинд сөргөөр нөлөөлөх хууль бус үйлдлийн талаар хэрэгжилт хариуцсан хэлтэс, ажилтнаар шалгуулж, холбогдох тайлантай танилцдаг эсэх, • Гүйцэтгэх удирдлагаас банкинд учирсан хүндрэлийг шалгуулахаар гуравдагч (*хараат бус*) талуудаас бүрдүүлсэн багаар шалгуулж тайлан гаргуулдаг эсэх,	
(5)	• Энэ загварын IV бүлэг (*ТУЗ-ийн хүлээх эрх, үүрэг*)-т дурьдсаны дагуу гүйцэтгэх удирдлага нь харилцагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг хариуцсан нэгж, ажилтнûг томилон ажиллуулж байгаа эсэх, • Гүйцэтгэх удирдлагаас дээрх ажлыг хариуцаж буй нэгж, ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж байгаа эсэх,	
2	**ТУЗ-д тайлагнах**	

(1)	• Гүйцэтгэх удирдлага нь банктай холбоотой асуудал (*тухайлбал, банкны ашигт ажиллагаа, харилцагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх аливаа асуудлууд*)-ын талаар ТУЗ-д тодорхой хугацааны давтамжтайгаар тайлагнах тогтолцоог бүрдүүлсэн эсэх,	
(2)	• Гүйцэтгэх удирдлага нь банкинд тулгарсан аливаа асуудлыг хариуцах захирлаас дээрх асуудлаар аудитын хороонд шууд мэдээлдэг байхаар зохицуулсан эсэх,	
3	**Дотоод хяналтын ач холбогдлыг ухамсарласан байдал**	
(1)	• Гүйцэтгэх удирдлага нь дотоод хяналтын ач холбогдлын талаар сайтар ойлголттой эсэх,	
(2)	• Гүйцэтгэх удирдлагаас дотоод хяналтын оновчтой тогтолцоог бүрдүүлсэн эсэх,	
(3)	• Дээрх тогтолцоог бүрдүүлэхдээ эрсдэл үүсч болох банкны удирдлага зохион байгуулалтын хэсгийг тодорхойлж, эрсдэл бий болсон тохиолдолд хүлээх алдагдлын хэмжээг урьчдилан судалсан эсэх, • Эрсдэлийг тооцохдоо алдагдлын хэмжээ болон харгалзах магадлалын түвшинд суурилдаг эсэх,	
(4)	• Гүйцэтгэх удирдлага нь банкинд дотоод хяналтын оновчтой тогтолцоог бүрдүүлснээр нь учирч болох эрсдэлээс сэргийлэх ач холбогдолтой гэдгийг ухамсарласан эсэх,	
(5)	• Дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлэх нь банкны үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангана гэдгийг гүйцэтгэх удирдлага ухамсарласан эсэх,	
(6)	• Дотоод хяналтын үйл ажиллагаа тогтвортой явагдаж байгаа тал дээр гүйцэтгэх удирдлагаас хяналт тавьдаг эсэх,	
(7)	• Гүйцэтгэх удирдлага нь банкны ажилòíыг сонирхлын зөрчилд оруулахгүй байх урьдчилсан арга хэмжээг авдаг эсэх, Тухайлбал, ажилòíы эрх мэдэл, ажил үүргийг оновчтойгоор хуваарилах, тухайн ажилòíы гүйцэтгэх ажлыг өөр ажилтнаар хянуулах буюу хянах эрх бүхий этгээдийг тогтмол сольж ажиллуулах нь сонирхлын зөрчилтэй холбоотой асуудал үүсгэхээс зайлсхийх аргуудын нэг юм.	
(8)	• Гүйцэтгэх удирдлага нь доор дурьдсан асуудлаас зайлсхийж байгаа эсэх. Үүнд: - Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хэт оролцох, шийдвэр гаргалтанд зохисгүй байдлаар нөлөөлөх, - Тухайн ажил үүргийг удирдахад шаардлагатай мэдлэг, чадварыг эзэмшээгүй хүнийг удирдах албан тушаалд томилох - Банкны өндөр ур чадвартайд тооцогдох "*Од*" ажилтны үйл ажиллагаанд хяналт тавих эрмэлзэлгүй, эсвэл боломжгүй байх, - Банкинд төлөвлөснөөс их хэмжээний ашиг оруулдаг ажилтныг алдах болгоомжлол бий болсон тохиолдолд тус ажилтанд хяналт тавих асуудал нь хүндрэлтэй болдог.	
(9)	• Зөрчлийг мэдээлэх тогтолцоо (*whistle blowing system*)-г гүйцэтгэх удирдлагаас боловсруулах, банкинд нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлж байгаа эсэх, • Зөрчил мэдээлэх тогтолцоо нь дараах шаардлагыг хангаж байгаа эсэх,	

	Үүнд: - Зөрчлийн талаарх тайлан мэдээг шаардлагатай ажилтнууд хүлээн авч танилцдаг эсэх - Зөрчлийн талаар мэдээлсэн этгээдийг гадуурхах, ялгавартай хандах, хохирол учруулахаас хамгаалах, - Мэдээллийг авсан дариуд дараагийн шатны арга хэмжээг авах шийдвэрийг гаргах, - Тогтолцоо нь хууль бус зорилго агуулсан мэдээллээс зайлсхийдэг, - Дээрх шаардлага нөхцөлийг баримтжуулан, заавар, журамд тусгаж, Банкинд танилцуулах, - Зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч буй ажилтан нь хууль, журмын хэрэгжилт хариуцсан хэлтсийн ажилтан, эсвэл аудитын хорооны гишүүд байхаас гадна гуравдагч тал (тухайлбал, хуульч) байж чадаж буй эсэх,	

VI. Дотоод хяналт

№	Тайлбар	Үнэлгээ
1	**Ойлголт**	
(1)	• Энэ загвар дахь дотоод хяналтын хэсгийг COSO (*Committee of sponsoring organizations of the treadway commission*)-ийн тайланд үндэслэн боловсруулсан. • Банкны ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон дотоод аудитор нь доор дурьдсан COSO-ийн тайлангуудын гол утга санааг ойлгож байгаа эсэх, Үүнд: *Дотоод хяналт нь банкийг дараах зорилòîд хүрэхэд хэрэгжүүлэх шаардлагатай үйл явц юм.* Банкны үйлчилгээний үр ашигтай, аюулгүй байдлыг хангах (*банкны активын чанарыг хангах*), Найдвартай санхүүгийн бүртгэл, тайлан, Хууль, журмыг сахин мөрдүүлэх, *Дотоод хяналт нь удирдлагын үйл явц бөгөөд дараах 5 бүрэлдýхүүн хэсгээс бүрдýíý.* - Хяналтын орчин - Эрсдэлийн үнэлгээ - Хяналтын арга хэрэгсэл - Мэдээлэл харилцаа - Хяналтын үнэлгээ /мониторинг/ - Дээрх хэсгийг банкны ТУЗ, гүйцэтгэх удирдлага, болон бусад ажилтнууд үр ашигтайгаар хэрэгжүүлэх нь банкны дотоод хяналтыг сайжруулíà. Банкны дотоод хяналтын орчин сайтай эсэх нь банкинд тухай бүр шалгалт хийхээс бусад үед банкны үйл ажиллагаанд гарах алдаа дутагдлыг тасралтгүй илрүүлэх чадвартай нягт холбоотой байдаг. Түүнчлэн, дотоод хяналтын тогтолцоо нь ажил үүргийн хэрэгжилт хангалтгүй байгааг хугацаанд нь илрүүлэх боломжтой байх бөгөөд дээрх хяналтыг холбогдох ажил үүргийн хуваарьт тохирох ажилтнаар	

	хийлгэнэ. Банкны боловсруулсан дотоод хяналтын системд дараах стандартыг тусгасан эсэх. Үүнд: *Дотоод хяналтын аргачлал.* Дотоод хяналтыг хэрэгжүүлэх арга барилыг урьдчилан тодорхойлох нь ач холбогдолтой ч шаардлагатай нөхцөл биш юм. Учир нь дотоод хяналтын аргачлалыг урьдчилан тодорхойлсон ч бодит байдалд хэрэгждэггүй бол үр дүн багатай байдаг. Иймд, дотоод аудитор нь урьдчилан боловсруулсан хяналтын аргачлалыг мөрдөхөөс гадна банкны үйл ажиллагааны онцлог, туршлагад анхаарлаа илүүтэйгээр хандуулах нь зохистой бөгөөд эдгээрийг асуулга, анкет, санал хүсэлт, ажиглалт, сорилтын аргуудыг ашиглан илрүүлэх боломжтой. *Чадварлаг ажлын гүйцэтгэл.* Дотоод хяналтыг үр дүнтэй явуулахад хяналтыг хийх ажилтан нь чадварлаг байх шаардлагатай. Хянан шалгагчийн мэргэжлийн чадвар, ухаан, хандлага зэргийг үнэлэх нь тодорхой хэмжээний субьектив дүгнэлтэд тулгуурласан байдаг. Иймд хянан шалгагчийн илрүүлсэн банкны ажилтны гаргасан алдаа нь мэдлэг, чадвар дутмагийн илрэл гэж үзэх боломжтой юм. *Ажил үүргээ хараат бус байдлаар хэрэгжүүлэх*. Банкны активыг байршуулах үүрэгтэй ажилтан нь тэдгээрийг тэнцэлд бүртгэх үүргийг давхар гүйцэтгэх (*эсвэл дээрх гүйлгээг бүртгэдэг ажилтнуудын үйл ажиллагааг хянадаг*) тохиолдолд тус ажилтнууд нь өөрсдийн хийсэн алдаа эсвэл луйврыг нуун дарагдуулах боломжийг үүсгэдэг. Түүнчлэн, активыг байршуулах ажил үүрэг нь тэдгээрийг бүртгэх үүрэгтэй зохицоогүй, эсвэл үйл ажиллагааны гүйцэтгэл нь түүний биелэлтийн хяналт, дүгнэлттэй зөрчилддөг талтай тул цаашид дээрх асуудалд анхаарах шаардлагатай.	
2	**Жижиг банкуудын анхаараõ асуудàл**	
(1)	Банк бүр өөрийн үйл ажиллагааны цар хүрээ, онцлогт тохирсон дотоод аудитын аргачлалыг боловсруулах шаардлагатай. Тухайлбал, жижиг банкуудын хувьд банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох, гарч буй зардал үр ашигтай байгааг удирдлагаас хянахаар зохицуулж болох боловч энэ үүрэг чеку́д гарын үсэг зурах эрх мэдэлтэй давхардах тохиолдолд банкны үйл ажиллагаа хэвийн, цаг хугацаандаа явагдаж чадахгүйд хүрэх эрсдэл үүсдэг.	
3	**Дотоод хяналтын үйл ажиллагааг үнэлэх аргачлалууд**	
(1)	• Банкны гүйцэтгэх удирдлага, аудитын хороо болон дотоод аудиторууд нь банкны дотоод хяналтын үйл ажиллагааг дүгнэх хангалттай мэдлэг туршлагатай эсэх. Үүнд: Дотоод хяналтынг үнэлэх хэд хэдэн арга байдаг бөгөөд эдгээрээс голчлон хэрэглэгддэг: *ажиглалт, үйл ажиллагааны урсгалын схем, өгүүлэмж/тайлбар, эрсдэлийн хяналтын матриц, тоймлон хянах болон бусад төрлийн тестүүд* гэх мэт аргачлал бèé. Банкны дотоод хяналтын асуулга нь дэлгэрэнгүй хэлбэрээр Монголбанкнаас гаргасан Хянан шалгагчийн гарын авлагад áèé.	

	Зээлийн үйл ажиллагааны эрсдэлийн хяналтын матриц, үйл ажиллагааны урсгалын схем болон өгүүлэмж/тайлбарын жишээг энэ загварын *Хавсралт 1.а,б,в*[1]-ээс харах боломжтой юм. Тоймлон хянах нь *Хавсралт 1*-д дурьдсан урсгалын схем, матриц, өгүүлэмж/тайлбарын тайлбарыг нийтэд нь хянах, сайжруулах үйл явц юм. Тест нь дотоод хяналтын үйл ажиллагаа нь үр дүнгээ өгсөн эсэхийг шалгах аргачлал юм.	

VII. Дотоод аудит

№	Тайлбар	Үнэлгээ
1	**Дотоод аудитын бодлого**	
(1)	• Дотоод аудитын бодлогыг боловсруулсан эсэх, • Дотоод аудитын бодлогод дараах асуудлуудыг тусгасан эсэх, - Дотоод аудитын зорилго Дотоод аудитын нэгжийн бие даасан байдлыг хангах талаарх дүрэм - Дотоод аудитын нэгжийн эрх, үүрэг хариуцлага, - Шаардлагатай мэдээллийг авах тогтолцоо - Дотоод аудитыг сайжруулах тогтолцоо - Дотоод аудитын нэгжээс гаргах тайлангийн талаар • Дотоод аудитын бодлогын талаар банкны ажилòíóóдад танилцуулсан эсэх,	
2	**Дотоод аудитын төлөвлөгөө**	
(1)	• Дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулсан эсэх, • Дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулахдаа банкинд хийгдэх дотоод аудитын хугацааны давтамж, үр нөлөө, аудит хийж буй нэгжийн эрсдэлийн удирдлага, харилцагчдын эрх ашгийг хамгаалах болон хууль журмыг хэрэгжүүлэх асуудлыг харгалзан үзсэн эсэх, • Дотоод аудитын төлөвлөгөөг банкны эрсдэлийн удирдлагын үнэлгээнд тулгуурлан боловсруулсан эсэх, • Аудитын төлөвлөгөөнд бизнесийн үйл ажиллагааны төрөл бүрт аудит хийхэд анхаарах хүчин зүйлс, хугацааны давтамж болон зардал, төсвийн талаар тусгасан эсэх, • Эрсдэлийн удирдлагын шинжилгээний үр дүнд үндэслэн аудит хийх газар, хэлтэс болон холбогдох асуудлыг эрсдэл ихтэйгээс багатай руу эрэмбýлэх замаар ач холбогдлын түвшинг аудитын төлөвлөгөөнд тусгасан эсэх, • Аудитын төлөвлөгөөний хуваарьт өөрчлөлт оруулах тохиолдолд дээрх өөрчлөлтийг банкны ТУЗ болон аудитын хорооноос зөвшөөрөл авсны дараа хэрэгжүүлдэг эсэх, • Зарим байгууллагà аудитын төлөвлөгөөг гадаад аудиторуудтай хамтран боловсруулдаг. Энэ тохиолдолд гадаад дотоод аудиторуудын	

[1] Энэхүү жишээг Япон улсын арилжааны банкны үйл ажиллагаанд тулгуурлан боловсруулсан тул банкны зүгээс өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан дээрх аргачлалыг боловсруулах нь тохиромжтой.

	ажил, үүргийн хуваарийг нарийн боловсруулах, гадаад аудит хийхэд дотоод аудиторуудаас туслалцаа авах эсэх асуудлыг дэлгэрэнгүй тусгадаг эсэх, • Аудит нь мөчлөгийн шинж чанартай эсэх, Тухайлбал, өндөр түвшний эрсдэл бүхий асуудалд жил бүр, дунд түвшний эрсдэлд хоёр жилд нэг удаа, бага түвшний эрсдэлд гурван жилд нэг удаа аудит хийх боломжтой. • Дотоод аудиторуудын боловсруулсан аудитын жилийн тайлан, төсвийг ТУЗ, аудитын хороо эсвэл гүйцэтгэх удирдлагаар батлуулдаг эсэх,	
3	**Аудитын гарын авлага**	
(1)	• Аудитын нэгжийн ажилòíыг бусад газар, хэлтýсò аудит хийхэд зориулсàн гарын авлагыг боловсруулж, ашигладаг эсэх, • Дээрх гарын авлагад аудитын дүрэм, зорилго, үйл ажиллагааны журам, ажлын баримт хийх стандарт болон тайлагнах үйл ажиллагааны талаар тодорхой тусгасан байгаа эсэх • Хийж буй аудитын шалгалт бүр нь гарын авлагад тусгасан шаардлагуудтай нийцэж байгаа эсэх, • Гарын авлагад аудитын үйл ажиллагааны зорилт болон сүүлийн үеийн аудитын стандартад орж буй өөрчлөлтийг тухай бүр шинэчлэн өөрчилдөг эсэх,	
4	**Аудитын хөтөлбөр болон ажлын баримт**	
(1)	• Аудитын хөтөлбөрт аудитын зорилго болон аудит хийсэн аргачлалыг тусгасан эсэх, • Хөтөлбөрт ажил гүйцэтгэгч болон үнэлэлт, дүгнэлт өгсөн эзнийг тодотгосон эсэх, • Аудитын ажлын баримтад аудиторын баримт нотолгоо болон түүнд үндэслэн хийгдсэн дүгнэлт, аудитын үйл ажиллагаанаас илэрсэн тулгамдаж буй асуудлыг тодорхой тусгасан эсэх, • Аудитын ажлын баримтанд хийгдсэн аудит нь гарын авлага дахь шаардлага, хөтөлбөрийг хангасан эсэх,	
5	**Эрсдэлийн үнэлгээний аргачлал**	
(1)	• Эрсдэлийн үнэлгээний аргачлалын тайланд банкны эрхлэх үйл ажиллагаа, тэдгээрийн харгалзах эрсдэл, нөлөөлдөг хүчин зүйлийн талаарх аудитын дүгнэлтийг тусгасан эсэх, • Дээрх үнэлгээнд банкны тухайн үйл ажиллагааны эрсдэлийн түвшин, эрсдэлийг удирдсанаар хэдий хэмжээний эрсдэлийг бууруулах болон үлдэж буй банкны хүлээх эрсдэлийн хэмжээний талаар тусгадаг эсэх, • Дээрх үнэлгээг банкинд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргах, дотоод хяналтын тогтолцоонд өөрчлөлт орох тухай бүрт өөрчлөн, сайжруулдаг эсэх,	
6	**Тухайлсан (*тусгай*) аудитын гүйцэтгэл**	
(1)	• Аудитын менежер нь тухайн аудит хийх ажилтныг томилох, үйл ажиллагааны чиглэл өгөх, ажлын гүйцэтгэлд нь үнэлэлт дүгнэлт өгдөг эсэх, • Банкинд аудит хийж буй аудитор нь банкинд тулгарч буй эрсдэлийг	

	нээн илрүүлж, үнэлгээ дүгнэлт өгөх, банкны дотоод хяналтын тогтолцоо нь үр ашигтай явагдаж байгаа талаар үнэлэлт дүгнэлт өгөх чадвар, хангалттай туршлагатай эсэх,	
7	**Аудитын тайлан**	
(1)	• Аудитын тайланг салбарын менежер, гүйцэтгэх удирдлага, аудитын хороо болон ТУЗ-д танилцуулдаг эсэх, • Аудитын тайланд аудит хийх зорилго, аудитын хүрээ болон дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаарх саналыг тусгасан эсэх,	
8	**Дотоод аудиторуудын мэдлэг чадвар**	
(1)	Дотоод аудиторуудын үүрэг хариуцлага, боловсролын түвшинд тавигдах шаардлага нь банкны үйл ажиллагааны цар хүрээ, онцлог болон аудитын үйл ажиллагааны талаар удирдлагаас тавьж буй шаардлагаас хамааран харилцан адилгүй байдаг. Зарим банкны хувьд, дотоод аудитын үйл ажиллагааг зөвхөн дотоод аудит хийх үүрэгтэй нэг болон хэд хэдэн хувь хүн гүйцэтгэж байхад бусад буюу ялангуяа жижиг банкны хувьд банкны талаар туршлага бүхий эдийн засагч эсвэл ажилтан нь цагийн ажил хэлбэрээр ихэвчлэн гүйцэтгэдэг. • Банкны салбар, хэлтэс, нэгжид дотоод аудит хийхэд дотоод аудитын нэгжээс хангалттай мэдлэг туршлагатай аудитын менежерийг томилон ажиллуулдаг эсэх, • Тухайлбал, дотоод аудитын нэгжийн менежер нь боловсролын дараах шалгуурыг хангасан эсэх. Үүнд: - Банкинд голлох үүрэгтэй ажилтны хувьд бусад банкуудаас тавигдах боловсролын түвшингийн шаардлагуудыг хангахуйц мэдлэг, боловсролыг эзэмшсэн, - Цаашид мэргэжлээрээ сурч боловсрох эрмэлзэлтэй, - Хийж гүйцэтгэх ажлын үүрэгт зохицсон мэдлэг, туршлагатай, удирдан зохион байгуулах чадвартай, - Ярианы болон бичгийн харилцааны чадвартай, • Банкны дотоод аудитыг хэрэгжүүлэх аудитын нэгжид оногдсон ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай эрх мэдэл олгосон эсэх, • Дотоод аудитын нэгжид банкинд тодорхой хугацаанд ажиллаж байсан мэдлэг туршлагатай ажилтнûг томилон ажиллуулдаг эсэх, Дээрх ажилòàí нь дотоод аудитын нэгжид ажиллахдаа тодорхой эрх мэдлээр хангагддаг эсэх, • Дотоод аудитын нэгжийн аудиторыг мэдлэг, боловсрол, ур чадвараа дээшлүүлэх зорилгоор дотоод болон гадаад сургалт, семинарт тогтмол хамруулдаг эсэх, • Дотоод аудитын нэгж нь аудитораа тасралтгүй сургах тогтолцоог бүрдүүлсэн эсэх, • Дотоод аудитын нэгжийн бие даасан байдал хангагдсан эсэх, • Дотоод аудитын нэгжээс бусад газар, хэлтýсò аудит хийхэд элдэв саад	

	учруулахгүй байх боломжоор хангагдсан эсэх, • Дотоод аудит хийдэг ажилтнуудыг банкны бусад үйл ажиллагаанд (*банкны өдөр тутмын үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээлэл бүртгэх гм*)-нд давхар томилоогүй эсэх, • Дотоод аудит хийгдэхэд алдаа, зөрчлийг илүүтэйгээр гаргадаг эсвэл гаргах магадлал өндөртэй газар, хэлтэст хийгдэх дотоод аудитын тогтолцоог бусад газар, хэлтсээс өөр байдлаар боловсруулсан эсэх, • Банкны дотоод хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор дотоод аудитын нэгж нь хүн хүч дутагдалтайгаас гадны аудиторыг хөлсөлж хийлгэсэн ажилд алдаа дутагдалд гарах тохиолдолд өмнөөс нь бүрэн хариуцлага хүлээлгэдэг байхаар тусгасан эсэх, • Дотоод аудитын нэгж нь дотоод аудитын дүрмийн дагуу банкны бүх ажилтан, албан хаагчаас ярилцлага авах, шаардлагатай мэдээ мэдээлэл гаргуулан авах эрхээр хангагдсан эсэх, • Банкны бусад ажилчид нь дотоод аудитын нэгжийн үүрэг хариуцлага, эрх мэдлийн талаар тодорхой ойлголттой эсэх, • Банкны гадаад улс дахь салбар, нэгжийн үйл ажиллагааны эрсдэл нь зөвшөөрөгдөх түвшнээс хэтэрсэн гэж үзвэл дотоод аудитын нэгжийн хяналтын дор ажиллах аудитын багийг тус улсын салбарт байгуулан ажиллуулдаг эсэх, • Дотоод аудиторын дүгнэлтийг хугацааны давтамжтайгаар, зохистойгоор тайлагнах тогтолцоог бүрдүүлсэн эсэх,	
9	**Банкны хэмжээ, цар хүрээний талаар**	
(1)	Үйл ажиллагааны цар хүрээ өргөн, том хэмжээтэй банкуудад орон тооны дотоод аудиторыг авч ажиллуулах, аудитын тусгай нэгж байгуулан ажиллуулснаас бий болох үр нөлөө нь гаргасан зардлаасаа илүү байдаг. Харин үйл ажиллагааны цар хүрээ багатай, жижиг банкуудын хувьд аудитор болон аудитын нэгжийг нээн ажиллуулах нь зардал өндөртэй байх хандлагатай байдаг. Гэхдээ жижиг хэмжээтэй банкууд нь дотоод хяналтын тогтолцооноос бий болсон обьектив санал, дүгнэлтэд тулгуурлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгох замаар дотоод аудитын үйл ажиллагааг хангах боломжтой. Энэ төрлийн дотоод тогтолцооны гол чанар нь шалгагдаж буй нэгжийн үйл ажиллагаанд хамааралгүй албан тушаалтнаар тус газар, нэгжийг шалгуулахад орших бөгөөд дотоод хяналтыг явуулах туршлагатай ажилтнûг томилон шалгалтын удирдамжийг боловсруулж, шалгалтыг ахлах боломжтой. Томилогдсон ажилтны гүйцэтгэсэн шалгалтын тайлан болон шалгалтаар илэрсэн зөрчлийг шууд аудитын хороонд тайлагнадаг байхаар тусгахаар зохицуулна.	
10	**Аудит, шалгалтаас хойш авах арга хэмжээний талаар**	
(1)	• Тухайн газар, хэлтэст хийгдсэн аудитын дүгнэлт, авах арга хэмжээний талаар санал, дүгнэлтийг хэрэгжүүлэх, алдаа дутагдлыг арилгах талаар төлөвлөгөөг нэгж нь өөрийн боломжид тулгуурлан боловсруулдаг эсэх, • Өмнөх үүрэг, даалгаврын биелэлтийн үйл явцыг дотоод аудитын нэгжээс хянах, биелэлтийг дараагийн аудитын шалгалтын удирдамж,	

	хөтөлбөрт тусгадаг эсэх,	

VIII. Гадаад аудит

№	Тайлбар	Үнэлгээ
(1)	• Банкинд гадаад аудит хийж буй аудитор нь мэргэжлийн болон бусад шалгуур, стандартûг хангасан эсэх, • Аудитын үндэсний стандартын дагуу, гадаад аудит хийж буй компанийн ахлах аудитор нь салбарын аудитораас банкуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын үнэн зөв эсэхэд давхар хариуцлага хүлээж буй эсэх, Ингэснээр нийт аудитын үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, санхүүгийн тайлангийн үнэн зөв гарсан эсэх талаар давхар баталгаа болох ач холбогдолтой юм. • Гадаад аудитор нь банкны дотоод хяналтын тогтолцоог шалгахдаа санхүүгийн тайланг нийтэд тогтмол ил тод гаргуулж байсан талаар хянадаг эсэх, • Гадаад аудитор нь өөрсдийн банкны өмнө хүлээх үүргээ бүрэн ухамсарлаж, ажлаа мэргэжлийн түвшинд хийдэг эсэх, • Байнга үйлчлүүлдэг нэр хүнд бүхий аудитын компанийã хугацааны давтамжтайгаар сольж буй эсэх,	
(2)	• Гадаад аудитор нь доорх зүйлсийг хэрэгжүүлдэг эсэх. Үүнд: - Банкинд аудит хийж буй тохиолдолд банкны үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн эрсдэлийг үнэлэх, дүгнэлт хийх, - Банкнаас аудиторò ирүүлсэн мэдээ, мэдээллийн үнэн бодит эсэхийг нягтлан шалгах, - Банкнаас үзүүлсэн бүтээгдхүүн үйлчилгээний арилжаа, гүйлгээтэй холбоотой мэдээллийг авах, сүүлийн жилүүдийн банкны салбарын хөгжлийн талаар тодорхой мэдлэгтэй байх, - ТУЗ-өөс гаргасан бодлого, журмыг гүйцэтгэх удирдлага хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар үнэлгээ, дүгнэлт өгөх, - ТУЗ, хувь нийлүүлэгч болон хяналт шалгалтын бусад байгууллагуудад шаардлагатай мэдээллийг хугацаанд нь үнэн бодитоор хүргүүлж байгаа эсэх, - Банкны бодлого, журам, хяналт шалгалтын байгууллагаас тогтоосон шаардлага, ёс зүйн журмын хэрэгжилтийн талаар үнэлэлт дүгнэлт өгөх,	

Хавсралт 1.а. Зээлийн үйл явцын урсгалын схем




5. Зээл олгох
6. Зээлийн данс хаах
7. Банкны төвд хийгдэх үйлдэл
(1)Шаардлагатай материалуудыг бүрдүүлэх
R3
(1)Шаардлагатай материалуудыг бүрдүүлэх
Гэрээ (хэлцэл) баримтууд
Зээл олгох заавар
Гэрээ (хэлцэл)-ний талаар баримтууд
Зээл олгох заавар
Зээлийн багцын жагсаалт
R4
R5
(2)Зээл олголт (тухайлбал гэрээний материалууд)
Гэрээ (хэлцэл) баримтууд
Гэрээ байгуулахад шаардлагатай материалын бүрдэлтийг хянах
C4
(3) Агуулгыг баталгаажуулах (Зээл хариуцсан ажилтан)
Гэрээ (хэлцэл) байгуулахтай холбоотойгоор бүрдүүлэх баримтууд
C5
R6
R7
(4)Үйл ажиллагаа
(5)Системд нэвтрэх хяналт (6)Системийг хамгаалах
C6
C7
Зээлийн багцын жагсаалт
Зээл олгох заавар
Зээлийн багцын жагсаалт
C9
(8) Гарын үсэг,тэмдэг (Зээлийн эдийн засагч)
(7)Баталгаажуулах (officer other than operator)
Удирдлагаас олгохыг зөвшөөрсөн зээлийн жагсаалт
(9)Шийдэгдээгүй зээлийн асуудлыг зохицуулах (Зээлийн эдийн засагч)
Зээлийн багцын жагсаалт
C10
Удирдлагаас олгохыг зөвшөөрсөн зээлийн жагсаалт
Зээл олгох заавар
Системд оруулсан зээлийн тоо, хэмжээ (орц)
(2) Баталгаажуулах
(1) Гарц
ГАРЦ
Системд оруулсан зээлийн тоо, хэмжээ (орц)
R8
R9
R10
(1)Гүйцэтгэх үйл явц
Өөрчөлт автоматаар хийгдэх
Харилцах дансны өөрчлөлт автоматаар хийгдэх
C12
Дансны системд орох өөрчлөлт автоматаар хийгдэх
(2) Үр дүнг баталгаажуулах
(төв салбар) Саатал учирсан зээлийн гүйлгээний жагсаалт
【Схем дэхь дүрсийн товч тайлбар】
Үйл ажиллагааны дэд алхам / урьтал нөхцөл
Баримт материалууд
Системийн ажиллагаа
Системийн орц
Хэд хэдэн ажилчдын урьдчилан гүйцэтгэх алхам
Бусад үйл явц
C12 : Эрсдэл
C12 : Хяналт

Хавсралт 1.б. Зээлийн олгох үет шат

Дд	дэд бүлэг	Үйл ажиллагаа	Урьдчилсан арга хэмжээ	Нэгж	Хариуцах ажилтан	Тухайн шатанд хийгдэх үйл ажиллагааны тайлбар	Баримтлах бодлого, гарын авлага	Холбогдох систем
1	(1)	Хүлээн авах	Хүлээн авах	салбар	Зээл хариуцсан ажилтан	Зээл хүсэгчээс ирүүлсэн зээлийн өргөдөл бүрдүүлсэн баримт, материалуудыг зээл хариуцсан ажилтан хүлээн авна.	Зээлийн үйл ажиллагааны журам	
2	(1)	Зээлийн нөхцлийг судлах	Зээлийн нөхцөл, гарч болох эрсдлийг судлах	салбар	Зээл хариуцсан ажилтан	Зээл хүсэгчээс ирүүлсэн өргөдөл, төслийг зээл хариуцсан ажилтан нь хүлээн авч зээлийн зориулалт нөхцөл болон бүрдүүлсэн баримтуудад шинжилгээ хийнэ.	Зээлийн үйл ажиллагааны журам	
3	(1)	Урьдчилсан хэлэлцүүлэг	Хэлэлцүүлэг	салбар	Зээл хариуцсан ажилтан/салбарын менежер	Зээл хариуцсан ажилтан нь зээл хүсэгчээс бэлтгэсэн мэдээллүүдэд хийсэн шинжилгээнд үндэслэн урьдчилсан дүгнэлт бүхий материалыг бүрдүүлж салбарын/хэлтэсийн менежертэй зээл олгох эсэх асуудлаар зөвлөлдөх,	Зээлийн үйл ажиллагааны журам	
	(2)		Зөвшөөрөл	салбар	Зээл хариуцсан ажилтан/салбарын менежер	Салбар, хэлтсийн менежер нь урьдчилсан баримт материалуудтай танилцан үзээд, зээл олгох эсвэл татгалзах шийдвэр гаргаж өөрийн тамга, тэмдгээр баталгаажуулах	Зээлийн үйл ажиллагааны журам	
4	(1)	Удирдлагаас зөвшөөрөл авахад шаардлагатай баримт материалууд	Зээлийг удирдлагын хурлаар оруулах, бүртгүүлэх	салбар	Зээл хариуцсан ажилтан	Салбарын менежерийн зөвшөөрлийг авсны дараа зээл хариуцсан ажилтан нь удирдлагаас зөвшөөрөл хүсэх өргөдлийн маягтийг бөглөж, зээлийн удирдлагын мэдээллийн системд давхар бүртгүүлэх бөгөөд холбогдох зээлийн бүрдүүлсэн баримтуудыг зөвшөөрөл хүсэх маягтуудын хамт зээлийн эдийн засагчид шилжүүлнэ.	Зээлийн үйл ажиллагааны журам	Зээлийн тогтолцоо
	(2)		Баталгаажуулах	салбар	Зээл хариуцсан ажилтан	Зээлийн эдийн засагч нь хүлээн авсан баримтуудыг зээлийн системд оруулсан өргөдлийн маягттай тулган шалган танилцаад, өөрийн гарын үсэг, тэмдгээр баримтуудыг баталгаажуулж, салбарын менежерт шилжүүлнэ.	Зээлийн үйл ажиллагааны журам	
	(3)		Зөвшөөрөл олгох	салбар	Хэлтэс/салбарын менежер	Салбар/хэлтсийн менежер нь баримтуудыг хүлээн авч танилцаад өөрийн гарын үсэг тэмдгээр баталгаажуулан зээлийн эдийн засагчид буцаан олгоно.	Зээлийн үйл ажиллагааны журам	
	(4)		Бүртгэх заавар	салбар	Зээлийн эдийн засагч	Зээлийн эдийн засагч нь салбарын захирлын тэмдэг, гарын үсгээр баталгаажсан баримтуудтай танилцаад зээлдэгчийн удирдлагад тавьсан хүсэлтийг зээлийн санд бүртгэхийг зээл хариуцсан ажилтанд даалгана.		
	(5)		Зөвшөөрөл олгосныг бүртгэх	салбар	Зээл хариуцсан ажилтан	Зээл хариуцсан ажилтан нь салбарын захирлаас өгсөн чиглэлийн дагуу зээлийг зээлийн удирдлагын санд бүртгэнэ.	Зээлийн үйл ажиллагааны журам	Зээлийн тогтолцоо

Дд	дэд бүлэг	Үйл ажиллагаа	Урьдчилсан арга хэмжээ	Нэгж	Хариуцах ажилтан	Тухайн шатанд хийгдэх үйл ажиллагааны тайлбар	Баримтлах бодлого, гарын авлага	Холбогдох систем
	(6)		Удирдлагаас олгохыг зөвшөөрсөн зээлийн жагсаалт		Зээлийн систем	Холбогдох зээлийн хүсэлтийг зээлийг программд оруулж баталгаажуулах бөгөөд программаас "Удирдлагаас олгохыг зөвшөөрсөн зээлийн жагсаалт" хэвлэгдэн гарна.		Зээлийн тогтолцоо
	(7)		Зөвшөөрөл олгосон зээлийн жагсаалтийг баталгаажуулах	салбар	Зээлийн эдийн засагч	Зээлийн эдийн засагч хэвлэгдсэн жагсаалт болон бусад баримтуудтай танилцаад цохолт хийж, гарын үсэг тэмдгээр баталгаажуулна.	Зээлийн үйл ажиллагааны журам	
5	(1)	Өргөдөл, баримтуудтай танилцах	Холбогдох баримтуудыг бүрдүүлэх	салбар	Зээл хариуцсан ажилтан	Зээл олгох шийдвэр гарсны дараа зээл хариуцсан ажилтан нь зээлдэгчээс гэрээ байгуулахад бүрдүүлэх баримтуудыг хүлээн авч зээлийн олголт хариуцсан ажилтанд шилжүүлнэ.	Зээлийн үйл ажиллагааны журам	
	(2)		Олголт	салбар	Зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан	Зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан нь зээлийн гэрээ байгуулахад шаардлагатай материалуудын бүрдэлт, түүний зээл олгох хүсэлт болон баталгаажсан зээл олгох зөвшөөрлийн уялдааг шалгасны үндсэн дээр зээл олгох зааврыг боловсруулж зээлийн эдийн засагч руу шилжүүлнэ.	Зээлийн үйл ажиллагааны журам	
	(3)		Баримтуудыг баталгаажуулах	салбар	Зээлийн эдийн засагч	Зээлийн эдийн засагч нь дээрх гурван баримтуудыг хүлээн авч шалгаад (зээл олгох заавар, гэрээний баримт, зээл олгох хүсэлт) зээл олгох зааварт өөрийн гарын үсэг болон тэмдгээр баталгаажуулах бөгөөд зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтанд зээлийг бүртгэх үүрэг өгнө.	Зээлийн үйл ажиллагааны журам	
	(4)		Үйл ажиллагаа	салбар	Зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан	Зээлийн эдийн засагчаас авсан чиглэлийн дагуу зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан нь зээлийн программд нэвтэрч зээлийн багцын жагсаалт дээрх зээлийг бүртгэнэ. Зээл олгох заавар болон зээлийн багцын жагсаалтын үнэн зөв эсэхийг хянуулах зорилгоор тухайн зээлийг хариуцдаггүй зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтанд шилжүүлж хянуулна.	Зээлийн үйл ажиллагааны журам	Зээлийн тогтолцоо
	(5)		Системд нэвтрэхэд тавих хяналт		Зээлийн систем	Зээлийн системийн программд нэвтрэх зөвшөөрөл олгодог ажилчныг тус системд нэвтрэхийг хориглоно.		Зээлийн тогтолцоо
	(6)		Системийн хамгаалалт		Зээлийн систем	Удирдлагаас урьдчилан зээл олгох зөвшөөрөл аваагүй тохиолдолд зээлийн программ ажиллахгүй.		Зээлийн тогтолцоо

Дд	дэд бүлэг	Үйл ажиллагаа	Урьдчилсан арга хэмжээ	Нэгж	Хариуцах ажилтан	Тухайн шатанд хийгдэх үйл ажиллагааны тайлбар	Баримтлах бодлого, гарын авлага	Холбогдох систем
	(7)		Баталгаажуулах	салбар	Операторын үүргийг гүйцэтгэдэггүй зээлийн үйл ажиллагаа хариуцсан	Операторын үүрэг гүйцэтгэдэггүй зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан нь зээлийн багцын жагсаалтанд нэмж бүртгэсэн зээл болон холбогдох зээл олгох зааврыг тулган шалгаж өөрийн гарын үсэг, тэмдгээр баталгаажуулна.	Зээлийн үйл ажиллагааны журам	
	(8)		Гарын үсэг/тэмдэг	салбар	Зээлийн эдийн засагч	Зээлийн эдийн засагч нь дээрх баримтуудыг давхар шалгаж, гарын үсэг, тэмдгээр баталгаажуулна.	Зээлийн үйл ажиллагааны журам	
	(9)		Бүртгэгдсэн зээлийг олгох	салбар	Зээлийн эдийн засагч	Зээлийн эдийн засагч нь удирдлагаас олгосон зээлийн жагсаалт болон программд бүртгэгдсэн зээлийн жагсаалтыг тулган шалгаж, удирдлагын баталсан жагсаалт дахь зээлүүд нь журмын дагуу олгогдсон эсэхэд хяналт тавина.	Зээлийн үйл ажиллагааны журам	
6	(1)	Данс хаах	Гарц	салбар	Зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан	Зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан нь өдрийн гүйлгээ хаагдахад баталгаажуулж, тухайн өдөрт бүртгэгдсэн нийт зээлийн тоо болон хэмжээг гаргана.	Зээлийн үйл ажиллагааны журам	Зээлийн тогтолцоо
	(2)		Баталгаажуулах	салбар	Зээлийн эдийн засагч	Зээлийн эдийн засагч нь зээлийн заавар болон зээлийн тоо, хэмжээний жагсаалтуудыг хүлээн авч, дансдыг тулган шалгаж, гарын үсэг, тэмдгээр баталгаажуулна.	Зээлийн үйл ажиллагааны журам	
7	(1)	Төв салбарт хийгдэх гүйлгээ	Гүйцэтгэл		Данс/харилцахын систем	Зээл олгох гүйлгээ нь банкны төв дээр хийгддэг бөгөөд, зээлийн дансыг нээхэд зээлдэгчийн нэрийн харилцах дансанд зээлийн дүн автоматаар бүртгэгдэж, ерөнхий дэвтэр холбогдох дүнгээр өөрчлөгддөг.		Дансны систем/депозит систем
	(2)		Гарцын үр дүнг баталгаажуулах	салбар	Зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан	Төв салбарт зээлийг бүртгэхэд аливаа саатал хүндрэл гарахад холбогдох асуудлын талаарх дэлгэрэнгүй тайлбарыг салбарт бүрт илгээх бөгөөд зээлийн үйл ажиллагааг хариуцсан ажилтан дээрх саатлыг илрүүлэх, засварлах үүрэг гүйцэтгэнэ.		Дансны систем

Хавсралт 1.в. Зээлийн үйл ажиллагааны эрсдлийн матриц (Risk Control Metrics)

Алхамын дд	Дэд алхамын дд	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны урьтал нөхцөл	Эрсдлийн төрлүүд								Хяналт				
				Үүсэх эрсдэл	Эрсдлийн тайлбар	Зээлийн төлөв*						алхамын дд	Хяналтын дд	Хэлтэс	Хариуцах ажилтан	Тайлбар (аргачлал)
						О	Д	Э/Ү	Ү	Х	Г/М					
4	(1)	Удирдлагаас зөвшөөрөл авахад шаардлагатай баримт материалууд	Зээлийг удирдлагын хурлаар оруулах, бүртгүүлэх	R1	Зээл хүсэх өргөдөл болон бусад мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгалгүйгээр шууд бүртгэх (хүүгийн түвшин, хэмжээ гэх мэт).	○			○			4(2)	C1	салбар	Зээл хариуцсан ажилтан	Зээлийн эдийн засагч нь хүлээн авсан баримтуудыг зээлийн системд оруулсан өргөдлийн маягттай тулган шалган танилцаад,өөрийн гарын үсэг, тэмдгээр баримтуудыг баталгаажуулж, салбарын менежерт шилжүүлнэ.
	(3)											4(3)	C2	салбар	Хэлтэс/салбарын менежер	Салбар/хэлтсийн менежер нь баримтуудыг хүлээн авч танилцаад өөрийн гарын үсэг тэмдгээр баталгаажуулан зээлийн эдийн засагчид буцаан олгоно
4	(5)	Удирдлагаас зөвшөөрөл авахад шаардлагатай баримт материалууд	Зөвшөөрөл олгосныг бүртгэх	R2	Бодит бус мэдээлэл бүхий өргөдлийг бүртгэж зөвшөөрөл олгох	○			○			4(7)	C3	салбар	Зээлийн эдийн засагч	Зээлийн эдийн засагч хэвлэгдсэн жагсаалт болон бусад баримтуудтай танилцаад цохолт хийж, гарын үсэг тэмдгээр баталгаажуулна.
5	(1)	Өргөдөл, баримтуудтай танилцах	Холбогдох баримтуудыг бүрдүүлэх	R3	Баримтуудыг хангалттай бүрдүүлээгүй.	○		○				5(2)		салбар	Зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан	Зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан нь зээлийн гэрээ байгуулахад шаардлагатай материалуудын бүрдэлт, түүний зээл олгох хүсэлт болон баталгаажсан зээл олгох зөвшөөрлийн уялдааг шалгасны үндсэн дээр зээл олгох зааврыг боловсруулж зээлийн эдийн засагч руу шилжүүлнэ.
												5(3)		салбар	Зээлийн эдийн засагч	Зээлийн эдийн засагч нь дээрх гурван баримтуудыг хүлээн авч шалгаад (зээл олгох заавар, гэрээний баримт, зээл олгох хүсэлт) зээл олгох зааварт өөрийн гарын үсэг болон тэмдгээр баталгаажуулах бөгөөд зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтанд зээлийг бүртгэх үүрэг өгнө.
5	(2)	Өргөдөл, баримтуудтай танилцах	Олголт	R4	Буруу мэдээлэлд үндэслэн зээл олгох зааврыг боловсруулах	○			○			5(3)	C5	салбар	Зээлийн эдийн засагч	Зээлийн эдийн засагч нь дээрх гурван баримтуудыг хүлээн авч шалгаад (зээл олгох заавар, гэрээний баримт, зээл олгох хүсэлт) зээл олгох зааварт өөрийн гарын үсэг болон тэмдгээр баталгаажуулах бөгөөд зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтанд зээлийг бүртгэх үүрэг өгнө.
												5(6)	C7	салбар	Зээлийн систем	Удирдлагаас урьдчилан зээл олгох зөвшөөрөл аваагүй тохиолдолд зээлийн программ ажиллахгүй.
												5(9)	C10	салбар	Зээлийн эдийн засагч	Зээлийн эдийн засагч нь удирдлагаас олгосон зээлийн жагсаалт болон программд бүртгэгдсэн зээлийн жагсаалтыг тулган шалгаж, удирдлагын баталсан жагсаалт дахь зээлүүд нь журмын дагуу олгогдсон эсэхэд хяналт тавина.
				R5	Удирдлагаас зээл хүсэх болон гэрээ байгуулахад шаардлагатай баримт материалуудыг бодит бус мэдээлэлд тулгуурлан бүрдүүлснээс зээл олгох заавар нь бодит байдалд зохицохгүй.				○			5(3)	C5	салбар	Зээлийн эдийн засагч	Зээлийн эдийн засагч нь дээрх гурван баримтуудыг хүлээн авч шалгаад (зээл олгох заавар, гэрээний баримт, зээл олгох хүсэлт) зээл олгох зааварт өөрийн гарын үсэг болон тэмдгээр баталгаажуулах бөгөөд зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтанд зээлийг бүртгэх үүрэг өгнө.
5	(4)	Өргөдөл, баримтуудтай танилцах	Системд нэвтрэхэд тавих хяналт	R6	Зээл олгох зааварт тусгагдаагүй зохиомол мэдээллийг зээлийн системд оруулах	○			○			5(5)	C6		Зээлийн систем	Зээлийн системийн программд нэвтрэх зөвшөөрөл олгодог ажилчныг тус системд нэвтрэхийг хориглоно.

Алхамын дд	Дэд алхамын дд	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны урьтал нөхцөл	Эрсдлийн төрлүүд								Хяналт				
				Үүсэх эрсдэл	Эрсдлийн тайлбар	Зээлийн төлөв*						алхамын дд	Хяналтын дд	Хэлтэс	Хариуцах ажилтан	Тайлбар (аргачлал)
						О	Д	Э/Y	Y	X	Г/М					
												5(6)	C7		Зээлийн систем	Удирдлагаас урьдчилан зээл олгох зөвшөөрөл аваагүй тохиолдолд зээлийн программ ажиллахгүй.
												6(2)	C11	салбар	Зээлийн эдийн засагч	Зээлийн эдийн засагч нь зээлийн заавар болон зээлийн тоо, хэмжээний жагсаалтуудыг хүлээн авч, дансдыг тулган шалгаж, гарынүсэг, тэмдгээр баталгаажуулна.
				R7	Зээл олгох зааварт зааснаас ялгаатай, худал мэдээллийг зээлийн системд оруулах				○			5(7)	C8	салбар	Операторын үүрэг гүйцэтгэдэггүй зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан	Операторын үүрэг гүйцэтгэдэггүй зээлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан нь зээлийн багцын жагсаалтанд нэмж бүртгэсэн зээл болон холбогдох зээл олгох зааврыг тулган шалгажөөрийн гарын үсэг, тэмдгээр баталгаажуулна.
												5(8)	C9	салбар	Зээлийн эдийн засагч	Зээлийн эдийн засагч нь дээрх баримтуудыг давхар шалгаж, гарынүсэг, тэмдгээр баталгаажуулна.
												6(2)	C11	салбар	Зээлийн эдийн засагч	Зээлийн эдийн засагч нь зээлийн заавар болон зээлийн тоо, хэмжээний жагсаалтуудыг хүлээн авч, дансдыг тулган шалгаж, гарынүсэг, тэмдгээр баталгаажуулна.
7	(1)	Төв салбарт хийгдэх гүйлгээ	Гүйцэтгэх үйл явц	R8	Зээлийг олгоогүй боловч системд бүртгэх	○						7(1)	C12		Харилцахын/дансны систем	Зээл олгох гүйлгээ нь банкны төв дээр хийгддэг бөгөөд, зээлийн дансыг нээхэд зээлдэгчийн нэрийн харилцах дансанд зээлийн дүн автоматаар бүртгэгдэж, ерөнхий дэвтэр холбогдох дүнгээр өөрчлөгддөг.
				R9	Зээлийг олгосон боловч системд бүртгэхгүй байх		○					7(1)	C12		Харилцахын/дансны систем	Зээл олгох гүйлгээ нь банкны төв дээр хийгддэг бөгөөд, зээлийн дансыг нээхэд зээлдэгчийн нэрийн харилцах дансанд зээлийн дүн автоматаар бүртгэгдэж, ерөнхий дэвтэр холбогдох дүнгээр өөрчлөгддөг.
				R10	Зээлийг системд бүртгэхдээ зээлийн хүү, хэмжээ болон төрлийн талаарх мэдээллийг буруу оруулах				○		○	7(1)	C12		Харилцахын/дансны систем	Зээл олгох гүйлгээ нь банкны төв дээр хийгддэг бөгөөд, зээлийн дансыг нээхэд зээлдэгчийн нэрийн харилцах дансанд зээлийн дүн автоматаар бүртгэгдэж, ерөнхий дэвтэр холбогдох дүнгээр өөрчлөгддөг.

*** [Зээлийн төлөвийн товчлол]**

О=Бодитоор орших
Д=Үйл явц хэрэгжиж дуусах
Э/Y= Эрх, үүрэг
Y=Үнэлгээ
X=Хуваарилалт
Г/М=Гүйцэтгэл/мэдээллийн ил тод байдал

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 5 дугаар сарын 26...-ны
өдрийн ...311.... дугаар тушаалын 5 дугаар хавсралт (Банкны үйл
ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь иж бүрэн шалгалт
хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журмын V хавсралт)

УХИ0014

УДИРДЛАГЫН ЧАДВАР

ХҮЧИН ЗҮЙЛ		ЖИГНЭХ ХУВЬ	МАШ САЙН /1/	САЙН /2/	ДУНД /3/	ХАНГАЛТГҮЙ /4/	МУУ /5/	ЖИГНЭСЭН ҮНЭЛГЭЭ
а	Ил тод байдал	10%						
б	Хувь нийлүүлэгчдийн бүтэц	10%						
в	Хувь нийлүүлэгчдийн зохистой удирдлага	10%						
г	Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэг	15%						
д	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа	15%						
е	Дотоод хяналт	10%						
з	Дотоод аудит	10%						
ж	Гадаад аудит	10%						
и	Мэдээллийн технологи	10%						
НИИТ ҮНЭЛГЭЭ:		100%						

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 5 дугаар сарын 26
-ны өдрийн 311 дугаар тушаалын 6 дугаар хавсралт
(Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь иж бүрэн шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журмын VIII хавсралт)

БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН БАЙДАЛД ЧАНАРЫН ХҮЧИН ЗҮЙЛСЭЭР ДҮГНЭЛТ ӨГӨХ АРГАЧЛАЛ

Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг газар дээр нь шалгаж үнэлгээ дүгнэлт өгөхдөө журмын 3 дахь заалтад заасан чанарын хүчин зүйлсийг дараах асуулгыг ашиглан тодорхойлно. Үүнд:

Нэг. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийн чанарын хүчин зүйлсийг үнэлэхдээ тухайн банкны эрсдлийн хүрээ болон түүний чанар, хэлбэр, эдгээр эрсдлийг удирдах удирдлагын чадавхи зэрэгт үндэслэн доорх асуулгын дагуу тооцож үнэлэлт өгнө.

	Тийм/Үгүй
1. Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа:	
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ сайн	-------/------
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалттай	-------/------
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалтгүй	-------/------
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ муу	-------/------
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ маш муу	-------/------
2. Актив хөрөнгийн эргэн төлөгдөх чадвар:	
Активын ангилал үнэн зөв эсэх	-------/------
Зээлд зэрэглэл тогтоодог эсэх	-------/------
Зээлдэгчдийн санхүүгийн тайланг тухай бүрт авдаг эсэх	-------/------
Зээлдэгчдийн санхүүгийн тайланд холбогдох судалгаа шинжилгээг хийдэг эсэх	-------/------
Зээлдэгчийн зээлээ эргүүлэн төлөх чадварт үнэлгээ дүгнэлт өгдөг эсэх	-------/------
3. Эрсдлийн сангуудын хэмжээ	
Байгуулсан эрсдлийн сангууд нь шаардлагатай хэмжээнээс дутуу эсэх	-------/------
Эрсдлийн сангийн хэмжээ нь зээлийн өсөлтийн хэмжээтэй ижил байгаа эсэх	-------/------
4. Ашигт ажиллагааны хандлага	
Ашигт ажиллагааны өсөлт нь активын өсөлттэй тэнцүү буюу их байгаа эсэх	-------/------
5. Банкны өсөлтийн түвшин	
Өөрийн хөрөнгийн өсөлт нь активын өсөлттэй тэнцүү буюу их байгаа эсэх	-------/------
6. Удирдлагын чадавхи	
Удирдлагын чадавхи нь сайн эсэх	-------/------
7. Эрсдэл бүхий активын хэмжээ	
Эрсдэлтэй актив хөрөнгө багатай эсэх	_____
8. Өөрийн хөрөнгийн өгөөж	

Банкны хуваарилсан ногдол ашиг нь цэвэр орлогын
50 хувиас илүүгүй эсэх -------/------

9. Хөрөнгийн зах зээлд оролцох бололцоо, чадавхи
Банк нь шинэ хувьцаа гаргах чадвартай эсэх -------/------

10. Бүлгийн дундажтай харьцуулсан үзүүлэлт
Банкны өөрийн хөрөнгийн харьцаа нь түүний харъяалах бүлгийн дундажтай харьцуулахад өндөр эсэх
-------/---

Асуулгыг үндэслэн тухайн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний чанарын хүчин зүйлд үнэлгээ дүгнэлт өгөхдөө дараах үзүүлэлтүүдэд 1-5 гэсэн үнэлгээ дүгнэлтийг өгнө:

1. Өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд _____
2. Актив хөрөнгийн эргэн төлөгдөх чадвар _____
3. Эрсдлийн сангуудын хэмжээ _____
4. Ашигт ажиллагааны хандлага _____
5. Банкны өсөлтийн түвшин /харьцаа/ _____
6. Удирдлагын чадавхи _____
7. Эрсдэл бүхий активын хэмжээ _____
8. Өөрийн хөрөнгийн өгөөж _____
9. Хөрөнгийн зах зээлд оролцох бололцоо, чадавхи _____
10. Бүлгийн дундажтай харьцуулсан үзүүлэлт _____

Огноо Огноо
Огноо

Өөрийн хөрөнгө (ӨХ) / Эрсдлээр жигнэсэн актив /ЭЖА/
1-р зэрэглэлийн ӨХ/ЭЖА
1-р зэрэглэлийн ӨХ / Нийт актив
1-р зэрэглэлийн ӨХ / Нийт дундаж актив

Нэгдсэн үнэлгээ:

Тайлбар

Хоёр. Активын чанар

Банкны активын чанарт үнэлгээ дүгнэлт өгөхдөө тэнцлийн болон тэнцлийн гадуурх хүндрэлтэй, чанаргүйд ангилагдсан, хугацаандаа төлөгдөөгүй, хуримтлуулж тооцоогүй, нөхцөл нь өөрчлөгдөж шинэчлэгдсэн актив хөрөнгийн түвшин, хандлага; активын эрсдлийн сангийн хүрэлцээ; чанаргүй активыг тодорхойлох, удирдах болон эргэн төлүүлэх чадвар, зээл болон бусад хөрөнгө оруулалтын багцын чанар болон тараан байршуулалт/диверсификаци/; зээл болон хөрөнгө оруулалтын бодлого, заавар журмын зохистой байдал; тэнцлийн гадуурх дансдаас үүсч болзошгүй зээлийн эрсдэл, актив хөрөнгийн төвлөрөл; зээлийн удирдлагын үр дүнтэй байдал; эрсдлийг тодорхойлох заавар журам, хяналт болон мэдээллийн систем зэргийг үндэслэн активын чанарын асуулгын дагуу тооцож үнэлэлт өгнө.

Тийм Үгүй

1. Зээл хөрөнгө оруулалтын бодлогын зохистой байдал
   а. Банк нь зээл, хөрөнгө оруулалтын бодлоготой эсэх (бичгээр боловсруулсан) -------/------
   б. Энэхүү бодлого нь тодорхой хугацааны дараа шинэчлэгддэг эсэх -------/------
   в. Зээлийн бодлого нь дараах зүйлсийг багтаасан эсэх. Үүнд:
      1. Банкны зорилго -------/------
      2. Зээлийн бодлогын талаар хүлээх хариуцлагын тогтолцоо -------/------
      3. Зээлийн удирдлагын хариуцлага -------/------
      4. Зээл олгох шийдвэрийн эрх хэмжээ, хязгаар -------/------
      5. Зээлийг эргэн шалгах ажиллагаа -------/------
      6. Газар зүйн, бүсийн хязгаарлалтууд -------/------
      7. Хүүгийн бодлого -------/------
      8. Зээлдэгчид тавигдах шаардлага /зээлийн шалгуурууд/ -------/------
      9. Зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийн шаардлага -------/------
      10. Зээлийг эргэн төлүүлэх ажиллагаа -------/------
      11. Зээлийн төрөл болон түүнд холбогдох шаардлага -------/------
2. Зээл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны заавар журам
   а. Банк нь зээлийн заавар, журамтай эсэх -------/------
   б. Энэхүү заавар нь зээлийн үйл ажиллагааны бүх үе шатыг хамруулдаг эсэх -------/------
3. Заавар журмын хэрэгжилт
   а. Зээл, хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийг дотооддоо хянадаг эсэх -------/------
   б. Заавар журмын мөрдөлт, хэрэгжилтийг дотооддоо хянадаг эсэх -------/------
4. Активын чанарын хяналт, ангилал
   а. Зээлийн эдийн засагчид нь зээлийн ангиллыг хийдэг эсэх -------/------
   б. Банкны зээлийн үйл ажиллагааг хянах дотоод хянал байдаг эсэх -------/------
   в. Зээлийн ангилал хийх ажилтан, зээл олгодог ажилтан нарын ажил үүрэг тусгаарлагдсан эсэх -------/------
   г. Зээлдэгчийн мөнгөн урсгал нь зээл олголт, зээлийн ангиллын чухал хүчин зүйл болж чаддаг эсэх -------/------
   д. Зээлдэгчийн санхүүгийн тайлан мэдээнд холбогдох шинжилгээг хийдэг эсэх -------/------
   е. Банкны зээлийн ангилал үнэн зөв эсэх -------/------
5. Активын ангилал
   Чанаргүй активт ангилсан актив нь нийт зээлийн 10 хувиас илүүгүй эсэх -------/------
6. Эрсдлийн төвлөрөл
   а. Банк нь холбогдох этгээдэд олгосон зээлийн төвлөрлийн эрсдлээс зайлсхийдэг эсэх -------/------
   б. Банк нь ижил салбарт олгосон зээлийн төвлөрлийн эрсдлээс зайлсхийдэг эсэх -------/------
   в. Банк нь бусад төвлөрлийн эрсдлээс зайлсхийдэг эсэх
7. Холбогдох этгээд үзүүлэх хөнгөлөл
   а. Банкны нь өөрийн хувь нийлүүлэгчдэд үзүүлэх хөнгөлөлттэй нөхцөлөөс татгалздаг эсэх -------/------

б. Банк санхүүгийн байгууллага нь өөрийн удирдлагад үзүүлэх татгалздаг эсэх -------/------

8. Чанаргүй активын удирдлага
Банк нь чанаргүй активын удирдлагыг хэрэгжүүлэх тусдаа нэгжтэй эсэх -------/------

9. Зээлийн төлүүлэлтийн бодлого
Хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаар банк нь идэвхтэй ажилладаг эсэх -------/------

10. Эрсдлийн сангийн хэмжээ, хандлага
а. Банкны эрсдлийн сангийн хэмжээ нь харьялагдах бүлгийн банкны эрсдлийн сантай харьцуулахад бага эсэх -------/------
б.Зээлээс хүлээх алдагдлын өсөлтийн хандлага -------/------

11. Чанаргүй активын хэмжээ, хандлага
а.Чанаргүй активын хэмжээ нь харьцангуй бага эсэх -------/------
б.Чанаргүй активын хэмжээ буурч байгаа эсэх -------/------

12. Хугацаа хэтэрсэн активын хэмжээ, хандлага
а.Хугацаа хэтэрсэн активын хэмжээ нь харьцангуй бага эсэх -------/------
б.Хугацаа хэтэрсэн активын хэмжээ буурч байгаа эсэх -------/------

13. Зээлийн зориулалт, түүний тодорхой байдал
Зээлийн хувийн хэрэг, зээл хүссэн өргөдөлд зээлийн зориулалт тодорхой бичигдсэн эсэх -------/------

14. Зээл эргэн төлөх эх үүсвэрийн тодорхой байдал
Зээлийн хувийн хэрэг, зээл хүссэн өргөдөлд зээлийн эргэн төлөх эх үүсвэрийн талаар тодорхой бичигдсэн эсэх -------/------

15. Зээлдэгчийн санхүүгийн тайлан мэдээ, түүний үнэн зөв байдал
а.Бүх зээлдэгчийн санхүүгийн тайлан мэдээг авдаг эсэх -------/------
б.Зээлдэгчдийн санхүүгийн тайлан мэдээ нь үнэн зөв эсэх -------/------
в. Зээл олгох шийдвэр гаргахаас өмнө зээлдэгчийн санхүүгийн тайлан мэдээнд холбогдох шинжилгээ, судалгааг хийдэг эсэх -------/------
г.Зээлдэгчийн бэлэн мөнгөний урсгалын шинжилгээ хийдэг эсэх -------/------

16. Барьцаа хөрөнгө
Зээлийн барьцаа хөрөнгө нь холбогдох хууль тогтоомж, заавар журам, бусад эрхийн бичигт заасан шаардлагыг хангадаг эсэх -------/------

17. Ашигт ажиллагаа
Банкны ашигт ажиллагаа нь эрсдлийн холбогдох сангуудыг байгуулахад хүрэлцэхүйц эсэх -------/------

18. Болзошгүй алдагдлын сан
Активын болзошгүй алдагдлын сан нь алдагдлыг хаахад хүрэлцээтэй эсэх -------/------

19. Эдийн засгийн нөхцөл байдлын үзүүлэлт
Эдийн засгийн нөхцөл байдал нь банкны хувьд тохиромжтой эсэх -------/------

Активын чанарын хүчин зүйлст үнэлгээ дүгнэлт өгөхдөө дараах үзүүлэлтүүдэд 1-5 гэсэн үнэлгээ дүгнэлтийг өгнө. Үүнд:

1. Зээл, хөрөнгө оруулалтын бодлогын зохистой байдал
2. Зээл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны заавар журмын зохистой байдал
3. Заавар журмын мөрдөлт, хэрэгжилт

4. Активын чанарын хяналт
5. Активын ангилал
6. Эрсдлийн төвлөрөл
7. Холбогдох этгээдэд үзүүлэх хөнгөлөлттэй нөхцөл
8. Чанаргүй зээлийн удирдлага
9. Зээл төлүүлэх бодлого
10. Эрсдлийн сангийн хэмжээ, хандлага
11. Чанаргүй активын хэмжээ, хандлага
12. Хугацаа хэтэрсэн активын хэмжээ, хандлага
13. Зээлийн зориулалтын тодорхой байдал
14. Зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрийн тодорхой байдал
15. Зээлдэгчийн санхүүгийн тайлан мэдээ, түүний үнэн зөв байдал
16.Барьцаа хөрөнгө
17. Ашигт ажиллагаа
18. Эдийн засгийн нөхцөл байдлын үзүүлэлт

	Огноо	Огноо
	Огноо	
(Хугацаа хэтэрсэн зээл+Хүүг хуримтлуулахаа зогсоосон зээл) / Нийт зээл		
(Хугацаа хэтэрсэн зээл+Хүүг хуримтлуулахаа зогсоосон зээл) / ЗТУБАХСан		
(Хугацаа хэтэрсэн зээл+Хүүг хуримтлуулахаа зогсоосон зээл)/1-р зэрэглэлийн ӨХ		
Чанаргүй зээл / Нийт зээл		
Чанаргүй зээл / ЗТУБАХСан		
Чанаргүй зээл /1 -р зэрэглэлийн ӨХ		

Нэгдсэн үнэлгээ:

Тайлбар:

Гурав. Ашигт ажиллагаа

Банкны ашигт ажиллагааны чанарыг үнэлэхдээ хуримтлагдсан ашгаар өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх чадвар; ашигт ажиллагааны түвшин, хандлага болон тогтвортой байдал, ашигт ажиллагааны чанар болон эх үүсвэр; банк санхүүгийн бусад байгууллагын үйл ажиллагаатай харьцуулсан үйл ажиллагааны зардлын түвшин; ашигт ажиллагааны зах зээлийн эрсдлээс хамаарах хэлбэлзэл; эрсдлийн сангуудын зохистой түвшин, уламжлалт бус, гэнэтийн орлого зарлагаас хамаарах ашигт ажиллагааны хамаарал; орлогод үзүүлэх татварын нөлөө; төсөв төлөвлөгөө, түүний зохистой систем; удирдлагын мэдээллийн системийн зохистой байдал зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн асуулгын дагуу үнэлэлт дүгнэлт өгнө.

	Тийм	Үгүй
1. Ашигт ажиллагааны чанар		
а. Банк санхүүгийн байгууллагын зээлдэгчдийн дийлэнх хувь нь санхүүгийн хувьд хүчтэй, чадварлаг эсэх	-------/------	
б. Ашиг ихтэй боловч эрсдэл өндөр үйл ажиллагаа явуулах зээлдэгчдэд зээл олгохыг хязгаарладаг эсэх	-------/------	

в. Шинээр үүсгэн байгуулагдсан компаниудад зээл олгохоос татгалздаг эсэх -------/------

2. Ашигт ажиллагааны хандлага

а.Ашигт ажиллагааны хандлага сайжирч байгаа эсэх -------/------

б.Активын өгөөж нэмэгдэж байгаа эсэх -------/------

в.Өөрийн хөрөнгийн өгөөж нэмэгдэж байгаа эсэх -------/------

3. Хүүгийн цэвэр зөрүү

а.Хүүгийн цэвэр зөрүү тогтвортой, эсвэл сайжирч байгаа эсэх -------/------

б. Зээлийн хүүг тогтоохдоо эх үүсвэрийн зардлыг харгалзаж үздэг эсэх -------/------

в.Хүүгийн зөрүүг удирддаг эсэх -------/------

4. Зээлтэй холбогдолтой алдагдал

Муу зээлтэй холбоотой алдагдлыг холбогдох журмын дагуу удирддаг эсэх -------/------

5.Үйл ажиллагааны зардал

Банкны удирдлага нь үйл ажиллагааны зардлыг төсөвлөж, хянадаг эсэх -------/------

6.Эрсдлийн сангуудын хэмжээ, түвшин

Холбогдох сангуудын хэмжээ нь алдагдлыг хаахад хүрэлцэхүйц эсэх -------/------

7.Өөрийн хөрөнгийн өгөөж, ногдол ашиг

Ногдол ашгийн төлөлт нь өөрийн хөрөнгийн өсөлттэй уялдаж чаддаг эсэх -------/------

8. Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашгийн өсөлт нь активын өсөлтийг бий болгоход хүрэлцэхүйц эсэх -------/------

9. Шимтгэлийн орлого

Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа нь шимтгэлийн орлого бий болгох бүтээгдэхүүн үйлчилгээг дэмждэг эсэх -------/------

10. Цэвэр орлого

Ашигт ажиллагааны болон өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлтүүдийг тухайн бүлгийн дундажтай харьцуулахад зохистой эсэх -------/------

Банкны ашигт ажиллагааны чанарт үнэлгээ өгөхдөө дараах үзүүлэлтүүдэд 1-5 гэсэн үнэлгээ дүгнэлтийг өгнө. Үүнд:

1. Ашигт ажиллагааны чанар _____
2. Ашигт ажиллагааны хандлага _____
3. Хүүгийн цэвэр зөрүү _____
4. Муу зээл _____
5. Үйл ажиллагааны зардал _____
6. Эрсдлийн сангуудын хэмжээ, түвшин _____
7. Өөрийн хөрөнгийн өгөөж, ноогдол ашиг _____
8. Хуримтлагдсан ашгийн өсөлт _____
9. Шимтгэлийн орлого _____
10. Цэвэр орлого _____

Огноо Огноо Огноо

Татварын дараах цэвэр ашиг (ТДЦА) / Дундаж актив
ТД цэвэр үйл ажиллагааны орлого / Дундаж актив
ТДЦА / Дундаж өөрийн хөрөнгө (ДӨХ)
ТД цэвэр үйл ажиллагааны орлого / ДӨХ

Нэгдсэн үнэлгээ:

Тайлбар:

Дөрөв. Төлбөрийн чадвар

Банкны төлбөрийн чадварын чанарыг үнэлж дүгнэхдээ бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлт, бууралтын хандлага, тогтвортой байдал; богино хугацаат, хэлбэлзэл өндөртэй эх үүсвэрээс хамаарах хамаарал, энэхүү богино хугацаат эх үүсвэрээр урт хугацаат активыг санхүүжүүлсэн байдал; актив хөрөнгөд эзлэх хөрвөх чадвар сайтай активын хэмжээ, активыг борлуулах боломж; мөнгөний зах зээлд оролцох болон бусад эх үүсвэр татах чадвар, төлбөрийн чадварын хэрэгцээг хангах чадвар; банк санхүүгийн байгууллагын төлбөрийн чадвартай холбоотой бодлого, заавар журмын зохистой байдал, түүний хэрэгжилт, эх үүсвэрийн удирдлагын стратеги, удирдлагын мэдээллийн систем болон эх үүсвэр татах нөөц төлөвлөгөө; төлбөрийн чадварын эрсдлийг тодорхойлох, хэмжих, хянах болон ажиглах удирдлагын чадвар, тэнцлийн болон тэнцлийн гадуурх дансд дахь эх үүсвэрийн хэмжээ зэрэг үзүүлэлтийг харгалзаж энэ асуулгын дагуу тооцно.

	Тийм Үгүй
1. Төлбөрийн чадварын талаарх бодлого	
а.Төлбөрийн чадварыг хангах бодлого боловсруулж батлуулсан эсэх	-------/------
б.Эх үүсвэрийн эрсдлийн шинжилгээг хийдэг эсэх	-------/------
2. Бодлогын хэрэгжилт	
Өөрийн тодорхойлсон төлбөрийн чадварын бодлогыг хэрэгжүүлдэг эсэх	-------/------
3. Активын хөрвөх чадвар	
Банк санхүүгийн байгууллагын хөрвөх чадвар сайтай активын хэмжээ нь зохистой, хангалттай эсэх	-------/------
4. Бусад хүлээж болзошгүй үүрэг	
Банк санхүүгийн байгууллага нь зээлийн шугамтай эсэх	-------/------
5. Мөнгөний зах зээлд оролцох бололцоо	
Банк санхүүгийн байгууллага нь өөрийн хувьцааг хөрөнгийн зах зээл дээр арилжаалах бололцоотой эсэх	-------/------
6. Төлбөрийн чадварын хандлага	
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа нь зохистой эсэх, сайжирч байгаа эсэх	-------/------
7. Бусдаас авсан зээл, түүний хандлага	
Бусдаас авсан зээлийн хэмжээ зохистой эсэх	-------/------
8. Бусдаас худалдаж авсан эх үүсвэрээс хамаарах байдал	
Бусдаас худалдаж авсан эх үүсвэрээс хамаарал багатай эсэх	-------/------
9. Актив пассивын зөрүүгийн удирдлага	
Актив пассивын зөрүүгийн удирдлагын системийг ашигладаг эсэх	-------/------

10. Тогтмол хүүтэй активын хэмжээ
Тогтмол хүүтэй активын хэмжээ нь тогтмол хүүтэй пассивын хэмжээнээс бага эсэх -------/------
11. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэлбэлзэл
Хувьсах хүүтэй, хэлбэлзэл ихтэй бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд хяналт тавьдаг эсэх -------/------
12. Эх үүсвэрийн эргэн төлөгдөх хугацаа
Санхүүгийн тайлан тэнцлээр эх үүсвэр төлөгдөх хугацааг нэгдсэн байдлаар хянах бололцоотой эсэх -------/------
13. Актив хөрөнгийн эргэн төлөгдөх хугацаа
Санхүүгийн тайлан тэнцлээр активын төлөгдөх хугацааг нэгдсэн байдлаар хянах бололцоотой эсэх -------/------

Банкны төлбөрийн чадварын чанарт үнэлгээ дүгнэлт өгөхдөө дараах үзүүлэлтүүдэд 1-5 гэсэн үнэлгээ өгнө:

1. Төлбөрийн чадварын талаарх бодлого
2. Төлбөрийн чадварын бодлогын хэрэгжилт
3. Активын хөрвөх чадвар
4. Бусад хүлээж болзошгүй үүрэг
5. Мөнгөний зах зээлд оролцох оролцоо
6. Төлбөрийн чадварын хандлага
7. Бусдаас авсан зээл, түүний хандлага
8. Худалдаж авсан эх үүсвэрээс хамааралтай байх байдал
9. Актив пассивын зөрүүгийн удирдлага
10. Тогтмол хүүтэй активын хэмжээ
11. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэлбэлзэл
12. Эх үүсвэрийн эргэн төлөгдөх хугацаа
13. Актив хөрөнгийн эргэн төлөгдөх хугацаа

Огноо Огноо Огноо

Богино хугацаат хөрөнгө оруулалт / Нийт Актив
Харилцах, хадгаламж / Нийт актив
Цэвэр зээл / Нийт актив

Нэгдсэн үнэлгээ:

Тайлбар:

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 5 дугаар сарын 26 –ны өдрийн 311 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт (Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь иж бүрэн шалгалт хийж үнэлгээ, дүгнэлт өгөх журмын X хавсралт)

Мэдээллийн технологийн хяналт шалгалтын удирдамж

I. Мэдээллийн технологийн хяналт шалгалтын удирдамжийн зорилт

Энэхүү удирдамж нь санхүүгийн байгууллагын дотоод удирдлагын тогтолцоог мэдээллийн системийн эрсдэлийн хувьд Монголбанкнаас газар дээр хянан шалгахад Мэдээллийн технологийн хяналт шалгалтын зөвлөмжид тулгуурласан гарын авлага болоход гол зорилго нь оршино.

Санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны төрөл, цар хүрээ болон эрсдэлийг хянах аргачлал нь хоорондоо харилцан адилгүй байдаг учраас удирдлагын тогтолцоог нэгдсэн загвараар тодорхойлоход бэрхшээлтэй байдаг. Санхүүгийн байгууллага энэхүү удирдамжийг чиглэл болгон өөрийн байгууллагын онцлог, үйл ажиллагааны цар хүрээнд тохируулан компанийн дотоод журам болон бодлогыг удирдлагын зүгээс удирдан, боловсруулж, бизнесийн үйл ажиллагааны хэвийн, тогтвортой байдлыг хангах хэрэгтэй.

II. Мэдээллийн технологийн хяналт шалгалтын удирдамжийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс

Мэдээллийн технологийн удирдамж нь дотоод удирдлагын зорилтууд хэрэгжсэнийг дүгнэх материал болно. Энэ нь санхүүгийн байгууллагуудад шалгалтаар хамрах үзүүлэлтүүдийн түвшинг хангахыг үүрэг болгохгүй. Удирдамж нь тухайн байгууллагын онцлог шинж, үйл ажиллагааны цар хүрээг зохистойгоор харгалзан үзсэн байх хэрэгтэй.

Мэдээллийн системийн эрсдэлийг харгалзан дотоод удирдлагын тогтолцоог бүрэлдүүлж бий болгох хариуцлага нь санхүүгийн байгууллагын удирдлагад хамаарах бөгөөд энэхүү удирдамж нь түүний хариуцлагын гүйцэтгэлд чиглэгдэнэ. Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон гүйцэтгэх удирдлага (гүйцэтгэх захирал) нь санхүүгийн байгууллагын ерөнхий удирдлагын үйл ажиллагаанд чухал үүрэг, хариуцлагатай байх бөгөөд мэдээллийн системийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлэх үүрэг ч мөн гүйцэтгэх захиралд бий гэж ихэнхи тохиолдолд үздэг. Төлөөлөн удирдах зөвлөл гүйцэтгэх удирдлагад шаардлагатай эрх мэдлийг олгоогүй тохиолдолд энэхүү үүрэг захирлуудын зөвлөлд байна гэж үзнэ.

Санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо нь харилцан адилгүй байдаг. Санхүүгийн байгууллагын хариуцлагыг тодорхойлох үед дээд түвшний гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлага, удирдах албан тушаалтаны хэн нь хариуцлагыг хэрэгжүүлэх эрхтэйг анхаарах хэрэгтэй.

Гуравдугаар хэсэгт удирдах эрх бүхий албан тушаалтныг жишээ болгон авсан бөгөөд санхүүгийн байгууллага өөрийн онцлогт тохируулан түүнийг өөрчилж болно.

Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо хангалтгүй байгаа тохиолдолд захирлуудын зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын хооронд үйл ажиллагааны цар хүрээ болон эрх мэдлийн хэмжээний талаархи ойлголтод зөрөө байхгүй эсэхийг харгалзан үзсэний үндсэн дээр үүрэг хариуцлага тэдгээрийн хэнд ноогдож буйг тодруулах нь чухал юм.

III. Мэдээллийн технологийн хяналт шалгалтын зөвлөмжид тусгагдсан мэдээллийн технологийн хяналт шалгалтын ажлын талбар

1) Эрсдэлийн удирдлагын хяналт шалгалт. Банк нь эрсдэлийн удирдлагын хяналт шалгалтын хүрээнд дараахийг биелүүлдэг эсэхийг шалгана. Үүнд:

a) Гүйцэтгэх удирдлага (эсвэл гүйцэтгэх захирал)-ын хүлээх хариуцлага

1. Дээд түвшний гүйцэтгэх захирал (эсвэл гүйцэтгэх удирдлага) нь мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын бодлого (гүйцэтгэх захирал, түүний хариуцсан газар хэлтсийн үүрэг хариуцлага, мэдээллийн системийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, шалгах, хянах, бууруулах үйл ажиллагааны талаар бодлого)-ыг тодорхойлж, байгууллагын хэмжээнд нэгдсэн ойлголтод хүрсэн,

2. Дээд түвшний гүйцэтгэх захирал (эсвэл гүйцэтгэх удирдлага) нь системийн эрсдэлийн удирдлагад ач холбогдол өгч буй эсэх. Ялангуяа, мэдээллийн системийн эрсдэлийг хариуцсан гүйцэтгэх захирал нь эрсдэлийн удирдлагын нөхцөл байдлыг оновчтой дүгнэж, мэдээллийн системийн эрсдэлийн бодлогод тулгуурлан зохистой эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлэх тал дээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг,

3. Дээд түвшний гүйцэтгэх захирал (эсвэл гүйцэтгэх удирдлага) нь үйл ажиллагааны газар, хэлтэс тус бүр болон бүх салбарт дагаж мөрдвөл зохих дотоод журам болон ажил, үүргийн хуваарийг нэгдсэн журмаар танилцуулж, дагаж мөрдүүлэх тогтолцоог бүрдүүлсэн,

4. Дээд түвшний гүйцэтгэх захирал (эсвэл гүйцэтгэх удирдлага) нь мэдээллийн системийн эрсдэлийг байгууллагын хэмжээнд хариуцан ажиллах газар, хэлтсийг байгуулан, түүний үйл ажиллагааг явуулахад хангалттай мэдлэг, туршлагатай хүнийг хариуцлагатай албан тушаалтнаар томилсон,

5. Дээд түвшний гүйцэтгэх захирал (эсвэл гүйцэтгэх удирдлага) нь байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд холбогдох газар, нэгжийг оролцуулдаг эсэх? Тэдгээр газар, нэгж нь мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын газрын удирдлага дор нэгдэж чаддаг,

6. Дээд түвшний гүйцэтгэх захирал (эсвэл гүйцэтгэх удирдлага) эрсдэлийн удирдлагын нөхцөл байдлыг зөв шинжилж, банкны газар, нэгжээс ирсэн тайлан, судалгааны үр дүн, гадаад, дотоод аудитын дүгнэлт дээр үндэслэн эрсдэлийн удирдлагын үр өгөөжийг үнэлдэг эсэх? Тэдгээр мэдээлэл дээр тулгуурлан эрсдэлийн удирдлагын тогтолцоонд учирсан асуудал, сул тал зэрэг сайжруулах шаардлагатай зүйлс байгааг анхаарч үздэг,

7. Эрсдэлийн удирдлагын нөхцөл байдлын талаар хийсэн шалгалт, шинжилгээний үр дүнд үндэслэн гүйцэтгэх улирдлага мэдээллийн технологийн сайжруулах төлөвлөгөөг боловсруулж, түүнийг хэрэгжүүлсэн.

а) Байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцооны бүрдэлт

1. Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын газрыг хариуцсан албан тушаалтан нь мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын тодорхой үйл ажиллагаа (эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, шалгах, хянах, бууруулах ажиллагаа)-тай холбогдох дүрэм, журмыг (мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын журам) боловсруулсан,

2. Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын бодлого болон журам нь шаардлагатай тохиолдолд дахин боловсруулж, гүйцэтгэх удирдлагаар батлуулдаг,

3. Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын газрыг хариуцсан албан тушаалтан нь мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, туршлагатай мэргэжилтнүүдээр ажлын багаа бүрдүүлж, шаардлагатай эрх мэдлийг тэдэнд олгон, тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлдэг,

4. Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын газар мэдээллийн системийн ач холбогдол, сул талыг харгалзан, эрсдэлийг үнэлэх, тодорхойлох стандартыг (Цаашид үнэлгээний стандарт гэх) боловсруулж, шаардагдах газруудад мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын газарт үнэлгээний стандартын дагуу тайлагнахыг шаарддаг,

5. Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын газар нь үйл ажиллагааны салбар (тухайлбал санхүү, мэдээлэл, гадаад харилцаа, үнэт цаас, олон улс) тус бүрийн системийн эрсдэлийг үнэлэхээс гадна системийн ерөнхий эрсдэл (сүлжээ, компьютер тоног төхөөрөмж зэргийн эрсдэл)-ийг таньж, үнэлдэг,

6. Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын газар нь системийн хэрэглэгч болох газар, нэгж бие даан систем нэвтрүүлэх тохиолдолд учирч болох эрсдэлийг тодорхойлон үнэлдэг,

7. Системийн хэрэглэгчид замбараагүй байдлаар программ хангамж суулгах, хэрэглэхээс сэргийлж тэдгээрийг хянах удирдлага, хариуцах ажилтныг томилсон,

8. Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлага нь сүүлийн үеийн мэдээллийн технологи, санхүүгийн гэмт хэргээс үүсч болзошгүй эрсдэлийг таньж мэдэхэд хангалттай чадвартай,

9. Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын газраас өөрсдийн эрсдэлийн үнэлгээн дээр тулгуурлан бусад газар, нэгжийг эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авахуулж, түүний биелэлтэд хяналт тавьдаг,

10. Хууль, журамд заасантай банкны бодлого, үйл ажиллагаа (мэдээллийн системтэй холбоотой) зөрчилдөж байгаа эсэхийг хянадаг тогтолцоог бүрдүүлсэн,

11. Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын газрын хариуцсан ажилтан нь эрсдэлийн удирдлагын нөхцөл байдлын талаар тогтмол эсвэл шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх удирдлага болон үйл ажиллагааны эрсдэл хариуцсан эрсдэлийн удирдлагын газарт тайлагнадаг,

12. Мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын газрын хариуцсан ажилтан шаардлагатай үед мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын газрын үйл ажиллагааг хянаж, түүний удирдлагын тогтолцоо, дүрмийг дахин боловсруулдаг.

2) Системийн аудит. Дотоод аудитыг хийхэд банк дараах шаардлагыг биелүүлсэн эсэхийг шалгана. Үүнд:

a) Гүйцэтгэх удирдлагын (гүйцэтгэх удирдлага хариуцсан албан тушаалтан) хариуцлага

1. Дээд түвшний гүйцэтгэх захирал (эсвэл гүйцэтгэх удирдлага) нь шаардлагатай мэдлэг, ажлын туршлага, чадварыг эзэмшсэн боловсон хүчнийг системийн аудитыг хариуцсан газар хэлтэст ажиллуулж, тэдгээрт аудитын ажлыг гүйцэтгэхэд нь шаардлагатай эрх, нөөц бололцоогоор хангасан,

2. Системийн аудитын газрын бусад газар, нэгжээс хараат бус байдлыг хангаж, тус газрын ажилтнуудыг шалгагдаж байгаа газар, нэгжийн үйл ажиллагаанд оролцохоос (санхүүгийн болон бусад үйл ажиллагааны өгөгдлийг боловсруулах гэх мэт) сэргийлсэн тогтолцоог гүйцэтгэх удирдлага бүрдүүлсэн,

b) Системийн аудитын үйл ажиллагаа, арга барил

1. Системийн аудитын газар нь хянан шалгах шаардлагай зүйлсийг оновчтой байдлаар тодорхойлж, түүний хүрээ, шалгах үе шатуудыг тодорхойлсон дотоод аудитын зөвлөмжийг боловсруулж, гүйцэтгэх удирдлагаар батлуулдаг,

2. Системийн аудитын газар мэдээллийн системийн эрсдэлийн удирдлагын

нөхцөл байдлыг мэдэрч, аудитын үйл ажиллагаанд шаардлагатай нөөц бололцоог харгалзан аудитын давтамж болон нарийвчлалыг тогтоосоны үндсэн дээр аудитыг үр ашиг, өндөр бүтээмжтэй хэрэгжүүлдэг,

3. Аудитаар шалгуулсан газар, нэгж системийн аудиторын илрүүлсэн алдаа, зөрчлүүдийг ач холбогдлын түвшнээр ангилсны үндсэн дээр түүнийг сайжруулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж, хэрэв шаардлагатай бол сайжруулах ажлын төлөвлөгөөг боловсруулан ажилладаг эсэх? Аудитын газраас шалгагдсан газрын сайжруулалтын явцыг дахин хянаж, дараагийн системийн аудитын төлөвлөгөөнд тусгасан.

3) Мэдээллийн системийн төлөвлөлт, удирдлага. Банкны мэдээллийн системийн төлөвлөлт, удирдлагын хүрээнд дараах шаардлагыг хангасан эсэхийг шалгана. Үүнд:

a) Бизнесийн стратеги болон мэдээллийн технологийн стратеги хоорондоо нийцсэн байдал

1. Бизнесийн стратеги дээр тулгуурлан мэдээллийн системийн стратегийг тодорхойлж, гүйцэтгэх удирдлагаар батлуулсан,

2. Мэдээллийн системийн стратегид компьютержүүлэлтийн үндсэн бодлого, системийн боловсруулалтын төлөвлөгөөнд зэрэглэл тогтоох аргачлал, системийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, боловсон хүчний төлөвлөлт, аутсорсингийн төлөвлөлт зэргийг тодорхой тусгасан,

3. Бизнесийн орчны өөрчлөлттэй уялдуулан мэдээллийн системийн стратегид засвар хийдэг тогтолцоо бүрдүүлсэн.

b) Мэдээллийн системийн төлөвлөгөөний боловсруулалт, хэрэгжилт

1. Мэдээллийн системийн стратегид үндэслэсэн мэдээллийн системийн төлөвлөгөө (богино, дунд, урт хугацааны төлөвлөгөө) боловсруулсан эсэх? Мэдээллийн системтэй холбоотой үйл ажиллагаа (мэдээллийн ситемийн хөрөнгө оруулалт болон бусад үйл ажиллагаа) мэдээллийн системийн төлөвлөгөөн дээр суурилж хийгддэг,

2. Мэдээллийн системийн төлөвлөгөө (дунд болон урт хугацааны) тогтмол эсвэл шаардлагатай тохиолдолд дахин боловсруулж, гүйцэтгэх удирдлагаар батлуулдаг,

3. Мэдээллийн системийн богино хугацааны төлөвлөгөө, түүний биелэлт улирал тутам эсвэл шаардлагатай үед хянадаг,

4. Мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг байгууллагын түвшинд хангахын тулд, байгууллагын дотоодод мэдээлэл дамжуулах холбоог хангах хороог байгуулж, нийт банкны бүх газар, нэгжийг оролцуулж чаддаг,

5. Богино хугацааны мэдээллийн системийн төлөвлөгөөний хэрэгжилтийн нөхцөл байдлыг тогтмол хянаж, банкны мэдээллийн системийг нэгдсэн байдлаар

хариуцдаг банкны мэдээллийн системийн хороо зэрэг нэгжид тайлагнадаг.

c) Мэдээллийн системийн үйл ажиллагаа, үнэлгээ

1. Мэдээллийн системийн газрын (цаашид мэдээллийн технологийн газар гэх) ажилтан бүрийн эрх, үүрэг тодорхойлогдож, тодорхой үүргийг салгаж, ангилсан,

2. Хэрэглэгчдийн мэдээллийн системийн үр ашигтай хэрэглээг дэмжих тогтолцоо (сургалт, дадлага, хэрэглэгчийн тусламж, системийн ашиглалтын хүрээг тэлэх нэгж зэрэг) –ийг бүрдүүлж чадсан,

3. Суулгасан мэдээллийн системийг үнэлэх ажиллагаа (хэрэглэгчдийн үнэлгээ, зардал болон үр дүнгийн харьцаа) явагддаг,

4. Мэдээллийн системтэй холбогдох төсөл бүрийн хувьд эсвэл нэгдсэн байдлаар төсөв болон үр дүнг тооцоолон, шаардлагатай үед төсвийн шинжилгээний үр дүнд үндэслэн арга хэмжээ авдаг.

4) Мэдээллийн аюулгүй байдал. Банкны мэдээллийн нууцлалын бодлго, үйл ажиллагаа нь дараах шаардлагыг хангасан эсэхийг шалгана. Үүнд:

a) Байгууллагын хэмжээний аюулгүй байдлын удирдлагын систем

1. Аюулгүй байдлын бодлого (Байгууллагын мэдээллийн хөрөнгийг зүй зохистой хадгалах үндсэн бодлогод а/ Хамгаалагдах шаардлагатай мэдээллийн хөрөнгө б/ Хадгаламж, хамгаалах шаардлага, в/ Хариуцаж ажиллах хүн зэргийг тодорхойлно.)–г тодорхойлж, гүйцэтгэх удирдлагаар батлуулсан,

2. Аюулгүй байдлын бодлого, стандарт (аюулгүй байдлын бодлогыг илүү нарийвчилсан байдлаар тодорхойлсон баримт бичиг)-ыг банкны бүх ажилтан танилцуулсан эсэх, шаардлагатай тохиолдолд дахин боловсруулалт хийгдсэн,

3. Банкны аюулгүй байдлын удирдлагыг төвлөрүүлэн хэрэгжүүлэгч албан тушаалтан томилогдсон эсэх, хэрэв байгаа бол уг хүн нь мэдээллийн системийн төлөвлөлт, боловсруулалт, үйл ажиллагаа, тогтвортой байдал зэрэг аюулгүй байдлын бүх удирдлагыг хариуцдаг,

4. Аюулгүй байдлын удирдлага хариуцсан ажилтан банкны сүлжээ, өгөгдөл, системүүдийн аюулгүй байдлын асуудлыг нэгтгэх тогтолцоо бүрдүүлсэн,

5. Мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд мэдээллийн аюулгүй байдлын хороо зэрэг байгууллагын дотоод нэгжээр дамжуулан мэдээллийн хөрөнгөтэй харьцдаг газар, нэгж бүрт аюулгүй байдлын администратор томилсон.

b) Нэгдсэн аюулгүй байдлын удирдлага

1. Барилга, тоног төхөөрөмжийн аюулгүйн стандарт (тухайлбал компьютерийн төвд орох, гарах дамжлага) боловсруулагдан, түүн дээр үндэслэн барилга, тоног төхөөрөмжийн ашиглалт болон хамгаалалт хийгдсэн,

2. Системийн доголдол, гэмтэл, гэмт хэргийн үед гүйцэтгэх ажил (тайлагнах, авах арга хэмжээ) төлөвлөгдөж, онцгой байдал үүссэн тохиолдолд түргэн шуурхай арга хэмжээ авах бололцоо бүрдсэн.

c) Өгөгдлийн аюулгүй байдал

1. Ямар төрлийн мэдээлэл нууцын зэрэглэлд орохыг тодорхойлсон эсэх? Нууцын зэрэглэлээс хамааран мэдээлэл тус бүрийн ашиглалт, хадгалалтын талаархи ойлголт тодорхой болж чадсан,

2. Хэрэглэгчийн мэдээллийг хамгаалах ажиллагааг хамаарч өгөгдлийн аюулгүй байдлын хүрээнд авч үздэг,

3. Хувийн мэдээллийн хадгалалт, хамгаалалтын бодлогыг тодорхойлсон.

d) Мэдээллийн системийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал

1. Мэдээллийн систем, санах ойн медиатай холбоотой тоног төхөөрөмж, багажийг (хэрэглэгчийн компьютер, сервер гэх мэт) хадгалж, хамгаалах үйл ажиллагаа тодорхойлогдсон,

e) Системийн хандалтад тавих хяналт

1. Системийн хандалтад тавих хяналтын талаар баримтлах бодлого болон процедурыг тодорхойлж өгсөн,

2. Системд нэвтэрч байгаа хандалт бүрийг тэмдэглэн, хянаж, шинжилгээ хийдэг,

3. Зүй бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэхийн тулд, гүйцэтгэж буй ажил үүргийн агуулга болон холбогдож буй арга хэрэгсэлээс хамаарч тухайн системд нэвтэрч байгаа этгээд нь эрх бүхий этгээд мөн эсэх эсвэл эрх бүхий терминалаас холбогдож буй эсэхийг тодруулах тогтолцоо байдаг.

f) Системд хор учруулах программ (зөвшөөрөлгүй программ хангамжийн хэрэглээ)-тай тэмцэх арга хэмжээ

1. Компьютерийн вирус зэрэг аюултай программ хангамжийн халдлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг эсэх; Мөн халдлагыг илрүүлж, вирусыг устгах тогтолцоо бүрдүүлсэн,

2. Зөвшөөрөлгүй программ хангамжийг хэрэглэхээс сэргийлэх арга хэмжээ авдаг.

5) Системийн боловсруулалт. Мэдээллийн системийг боловсруулахдаа дараах шаардлагыг банк биелүүлж ажилладаг эсэхийг шалгана. Үүнд:

а) Системийн боловсруулалтын удирдлага

1. Системийн боловсруулалттай холбоотой байгууллагын дүрэм, журам батлагдаж гарч, тухайн нөхцөл байдалд нийцүүлж дахин боловсруулалт хийдэг эсэх,

2. Систем боловсруулах стандарт(программ боловсруулалтын аргачлал болон баримт бичгүүд г.м) батлагдаж гарсан,

3. Боловсруулалтын төлөвлөгөөг (үүнд нэгэнт боловсруулсан системд засвар өөрчлөлт оруулах төлөвлөгөө багтана) хэлэлцэж батлуулах тухай журам гаргасан,

4. Мэдээллийн Технологийн газар/хэлтсийн удирдах албан тушаалтан нь системийн боловсруулалтын ажиллагсадаа шаардлагатай сургалтад хамруулж, дадлагажуулах болон ажиллах таатай орчныг бүрдүүлж хүний нөөцийн уян хатан, зөв зохистой бодлогыг хэрэгжүүлдэг,

5. Мэдээллийн Технологийн газар/хэлтсийн удирдах албан тушаалтан нь системийн үйл ажиллагаа болон системийн боловсруулалт хариуцсан ажилтнуудын хооронд албан үүргийнх нь хувьд зохих тусгаарлалтыг хийсэн.

b) Систем боловсруулалтын үйл явц

1. Хэрэглэгч буюу захиалагч газар/нэгж/ нь системийн шинжилгээ хийх үе шатанд оролцдож, хэрэглэгч газар/хэлтсийн зүгээс системийн ерөнхий шаардлагыг тодорхойлдог,

2. Системийн боловсруулалтын төсөл бүрийн хувьд түүнийг орлох боломжтой системийг бий болгож, техникийн боломж бололцоо, хүний нөөц, тоног төхөөрөмж, зарцуулагдах хугацаа зэргийг үнэлж гаргадаг,

3. Боловсруулсан програм хангамжийг нэвтрүүлэх журам батлагдаж гарсан,

4. Системийг боловсруулахдаа, хянан шалгах үйл ажиллагааг дэмжиж ажилладаг системийн функцүүдийн талаар авч үзсэн,

5. Боловсруулж байгаа системийн туршилтыг төлөвлөж, төлөвлөсний дагуу бүрэн явуулдаг эсэх. Хэрэглэгч буюу захиалагч газар/нэгж тестийн үйл явцад оролцдог,

6. Систем боловсруулалт болгоны хувьд системийн шилжүүлэлт хариуцсан ажилтан томилдж, шилжүүлэлт хийхэд холбогдох газар/нэгжийн гүйцэтгэх үүрэг, хариуцлага болон шилжүүлэлтийг хийх шийдвэрийн стандартыг тодорхой журамд тусгасан.

c) Төслийн удирдлага/Ажлын хэсгийн зохион байгуулалт

1. Боловсруулалтын төсөл бүр дээр төслийн удирдагчийг томилдж, удирдах ажилтны зүгээс системийн онцгой, ач холбогдол бүхий хэсгүүдийн гүйцэтгэлийн явцыг хянадаг,

2. Төслийн гүйцэтгэлийн товъёог, өртөг, чанарыг үр ашигтайгаар сайн зохион байгуулсан төслийн төлөвлөгөө боловсруулдаг,

3. Төслийн удирдагчаар дадлага, туршлага, мэдлэг чадварыг нь харж, тохирсон хүнийг томилдог,

4. Боловсруулалтын ажил дуусанаар төслийн гүйцэтгэлийг шалгаж, үнэлгээ өгч, төслийн мэдээллийг хадгалан, түүнийг ашиглан, төслийн гүйцэтгэлийн үнэлгээний дүгнэлтийг мэдээллийн технологийн газар/хэлтэс болон хэрэглэгч газар/хэлтсийн удирдах албан

тушаалтанд тайлагнадаг.

6. Системийн үйл ажиллагаа. Мэдээллийн системийг үйл ажиллагааг хэвийн, найдвартай явуулахад дараах шаардлагыг банк биелүүлж ажилладаг эсэхийг шалгана. Үүнд:

a) Системийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

1. Системийн үйл ажиллагааны тухай стандарт болон журам батлагдаж, түүний дагуу үйл ажиллагааг шалгадаг,

2. Системийн үйл ажиллагааны хэсгийг ажил үүргээр нь зохих тусгаарлалтыг хийдэг (Үүнд ажиллагсад нь боловсруулалтын ажилд оролцохгүй байх, хэрэглэгчийн үйлдлүүдийг хийхгүй байх),

3. Системийн операторуудын ажил үүргийг зөв зохистой байдлаар хуваарилсан байдал. Ажилтны ур чадварыг нэмэгдүүлэх болон ёс суртахууныг өсөн нэмэгдүүлэх үүднээс шаардлагатай сургалтаар хангасан болон ажиллах орчны нөхцөлийг сайжруулсан.

b) Операторын үйл ажиллагааны удирдлага

1. Операторын үйл ажиллагаа нь тодорхой батлагдаж гарсан ажлын удирдамж болон төлөвлөгөөн дээр үндэслэж явагддаг,

2. Операторын үйл ажиллагааны протокол хөтлөгддөг эсэх. Уг протоколыг үйл ажиллагааны хэсгийг хариуцсан удирдах албан тушаалтан нь урьчилан тодорхойлсон өгөгдлийн дагуу нягталж, шалгадаг,

3. Үйлдлийн системд хяналт тавигддаг,

4. Чухал шаардлагатай файлууд (өгөгдлүүд болон програм хангамж)-ыг нөөцлөн, түүний хадгалалтын журмыг тогтоодог,

5. Системийн өгөгдлийг ашиглах (системийн туршилтад ашиглах, санхүүгийн аудит бусад тохиолдолд ашиглах) журам гаргасан,

6. Нөөц файлуудын хадгалалт, хамгаалалтын талаар хангалттай түвшинд анхаарч үзсэн (хэсэгчилэн салгаж хадгалдаг, банкнаас зайтай газар нэгтгэн хадгалдаг г.м),

7. Системийн үйл ажиллагааны доголдлын үед авах арга хэмжээний тухай журам батлагдаж гарч, системд доголдол үүссэн тохиолдолд түүний шалтгааныг тодруулж, шаардлагатай арга хэмжээг авдаг,

8. Системийн аутсорсинг хийгддэг компани дээр үүссэн гэмтлийн хувьд ч мөн тайлагнах тогтолцоо бүрдсэн,

9. Бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх ноцтой гэмтэл үүссэн тохиолдолд, мэдээллийн системийн эрсдлийн удирдлагын газар болон холбогдох салбар нэгжтэй хамтран асуудлыг шийдвэрлэхээр ажиллан,гүйцэтгэх удирдлагад тайлагнах нөхцөл бололцоо бүрдсэн,

10. Компьютерийн програм хангамжийг бүртгэх журам батлаж, бүртгэлийг хариуцсан албан тушаалтныг томилсон,

11. Системийн үйл ажиллагаанд ашиглагддаг тоног төхөөрөмжийг эзэмшиж, удирдах тухай журам болон хариуцах ажилтанг томилсон,

12. АТМ машиныг удирдаж, ажиллуулах тухай журам гаргасан,

7. Системийн ашиглалт. Мэдээллийн системийн зохистой ашиглалтыг бүрдүүлэхийн тулд дараах шаардлагыг банк биелүүлж ажилладаг эсэхийг шалгана. Үүнд:

1. Системийг ашиглаж байгаа ажилтнууд болон хэрэглэгчийн терминалийн тоо нь хэрэглэгч газар/хэлтсийн үйл ажиллагааны цар хүрээтэй нийцүүлсэн, системийг ашиглаж хэрэглэгчдэд зориулж сургалт явуулдаг байдал,

2. Өдөр тутмын үйл ажиллагааны журам болон гарын авлагууд нь сүүлийн хувилбарын дагуу шинэчилэж, эдгээр гарын авлага болон журамын агуулгыг хэрэглэгчдэд хүргэж танилцуулсан байдал,

3. Системийн тасалдал доголдлыг арилгах, засч залруулах дадлага хийдэг,

4. Гэнэтийн ослын болон гэмт халдлагын тухай дохио өгөх тогтсон систем ажилладаг эсэх, түүндээ дадлагажуулсан,

5. Чухал бичиг баримтуудтай холбоотой журмыг баталж мөрддөг,

6. ID картын ашиглалтын талаар зааварчилгаа байдаг эсэх болон хэрэглэгчдэд аюулгүй байдлын талаар анхааруулга, сануулга өгдөг,

7. Мэдээллийн системд холбогдож ажилладаг терминал болон компьютерүүд дээр үүргээ урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэн ашиглалтын хязгаарыг тогтоож өгсөн.

8. Оролт/Гаралттай холбоотой үйл явц. Мэдээллийн системийн оролт, гаралт, өгөгдөл, тайланг дараах шаардлагыг банк биелүүлсэний үндсэн дээр боловсруулдаг эсэхийг шалгана. Үүнд:

а) Оролт/Гаралтын үйл явц

1. Гүйлгээ хуваарилах, засах, батлах тухай журам гаргасан,

2. Гадны байгууллагатай өгөгдөл солилцох тохиолдолд шалгах функц болон өөр бусад асуудлаар урьдчилж тохирдог,

3. Оролтын өгөгдлийг(орж ирж байгаа гүйлгээ) хадгалдаг,

4. Гүйлгээний хуулгыг боловсруулах, засах үйл ажиллагаа болон гүйлгээг шивэх үйл ажиллагааг ажил, үүргийн хуваариар тусгаарлаж өгсөн.

5. Системд хийгдэж байгаа онцгой чухайл гүйлгээ болон гүйлгээтэй холбоотой үйл ажиллагааны талаар протокол бичигддэг эсэх, мөн ямар нэгэн зохицуулагчийн зүгээс үүнийг хянаж, шалгадаг,

6. Системээс хэвлэж авсан мэдээлэлийг тараах, хадгалах, устгах журам гаргасан,

7. Системийн боловсруулагдсан өгөгдөлд хандах хандалтуудын эрхийг зохицуулсан,

8. Боловсруулагдсан өгөгдлийн бүрэн бүтэн байдал, үнэн зөв эсэхийг тогтмол шалгадаг.

b) Өгөгдлийн боловсруулалт

1. Орж ирж байгаа өгөгдлийн үнэн зөвийг шалгадаг журам байдаг эсэх. Энэ нь системийн функц болж суугдсан,

2. Системээс гарч байгаа мэдээлэлийн шинжилгээг хийдэг,

3. Алдаатай өгөгдөлд засвар хийх журам байдаг эсэх. Мөн гарсан алдааг тэмдэглэн, шалтгаанд нь дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг авдаг.

9. Сүлжээ

a) Сүлжээний менежмент

1. Сүлжээний зохицуулагчаар ажилтан томилсон,

2. Сүлжээний удирдлагын систем, түүнтэй холбоотой журам (сүлжээний зохион байгуулалт болон ашиглалтын зөвшөөрөл авах тухай дотоод дүрэм, журамд тусгаж, холбогдох хүмүүст таниулж мэдүүлснээр сүлжээг аюулгүй, сааталгүй ажиллуулах тогтолцоо) байгаа.

3. Сүлжээний тасалдал, доголдлын эсрэг авах арга хэмжээ бэлтгэгдсэн байдал.

b) Нууцлалын менежмент

1. Сүлжээний зохицуулагч буюу эрх бүхий албан тушаалтны зүгээс сүлжээний тоног төхөөрөмжтэй ажиллах эрхийг хязгаарлаж, зохицуулсан,

2. Гадаад болон дотоод сүлжээний зөвшөөрөлгүй хандалтаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хэвийн байдалд нь оруулах арга хэмжээ авдаг эсэх. Урьдчилан сэргийлэх систем(илрүүлэх, хэвийн байдалд нь оруулах арга хэмжээг хамрана)-ийг гуравдагч этгээдээр үнэлүүлсэн,

3. Серверийн программ хангамж, контент хэлний талаархи аюулгүй ажиллагааны мэдээллийг цуглуулдаг эсэх. Мөн тэдгээр аюулгүйн ажиллагааны талаархи мэдээллийг харгалзан арга хэмжээ авдаг.

c) Интернетийн ашиглалт

1. Интернет (вэб, мэйл) ашиглалтын журмыг батлан, ажиллагсдад таниулж, хэрэгжүүлдэг,

2. Имэйлийг ажлын гүйцэтгэлийн нотолгоо болгон хадгалан, түүний ашиглалтад хяналт тавьдаг,

d) Электрон банк

1. Электрон банкны данс нээх болон гүйлгээ хийх үед хэрэглэгчийг таних зохих үйл явц явагддаг,

2. Хэрэглэгч болон санхүүгийн байгууллага тус бүрийн хувьд хууль бус гүйлгээг ялган таних ямар нэгэн функц системд бүрдсэн,

3. Хууль бус гүйлгээ болох нь танигдсан тохиолдолд авах ёстой арга хэмжээ тодорхой байдаг.

4. Электрон банкны эрсдлийн тухай хэрэглэгчдэд анхааруулсан зүйл байдаг,

5. Хэрэглэгчийн санал, гомдол, асуудлыг хүлээн авч ажилладаг,

6. Электрон банкны үйлчилгээний агуулга болон банкны санхүүгийн үйл ажиллагааны талаархи мэдээллийг вэб хуудас зэргийг ашиглан нээлттэй тавьдаг,

10. Системийн хөрөнгө, нөөцийн удирдлага. Мэдээллийн системийн хөрөнгийн бүртгэл, удирдлагад дараах шаардлагыг банк ханган ажилладаж байгаа эсэхийг шалгана. Үүнд:

a) Хөрөнгийн удирдлага

1. Хөрөнгийн зохицуулалтын талаар тодорхой стандарт байдаг,

2. Програм хангамж болон техник хангамжийн хөрөнгийн бүртгэлийг хөтөлж, бодит хөрөнгөтэй нь тулган шалгах ажлыг тогтмол явуулдаг,

3. Програм хангамжийн лицензийг тогтмол тулгаж, шалгадаг.

b) Багтаамж болон чанарын менежмент

1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний журмын дагуу техник хангамжийн үнэлгээг хийх төлөвлөгөө гаргадаг,

c) Өгөгдлийн сангийн менежмент

1. Өгөгдлийн сангийн менежментийг(өгөгдлийн сангийн загварчилгаа, ажиллагаа болон бусад) хийх тухай журам батлагдсан,

2. Өгөгдлийн сангийн зохицуулагч нь системийн боловсруулалтын болон үйл ажиллагааны хэсгийн ажлаас тусгаарлагдсан байдаг,

3. Урьдчилж бэлдсэн заавар дээр үндэслэж өгөгдлийн сангийн нөөцлөлт болон сэргээлтийн журмыг батлан, тогтмол дадлага хийдэг,

d) Сайжруулах нэмэлтийн (patch) менежмент

1. Нэмэлт сайжруулалтыг сонгож ашиглах тухай журам батлагдсан.

11. Аутсорсинг

a) Аутсорсингийн төлөвлөгөөний боловсруулалт

1. Мэдээллийн системийн стратегитэй нийцүүлэн дэс дараатайгаар аутсорсинг хийх зориулалттай аутсорсингийн төлөвлөлтийн журам гаргасан.

b) Аутсорсингийн компанийг сонгон шалгаруулах

1. Аутсорсингийн компанийг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан, түүнийхээ дагуу сонгон шалгаруулалтыг явуулдаг,

2. Аутсорсингийн компанийг шийдвэрлэх явцад, шийдвэрийг хариуцсан албан тушаалтан баталж, оролцогч талууд хүлээж авсан,

3. Аутсорсингд шаардлагатай нөхцөлүүдээр(үүнд үйлчилгээний нөхцөл орно) хангаж өгөх тухай 2 тал харилцан зөвшилцсөн,

c) Аутсорсинг хийх гэрээ байгуулах

1. Аутсорсингийн гэрээнд тусгах шаардлагатай зүйлсийг стандартчилан тогтоон, гэрээний агуулгыг боловсруулах явцад түүнийг харгалзан үздэг,

2. Гэрээг байгуулахын өмнө хуулийн газар/хэлтэс шалгаж холбогдох албан тушаалтнаар батлуулсан.

d) Нэгэнт хийгдэхээр болсон аутсорсингийн менежмент

1. Аутсорсийн системийн төлөвлөлт, загварчилгаа, боловсруулалт, тестийн ажлын үе шатанд аутсорсинг авч байгаа байгууллагын хэрэглэгч тал нь шалгалт, тестчилэлийг хийж оролцдог (Бүртгэлийн системийн хувьд санхүү, бүртгэлийн газарын хариуцсан ажилтан гэсэн үг),

2. Аутсорсингийн компанийн зүгээс үйл ажиллагааны тайланг тогтмол гаргуулан авч, агуулгын тодруулгыг хийдэг,

3. Аутсорсингийн компанид шаардлагатай тохиолдолд он-сайт болон офф-сайт шалгалтыг явуулдаг,

12. Онцгой байдлын төлөвлөгөө

a) Мэдээллийн системийн нөөц төлөвлөгөөний боловсруулалт

1. Гамшигийн болон бусад гэнэтийн тохиолдлоос болж мэдээллийн систем нь хэвийн ажиллах боломжгүй болсон үед зориулан онцгой байдлын төлөвлөгөөг хийж, үүнийг дахин шинэчилдэг,

2. Онцгой байдлын төлөвлөгөөг боловсруулах болон дахин боловсруулах үед Мэдээллийн технологийн газар/хэлтсээс гадна хамааралтай ажилладаг санхүү бизнесийн газар/нэгж оролцож, энэ төлөвлөгөөг удирдлагаар батлуулдаг,

3. Онцгой байдлын төлөвлөгөө нь анхан шатны хариу арга хэмжээ, ажил хийгдэх хугацааны туршид авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ болон бүрэн сэргээлтийг төв байр, салбарууд болон тооцооны төвүүд тус бүр дээр хэрхэн хийх журмыг тусгасан,

4. Онцгой байдлын төлөвлөгөөнд гадаад системд үзүүлэх нөлөө болон хэрэглэгчидэд үзүүлэх нөлөөг харгалзан үзэж боловсруулсан,

5. Компьютерийн гэмтэл болон компьютерийн гэмт халдлагуудыг сайтар бодолцож, үүнд бэлтгэж, асуудал үүссэний дараа хэвийн ажиллагааг шалгах үзүүлэлтүүдийг боловсруулсан,

6. Онцгой байдлын төлөвлөгөөний дагуу нийт ажиллагсдад байнгын болон дахин давтагдах сургалт, дадлага хийдэг,

7. Сургалт, дадлагын үр дүн түүнд өгсөн үнэлгээг удирдах албан тушаалтанд тайлагнаж танилцуулдаг,

b) Болзошгүй гэмт хэрэг, ослын үеийн бэлэн байдал

1. Мэдээллийн системтэй холбоотой гэмт хэрэг болон ослын талаар анхаарч, түүнээс сэргийлэх бүрэн арга хэмжээ авсан байдал, хэрэв авч хэрэгжүүлдэг бол үүнд гэмт хэрэг, ослын шалтгааны тодруулах ажиллагаа багтсан эсэх,

13. Баримтжуулалт

а) Системийн ашиглалт, үйл ажиллагаа, боловсруулалтыг баримтжуулах үйл ажиллагаа

1. Баримтжуулалтын стандарт(баримтжуулалтын бодлого, боловсруулалтын аргачлал, хуваарилан тараах аргачлал, шинэчлэх аргачлал, хадгалах аргачлал болон устгах аргачлал г.м) байдаг,

2. Системийн боловсруулалтын төлөвлөгөөнд системийн операторууд болон хэрэглэгчдэд зориулсан бичиг баримтыг боловсруулах тухай бичиг баримтжуулах төлөвлөгөө багтдаг,

3. Нууцын зэрэглэл бүхий баримт бичгийг хамгаалсан байдал (нууцын зэрэглэлээс хамаарсан хадгалалтын тогтолцоо) хангалттай.